



Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг

**ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,  
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР**



# Газрын нэгдмэл сангийн 2017 оны УЛСЫН НЭГДСЭН ТАЙЛАН







Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг

**ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,  
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР**

# Газрын нэгдмэл сангийн 2017 оны УЛСЫН НЭГДСЭН ТАЙЛАН

Улаанбаатар хот  
2018 он



#### ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН 2017 ОНЫ УЛСЫН НЭГДСЭН ТАЙЛАН

Хянан тохиолдуулсан:

Б.Галмандах – КХ-ийн дарга

Эмхэтгэсэн:

Х.Энхжаргал – КХ-ийн ахлах мэргэжилтэн

Тайлан гаргасан:

Х.Энхжаргал – КХ-ийн ахлах мэргэжилтэн

Х.Оюунбаяр – КХ-ийн ахлах мэргэжилтэн

Ж.Баянмөнх – КХ-ийн мэргэжилтэн

Э.Эрдэнэбаатар – КХ-ийн мэргэжилтэн

С.Өлзийбуян – КХ-ийн мэргэжилтэн

Б.Урантөгс – КХ-ийн мэргэжилтэн

Ж.Баянмөнх – КХ-ийн мэргэжилтэн

Н.Мөнхөө – ГЗБХ-ийн ахлах мэргэжилтэн

Р.Отгончимэг – ГЗБХ-ийн мэргэжилтэн

Г.Мөнхзул – ССМХ-ийн ахлах мэргэжилтэн

О.Дөлгөөнтуул - ЗУХАГ-ын ахлах мэргэжилтэн

Б.Оюуннасан - ЗУХАГ-ын ахлах мэргэжилтэн

# АГУУЛГА

<b>Оршил</b>	<b>6</b>
<b>1. ТАЙЛАНТ ОНД ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ТАЛААР ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ</b>	<b>7</b>
1.1. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас хэрэгжүүлсэн томоохон ажлууд	7
1.1.1. Газрын талаарх хууль тогтоомж, үндэсний хөтөлбөр, газрын харилцааны салбарт хийгдэх ажлуудын техник, эдийн засгийн үндэслэл, төсвийн тооцоо, танилцуулгыг боловсруулах ажлын хүрээнд:	7
1.1.2. Салбарын гадаад болон дотоод хамтын ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх ажлын хүрээнд:	9
1.1.3. Агентлагийн үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх зорилгоор тус газрын харъяа орон нутгийн байгууллагуудын үйл ажиллагаанд дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, байгууллагын үйл ажиллагааг санал зөвлөмжөөр дэмжих ажлын хүрээнд:	10
1.1.4. Инженер хайгуул, мониторингийн чиглэлээр:	10
1.1.5. Газар зохион байгуулалтын төлөвлөлтийн чиглэлээр:	14
1.1.6. Кадастрын чиглэлээр:	17
1.1.7. Орон зайн өгөгдөл, мэдээллийн чиглэлээр:	24
1.1.8. Мэдээллийн технологийн чиглэлээр:	26
1.2. Газрын харилцааны салбарын хүний нөөцийн судалгаа	27
1.2.1. Нийслэл, дүүргийн Газрын алба	28
1.2.2. Аймгийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрууд	32
1.2.3. Сумдын газрын даамлууд	36
1.3. Газрын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийн талаар хийсэн хяналт, шалгалт	39
1.4. Өргөдөл, хүсэлт, тэдгээрийн барагдуулалтын судалгаа	42
1.5. Газрын маргаан, түүнийг шийдвэрлэсэн байдал	45
1.6. Газар эзэмших эрх болон өмчийн газраа банк, санхүүгийн байгууллагад барьцаалсан байдлын тайлан	51
1.7. Газрын зах зээлийн тойм	56
1.8. Газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтын талаарх мэдээ, тайлан	63
1.9. Газрын кадастрын судалгаа, хэмжил, зураглал	69
1.10. Газар зохион байгуулалтын 2017 оны төлөвлөгөөний хэрэгжилт, 2018 оны төлөвлөгөө	71
1.10.1. Газар зохион байгуулалтын 2017 оны төлөвлөгөөний хэрэгжилт	71
1.10.2. Газар зохион байгуулалтын 2018 оны төлөвлөгөө	76
1.11. Сууц өмчлөгчдийн холбоонд ашиглуулж буй газрын тайлан	78
<b>2. ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН ТАЙЛАН</b>	<b>80</b>
2.1. Газрын нэгдмэл сангийн үндсэн ангилал, газар ашиглалтын төрөлд гарсан өөрчлөлт, шилжилтийн үндэслэл /Маягт ГТ-1, 5/	80
2.1.1. Хөдөө аж ахуйн газар	82
2.1.2. Хот, тосгон, бусад суурины газар	84
2.1.3. Зам, шугам сүлжээний газар	86
2.1.4. Ойн сан бүхий газар	87
2.1.5. Усны сан бүхий газар	87
2.2. Улсын тусгай хэрэгцээний газар /МАЯГТ ГТ-4/	88
2.3. Газрын нэгдмэл сангийн эрх зүйн байдлын тайлан /Маягт ГТ-2/	90
2.4. Газрын улсын бүртгэлийн тайлан /Маягт ГТ-3/	94
2.5. Газарт учруулсан хохирлын тайлан /Маягт ГТ-6/	97
2.6. Газар хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний тайлан /Маягт ГТ-7/	102
2.7. Газрын төлбөр ногдуулалт, төлөлт /Маягт ГТ-8/	105
2.8. Газар өмчлөлийн тайлан /Маягт ГТ-9/	111
<b>3. ДҮГНЭЛТ</b>	<b>115</b>

## ОРШИЛ

---

Монгол Улсын Газрын нэгдмэл сангийн үндсэн болон дэд ангилал бүрийн газрын тоо бүртгэл, газрын улсын бүртгэл, шилжилт хөдөлгөөн, газарт учирсан хохирол, газар хамгаалах, нөхөн сэргээх талаар авсан арга хэмжээ, газрын төлбөр ногдуулалт, төвлөрүүлэлт зэрэг үзүүлэлтийг засаг захиргааны нэгж тус бүрээр тусган улсын газрын нэгдмэл сангийн тайланг гаргаж, Засгийн газарт танилцуулж байхаар Монгол Улсын Газрын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 2.6-д заасан билээ. Уг заалтын дагуу аймаг, нийслэлийн 2017 оны газрын нэгдмэл сангийн тайланг Монгол улсын Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан “Газрын нэгдмэл сангийн тайлан гаргах журам” болон Засгийн газрын 2003 оны 204 дүгээр тогтоолоор батлагдсан тайлангийн ГТ1-9 маягтын дагуу нэгтгэн танилцуулж байна.

Газрын нэгдмэл сангийн улсын тайлан нь тайлангийн хугацаанд газрын ангилал болон газар өмчлөл, эзэмшил, ашиглалтын эрх зүйн байдал, тэдгээрт гарсан өөрчлөлтөд дүгнэлт өгөх, газрын талаар авч хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээг тодорхойлох, цаашид газрыг өмчлөх, эзэмших, ашиглах, хуваарилах, хамгаалах, нөхөн сэргээх болон газар зохион байгуулалтын бусад арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх, газрын нэгдмэл сангийн өгөгдөхүүнд өөрчлөлт оруулах, улс, орон нутгийн статистик мэдээнд ашиглахад суурь материал болдог ач холбогдолтой.

# 1

## ТАЙЛАНТ ОНД ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ТАЛААР ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ

### 1.1. ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗРААС ХЭРЭГЖҮҮЛСЭН ТОМООХОН АЖЛУУД

#### 1.1.1. ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ХУУЛЬ ТОГТООМЖ, ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ САЛБАРТ ХИЙГДЭХ АЖЛУУДЫН ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ, ТӨСВИЙН ТООЦОО, ТАНИЛЦУУЛГЫГ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД:

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2017 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн А/39 тоот тушаалаар Геодези, зураг зүйн тухай хууль /шинэчилсэн найруулга/, Үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хууль /шинээр/, Газрын тухай хууль /шинэчилсэн найруулга/, “Газрын төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль /шинэчилсэн найруулга/, Нийгмийн зайлшгүй хэрэгцээнд зориулан газрыг нөхөх олговортойгоор эргүүлэн авах тухай хууль /шинээр/-иудыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажиллалаа.

Үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл, Газрын төлбөрийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл, Кадастрын тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл, Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Нийгмийн зайлшгүй хэрэгцээнд зориулан газар чөлөөлөх тухай хуулийн төсөл, Газрын тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг тандан судалгааны үнэлгээний тайлангийн хамт боловсруулаад байна.

ГЗБГЗЗГ-ын даргын 2017 оны А/219 дүгээр тушаалаар Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгааны үнэлгээ хийх ажлын хэсгийг байгуулан ажиллуулсан бөгөөд тандан судалгааны үнэлгээний тайланд Засгийн газрын гишүүдээс санал авч байна.

“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн төсөлд тусгахаар геодези, зураг зүй, инженер хайгуул, мониторинг, газар зохион байгуулалт, кадастр, хот төлөвлөлт, барилга, орон зайн дэд бүтэц, мэдээлэл технологи, архивын чиглэлээр 2018 онд хийх ажлын судалгаа, төсвийн тооцоо, танилцуулгыг боловсрууллаа.

“Газрын харилцаа, геодези, зураг зүйн талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн төсөл”-ийг газрын харилцааны салбарын 6 үндэсний хөтөлбөр, 17 техник, эдийн засгийн үндэслэлтэй уялдуулан боловсруулав.

УИХ-ын 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 45 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн Газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 121 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд тусгагдсаны дагуу дараах үндэсний хөтөлбөрүүдийг боловсруулаад байна. Үүнд:

- Монгол орныг зурагжуулах үндэсний хөтөлбөр
- Газрын төлөв байдал, чанарын мониторингийн үндэсний хөтөлбөр
- Нутаг дэвсгэрийн тогтвортой хөгжлийг дэмжих газар зохион байгуулалтын үндэсний хөтөлбөр
- Монгол улсад олон зориулалтын кадастрын нэгдсэн тогтолцоог байгуулах үндэсний хөтөлбөр
- Төрийн цахим архив, цахим үйлчилгээг хэрэгжүүлэх үндэсний хөтөлбөр

- Үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтэц байгуулах үндэсний хөтөлбөр

Мөн Монгол улсын Засгийн газрын 2016 оны “ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ” 121 дүгээр тогтоолын 3-т “Төлөвлөгөөнд тусгасан томоохон төсөл, хөтөлбөрийн техник эдийн засгийн үндэслэлийг 2017 онд багтаан эцэслэн боловсруулж, 2018 оноос хэрэгжүүлж эхлэх бэлтгэлийг бүрэн хангаж ажиллах”-аар даалгасныг хэрэгжүүлэх зорилгоор дараах 17 техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын даалгаврын төсөл боловсруулсан. Үүнд:

1. Газрыг зохистой ашиглаж, хамгаалах, нөхөн сэргээх тогтолцоог бүрдүүлж, газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны үндэсний мониторингийн сүлжээг байгуулах;
2. Аймгийн төвүүдийн нутаг дэвсгэрт газар хөдлөлийн бичил мужлалын зураг хийх, газар хөдлөлийн эрсдлийг тодорхойлоход чиглэсэн инженер геологи, гидрогеологийн судалгааны ажил;
3. Газрын харилцааны талаар иргэдэд үзүүлэх үйлчилгээ, лавлагааны цахим системийг байгуулах;
4. Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний тодотголтой нийцүүлж газар ашиглалтын зориулалт бүрээр газрын тохиромжтой байдлын болон хэрэгцээт байдлын үнэлгээний үр дүнд үндэслэн аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг тодотгох;
5. Мэдлэгт суурилсан газар зохион байгуулалтын төлөвлөлтийг иргэдийн оролцоотойгоор ил тод хийж, тэдгээрийг орон нутагтаа баялаг бүтээх боломжийг бүрдүүлэн, олон төрөлтөт эдийн засгийн хөгжлийн үндсийг бий болгох;
6. Байрлалд суурилсан нийгэм, эдийн засгийн нэгдсэн мэдээллийн сан, системийг улсын хэмжээнд бий болгож, эрүүл мэнд, боловсрол болон бусад байгууллагуудыг ашиглах боломжоор хангаж, тогтолцоог бүрдүүлэх;
7. Аймаг, нийслэлийн газрын кадастрын мэдээллийн санг өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлж засварлан, улсын кадастрын нэгдсэн мэдээллийн системд холбож, үйлчилгээнд нэвтрүүлэх;
8. Улсын хэмжээнд газрын бодит үнэ цэнийг олон улсын жишгийн дагуу зах зээлийн зарчимд үндэслэн тогтоож, газрын суурь үнийг шинэчилж, иргэд, олон нийтэд нээлттэй, ил тод болгох;
9. Газрын цахим биржийг ажиллуулах эрх зүйн орчныг бүрдүүлж, газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт, түрээс, барьцааг цахимаар зохион байгуулж, оролцогч талуудыг эрх тэгш байдлаар ханган, эдийн засгийг эрчимжүүлэх;
10. Төрийн архивыг цахимжуулах, архивын хосгүй үнэт баримтыг илрүүлэх, сан хөмрөгөө баяжуулж, нөхөн бүрдүүлэлт хийх;
11. Орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэгч байгууллагуудын санг геопорталаар дамжуулан цахимжуулж, хэрэглээнд нэвтрүүлэх;
12. Газар зүйн нэр, хаяг, геодезийн цэг тэмдэгт, хилийн цэсийн мэдээллийн цахим үйлчилгээг нэвтрүүлэх;
13. Монгол Улсын нутаг дэвсгэрийн 55 хувийг 1:25000-ны масштабтай байр зүйн зургаар зурагжуулах;
14. Газар зүйн нэрийн тодруулалтыг улсын хэмжээнд хийх;
15. Монгол Улсын 63 сум, суурин газарт GNSS (GPS)-ийн байнгын ажиллагаатай суурин станц байгуулах;
16. Монгол орны өндрийн тулгуур сүлжээг шинэчлэх;
17. Монгол орны эхлэл цэг байгуулах.

Ажлын даалгаврын дагуу 17 ТЭЗҮ-ийг боловсруулж, ажлын хэсгийн, орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн, газрын даргын дэргэдэх Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн холбогдох засвар, өөрчлөлтийг хийж, БХБ-ын дэд сайдаар батлуулав.



## 1.1.2. САЛБАРЫН ГАДААД БОЛОН ДОТООД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ, БАТЛУУЛАХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД:

Салбарын гадаад хамтын ажиллагааны хүрээнд 2017 оны байдлаар нийт 2 Хамтран ажиллах санамж бичиг болон Хамтран ажиллах гэрээг байгуулаад байна. Үүнд:

- Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар нь Швейцарийн хөгжлийн агентлагийн “Ногоон Алт-Малын эрүүл мэнд төсөл”-ийн дэмжлэгээр Бэлчээр ашиглалтын чиглэлээр хамтран ажиллах гэрээ
- Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын BEAK CONSULTANTS GMBH компанитай хамтран ажиллах санамж бичгийг тус тус байгуулаад байна.
- Салбарын дотоод хамтын ажиллагааны хүрээнд 2017 оны байдлаар нийт гурван байгууллагатай хамтран ажиллах санамж бичиг, нэг яамтай 2 чиглэлээр ажлын хэсэг байгуулан хамтран ажиллахаар болсон байна. Үүнд:
- Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институт хоорондын хамтын ажиллагааны санамж бичиг
- Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, Монголын газар зохион байгуулагчдын холбоо хоорондын хамтын ажиллагааны санамж бичиг
- Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар хоорондын хамтын ажиллагааны санамж бичиг
- ХХААХҮЯ-ны төрийн нарийн бичгийн дарга, ГЗБГЗЗГ-ын даргын хамтарсан тушаал, Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах хамтарсан ажлын хэсэг байгуулах тухай
- ХХААХҮЯ-ны төрийн нарийн бичгийн дарга, ГЗБГЗЗГ-ын даргын хамтарсан тушаал, Хөдөө аж ахуйн газар /бэлчээр, хадлан, атаржсан газар, газар тариалангийн газар/-ын мэдээллийн санг бүрдүүлэх ажлын хэсэг байгуулах, хамтран ажиллах тухай

Салбар хоорондын, байгууллага хоорондын, олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх ажлын хүрээнд:

- “Барилгын салбарын 2017-2018 оны хамтын хэлэлцээр” болон “Барилгын салбарын 2017-2018 оны хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-ний төсөлд тус газраас оруулах саналыг бэлтгэн БХБЯ-нд 2017.05.05-ны 1/798 албан тоотор хүргүүлсэн. Хамтын хэлэлцээр байгуулагдаж, ажлын төлөвлөгөө батлагдсан.
- МУ-ын Үндэсний статистикийн хорооны даргын 2017.04.24-ны А/61 дүгээр тушаалаар “Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын бэлтгэл ажлын хүрээнд Барилга, орон сууцны тооллогыг улсын хэмжээнд явуулах шаардлагатай талаар санал боловсруулах, энэ асуудлыг цаашид нарийвчлан судлах, тооллогын бэлтгэлийг хангах, зохион байгуулах Хамтарсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оролцон ажиллаж байна.
- 2016 оны 01-р сарын 18-19-ний өдрүүдэд болсон Монгол орны UN-REDD үндэсний хөтөлбөрийг танилцуулах семинарт оролцож, байгууллагын үйл ажиллагааг танилцуулж, харилцан санал солилцож ажилласан.
- Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Ашигт малтмалын газар, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар хооронд байгуулах Санамж бичгийн төсөлд санал боловсруулсан. Санамж бичиг нь газар нутгийг тусгай хэрэгцээнд авах тухай орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолын зөрчлийг арилгах, орон нутгийг тусгай хэрэгцээнд авах, бүртгэх үйл ажиллагааг сайжруулах, улсын хэмжээнд орон нутгийн тусгай хамгаалалттай газар /ОНТХГ/-ын нэгдсэн тоо, баримт, мэдээллийг ашиглах, харилцан солилцох, ОНТХГ-ын мэдээллийн сангийн тогтмол ажиллагааг хангах зорилготой юм.
- “Барилгачдын баяр-2017”-г тэмдэглэх нэгдсэн хөтөлбөрийн хүрээнд БЗТЗХ-ноос 2017.09.08-

ны өдөр МҮЭСТО-нд зохион байгуулсан “Медиа” үзэсгэлэнд ГЗБГЗЗГ-ын танилцуулга, мэдээллийг бэлтгэн оролцсон.

- 2017.10.20-ны өдөр Төрийн ордны Иргэний танхимд хийсэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар зохион байгуулагдах Агаарын бохирдлыг бууруулах үндэсний чуулганы “Төвлөрлийг сааруулах, түүнийг шийдвэрлэх арга зам” салбар хуралдаанд оролцсон.

### 1.1.3. АГЕНТЛАГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГ ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛГООР ТУС ГАЗРЫН ХАРЬЯА ОРОН НУТГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ДОТООД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙЖ, БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ САНАЛ ЗӨВЛӨМЖӨӨР ДЭМЖИХ АЖЛЫН ХҮРЭЭНД:

2017 онд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын төлөвлөгөөг 2017.04.25-ны өдөр Газрын даргаар батлуулсан бөгөөд уг төлөвлөгөөний дагуу 21 аймгийн ГХБХБГ-ын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх Ажлын хэсгийн бүрэлдэхүүн, удирдамжийг Газрын даргын А/122 дугаар тушаалаар батлуулан 2017.05.07-ны өдрөөс 2017.05.23-ны өдрийн хороонд Архангай, Баян-Өлгий, Булган, Дархан-Уул, Завхан, Орхон, Сэлэнгэ, Увс, Ховд, Хөвсгөл аймагт ажилласан бөгөөд хяналт-шинжилгээний ажлын тайланг 2017.05.31-ний өдрийн Газрын даргын дэргэдэх зөвлөлийн 13 дугаар хуралдаанд танилцууллаа.

Баянхонгор, Говь-Алтай, Говьсүмбэр, Дорнод, Дорноговь, Дундговь, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Төв, Хэнтий аймгуудад 2017.06.04-ний өдрөөс 2017.06.20-ны өдрүүдэд ажилласан ба тайланг 2017.07.26-ны өдрийн Газрын даргын дэргэдэх Зөвлөлийн 15 дугаар хуралдаанд хэлэлцүүлсэн бөгөөд хуралдааны шийдвэрээр Ажлын хэсэг гарган 2017 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 2/1504 дугаартай албан бичгээр зөвлөмжийг аймаг, орон нутагт хүргүүлээ.

Нийслэлийн Газрын алба болон 9 дүүргийн Газрын албаны үйл ажиллагаанд Газрын даргын 2017 оны А/231 дүгээр тушаалаар 12 хүний бүрэлдэхүүнтэй Ажлын хэсэг байгуулан 2017.10.09-ны өдрөөс 2017.11.10-ны өдрүүдэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг газрын удирдлагууд болон Газрын даргын дэргэдэх зөвлөлийн хуралдаанд танилцууллаа.


### 1.1.4. ИНЖЕНЕР ХАЙГУУЛ, МОНИТОРИНГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

#### ГЕОЛОГИ ОРЧНЫ МЭДЭЭЛЛИЙН САН

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын захиалгаар урьд өмнө хийгдсэн улсын хэмжээний 59 зураг, аймаг, сумын төвийн 1709 цаасан буюу аналог зургийг тоон системд хөрвүүлэх, зарим сумдад хээрийн судалгааны ажлыг гүйцэтгэх ажлыг “Инжгеотех” ХХК 2013-2017 онд гүйцэтгэж, “Монгол орны геологи орчны мэдээллийн сан”-г бүрдүүлээ.

Энэхүү мэдээллийн сан нь геологи, тектоник, шинэ тектоник газар чичирхийлэл, геоморфологи, дөрөвдөгч, ашигт малтмал, гидрогеологи, гидрологи, инженер-геологи, түүх археологийн гэсэн үндсэн дэд давхаргуудаас бүрдэх бөгөөд хурдас чулуулгийн хэв шинж, гарал үүсэл, дөрөвдөгчийн хурдасны зузаан, хурдас чулуулгийн нас, гарал үүслийн төрөл, литологийн бүрэлдэхүүн, суурь чулуулгийн төрөл, дөрөвдөгчийн хагарал, гадаргын хэлбэр, тектоник хагарал, геоморфологийн үндсэн болон дэд хэв шинж, газар хөдлөлийн түүхэн болон багажинд бүртгэгдсэн мэдээ, газар хөдлөлийн ерөнхий мужлал, ашигт малтмалын үндсэн төрөл, орд/илрэл, голлох ашигт малтмал, ул хөрсний бүрэлдэхүүн, цэвдэг, гидрогеологийн нөхцөл, орчин үеийн геологийн үйл явц, мөнх цэвдэгийн тархалтын бүсийн хил зааг, палеонтологийн олдворын төрөл, цэвдэгт үзэгдлүүдийн мэдээлэл болон түүх археологийн нутаг дэвсгэрийн хил, томоохон хот суурин, худалдааны гол зам, усан суваг, эзэнт гүрний шууд захиргааны муж улс, боомт, түүхэн олдворууд гэсэн мэдээллээс бүрдэж байна.

ЗУРАГ 1.1.4.1: МОНГОЛ ОРНЫ ИНЖЕНЕР ГЕОЛОГИЙН НӨХЦӨЛИЙН 1:500 000 МАСШТАБ БҮХИЙ ТОЙМ ЗУРАГ



Мэдээллийн сан бий болсноор бүх шатны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулах, хот төлөвлөлт, барилга байгууламжийн төлөвлөлтийг шинжлэх ухааны үндэстэй хийхэд чухал суурь материал болох төдийгүй сургалт, эрдэм шинжилгээ, олон нийтийн хэрэглээнд ашиглах өргөн боломжийг бүрдүүлж байна.

## 12 АЙМГИЙН ТӨВИЙН ГАЗАР ХӨДЛӨЛИЙН БИЧИЛ МУЖЛАЛЫН МЭДЭЭЛЛИЙН САН


Монгол Улсын Засгийн газраас “Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний хөтөлбөр”-ийг 2009 онд баталж, хүн амын төвлөрөл ихтэй хот, суурин газар, бүсийн тулгуур төвд 1:10000-ны масштабтай газар хөдлөлийн бичил мужлалын зураг зохиох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

2012-2017 онд Барилга, хот байгуулалтын яамны захиалгаар Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Дорнод, Говьсүмбэр, Сүхбаатар, Орхон, Өвөрхангай, Хэнтий аймгийн төвд 1:10000 масштабтай газар хөдлөлийн бичил мужлалын зураг, түүний тодорхойлоход чиглэсэн инженер-геологи, гидрогеологийн судалгааны ажлыг Одон орон геофизикийн хүрээлэн гүйцэтгэж, үр дүнг хүлээж аваад байна.

Энэ ажлын хүрээнд газар хөдлөлийн идэвхжил, идэвхтэй хагарал, газар хөдлөлийн аюулын үнэлгээ, геофизик, грави хайгуул, сул газар хөдлөлт, микросейсм, инженер-геологи, гидрогеологийн судалгааг хийж, газар хөдлөлтийн түүхэн болон багажинд бүртгэгдсэн мэдээллийн санг бүрдүүлж, хөрсний зонхилох давтамж, хөрсний оргил хурдатгалыг тодорхойлж, газар хөдлөлийн бичил мужлалын зураг, инженер-геологи, гидрогеологийн зургийг үйлдэх ажлыг хийж гүйцэтгэв.

Газар хөдлөлийн бичил мужлалын зураг, газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг тодорхойлоход чиглэсэн инженер-геологи, гидрогеологийн мэдээллийн сан нь хот, суурин газрын нутаг дэвсгэрт барилга, байгууламжийг шинээр барих, өргөтгөх, шинэчлэх, засварлах, барилгын ажил гүйцэтгэх, зураг төсөл боловсруулахад шаардагдах суурь мэдээлэл болох төдийгүй газар хөдлөлийн гамшгийн эрсдэлийг бууруулах, ард иргэдийг эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж байгаагаараа ач холбогдолтой.

ЗУРАГ 1.1.4.2: АРХАНГАЙ АЙМГИЙН ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН ИНЖЕНЕР-ГЕОЛОГИ, ГАЗАР ХӨДЛӨЛИЙН БИЧИЛ МУЖЛАЛЫН ХӨРСНИЙ ЗОНХИЛОХ ДАВТАМЖ, ХӨРСНИЙ ОРГИЛ ХУРДАТГАЛЫН ЗУРАГ



## БЭЛЧЭЭРИЙН ГАЗРЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ ФОТОМОНИТОРИНГИЙН АРГААР ҮНЭЛЭХ

ГЗБГЗЗГ нь “Бэлчээр ногоон алт” төсөлтэй хамтран 2015 оноос бэлчээрийн газрын өөрчлөлтийг фотомониторингийн аргаар үнэлэх ажлыг жил бүр улсын хэмжээнд хэрэгжүүлж байгаа бөгөөд мониторингийн цэгүүдээс ижил хугацаанд мэдээллийг цуглуулж, фото зураг авч, програм ашиглан үр дүнг гаргаж байна.

Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фотомониторингийн аргаар үнэлэх нь бэлчээрийн төлөв байдал, чанарын өөрчлөлтийн явцыг хянах, цаг тухайд нь илрүүлэх, үнэлэлт, дүгнэлт өгөх, урьдчилан сэргийлэх, хэрэглэгчдийг мэдээллээр хангах, бэлчээрийг зохистой ашиглах нөхцлийг хангаж байдгаараа чухал ач холбогдолтой. Энэ аргын давуу тал нь богино хугацаанд нэг дор олон мэдээллийг цуглуулах, хэрэглэхэд энгийн, зардал багатай, сэргэн ургалт, доройтол, талхагдлын урт богино хугацааны өөрчлөлтийг харуулдаг.


2017 онд “Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фотомониторингийн аргаар үнэлэх, мэдээлэл боловсруулах, тайлан гаргах” сэдэвт сургалтыг 21 аймгийн 330 сумын нийт 360 мэргэжилтэн, газрын даамлыг хамруулан хийлээ.

ЗУРАГ 1.1.4.3: ХЭЭРИЙН СУДАЛГАА ХИЙХ БОЛОН СУУРИН БОЛОВСРУУЛАЛТ ХИЙХ СУРГАЛТ



Одоогийн байдлаар бэлчээрийн газрын өөрчлөлтийг фотомониторингийн аргаар үнэлэх 2418 цэгийг албан ёсоор тогтоосон байгаа бөгөөд байгууллагын орон зайн мэдээллийн санд нийт 51 үзүүлэлтээр мэдээллийг жил бүр оруулах нөхцөлийг бүрдүүлээд байна. Өөрөөр хэлбэл хэрэглэгчид байгууллагын орон зайн мэдээллийн сангаас цэгийн солбицол, аймаг, сум, баг, бэлчээр ашиглалтын хэсгийн нэр, судалгаа хийсэн огноо, газрын нэр, улирлын бэлчээр, ургац, бэлчээрийн төлөв байдлын үнэлгээ, бүсийн нэр, сэргэх чадварын ангилал зэрэг мэдээллийг харах боломжтой юм.

ЗУРАГ 1.1.4.4: БЭЛЧЭЭРИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН СЭРГЭХ ЧАДВАРЫН АНГИЛЛЫН ЗУРАГ



Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фотомониторингийн аргаар үнэлэх ажил нь бэлчээрийн чанар бүтээмжийн өөрчлөлтийг тодорхойлох, урьд жилүүдийн үр дүнтэй харьцуулах, бэлчээр ашиглалтыг зохицуулах, үнэлэлт дүгнэлт өгөх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх чухал ач холбогдолтой ажил юм.

### ТАРИАЛАН БОЛОН АТАРШСАН ГАЗРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧАНАРЫН УЛСЫН ХЯНАН БАТАЛГААНЫ АЖИЛ

Тус газраас Газрын тухай хуулийн холбогдох заалтын дагуу тариалан болон атаршсан газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлыг улсын хэмжээнд 5 жил тутам хийж байгаа бөгөөд анхны хянан баталгааны ажлыг 2006 онд хийсэн бол 2017 оноос 3 дахь удаагийн хянан баталгааны ажлыг тариалангийн гол бүс нутгаас эхлүүлээд байна.

2017 онд улсын төсвийн хөрөнгөөр Сэлэнгэ, Дорнод, Булган, Төв аймгийн нийт 858315.0 га тариалан болон атаршсан талбайд тариалан болон атаршсан газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлыг хийж гүйцэтгэж үр дүнг хүлээн аваад байна.

### 1.1.5. ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР:

#### “МОНГОЛ УЛСЫН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨГ ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛАХ”

Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний тодотгол боловсруулах ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж, салбар дундын зохицуулалт хийх үүрэг бүхий Ажлын хэсгийг Монгол Улсын Ерөнхий сайдын 2017 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 55 дугаар захирамжаар байгуулсан бөгөөд уг захирамжийн дагуу Ажлын хэсгийн анхны уулзалтыг 2017 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр БХБЯ-нд зохион байгууллаа. Ажлын хэсгийн хурлаар ажлын нарийвчилсан төлөвлөгөөг хэлэлцэж, зөвшөөрсний дагуу БОАЖЯ, ХХААХҮЯ, УУХҮЯ, ЭХЯ, ЗТХЯ, Үндэсний хөгжлийн газарт ГЗБГЗЗГ-ын зүгээс УГЗБЕТ-ний тодотгол ажлын танилцуулгыг хийж, дэд ажлын хэсгийг байгуулан холбогдох мэдээллийг уг ерөнхий төлөвлөгөөний тодотголтой уялдуулах ажлыг гүйцэтгэсэн.

“Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах, түүний хэмжээ заагийг тогтоох, ашиглах журам”-ыг Засгийн газрын 2017 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 287 тоот тогтоолоор баталгаажуулсан.

Тухайн журамд улсын тусгай хэрэгцээний газар, түүнд тавигдах шаардлагыг тодорхойлон, газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах үйл ажиллагааг алхам бүрээр зааж өгсөн, газрыг өөр газраар солих буюу нөхөн олговор олгох үйл ажиллагаа болон гол асуудал нь ГЗБГЗЗГ нь улсын тусгай хэрэгцээний газарт үйл ажиллагаа явуулж буй тухайн яаманд гэрчилгээ олгох талаар журамлаж өгсөн.


### НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН МЭДЭЭЛЛИЙН САН БАЙГУУЛАХ

ҮОЗМДБ-ийн нэг дэд сан нь “Нийгэм, эдийн засгийн мэдээллийн сан” бөгөөд уг сан нь нийгэм, эдийн засгийн 27 салбарын 642 үндсэн үзүүлэлтийн 2532 утга бүхий дэд үзүүлэлтээс бүрдсэн, мэдээллүүд орон зайн өгөгдөлтэй буюу зурагтай холбогдох, төрийн байгууллагууд мэдээллийн санд мэдээллээ оруулах болон байнга шинэчлэх, цаг хугацаа, орон зай хамаарахгүй онлайн хандалттай байх, төрийн бүх шатны байгууллага дундаа ашиглах онцлогтой юм.

Одоогийн байдлаар уг мэдээллийн санг бүрдүүлэх ажлыг дуусган манай байгууллагын геопортал <https://geoportal.nsd.gov.mn> сайтаар дамжуулан иргэд олон нийтэд нээлттэй ашиглаж болохоор вэб аппликэйшнийг холбож, бэлтгэл ажлыг хангаад байна.



ЗУРАГ 1.1.5.1: НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН МЭДЭЭЛЛИЙН САН




## СУМЫН НУТАГ ДЭВСГЭРИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ

“Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах арга зүй”-г боловсруулан ГЗБГЗЗГ-ын 2017 оны 11 дүгээр сарын 24-ний А/278 тоот тушаалаар батлуулсан. Уг арга зүйг баримтлан тухайн сумын нутаг дэвсгэрийн газар ашиглалт, байгалийн нөөц, нөхцөлийн онцлогийг бүрэн тодорхойлсны үндсэн дээр нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийн бодлогыг дэмжсэн, иргэд, олон нийтийн оролцоо, тэдний санал санаачилга, орон нутагтаа баялаг бүтээх боломжийг бүрдүүлсэн цогц үйл ажиллагаа бүхий дунд хугацааны төлөвлөгөө боловсруулах нөхцөл бүрдэж байгаа юм.

2017 оны байдлаар Улсын хэмжээнд 11 аймгийн 19 суманд нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлыг хийж гүйцэтгээд байна. Үүнд:

1. Сэлэнгэ сум, Булган аймаг
2. Мандал сум, Сэлэнгэ аймаг
3. Ерөө сум, Сэлэнгэ аймаг
4. Хүдэр сум, Сэлэнгэ аймаг
5. Баян тал, Говьсүмбэр аймаг
6. Сүмбэр сум, Говьсүмбэр аймаг
7. Шивээговь, Говьсүмбэр аймаг
8. Батноров сум, Хэнтий аймаг
9. Батширээт сум, Хэнтий аймаг
10. Эрдэнэцагаан сум, Сүхбаатар аймаг
11. Баяндэлгэр сум, Сүхбаатар аймаг
12. Түвшинширээ сум, Сүхбаатар аймаг
13. Сүхбаатар сум, Сүхбаатар аймаг
14. Бөхмөрөн сум, Увс аймаг
15. Дөрвөлжин сум, Завхан аймаг
16. Дарви сум, Ховд аймаг
17. Жаргалант сум, Орхон аймаг
18. Халиун сум, Говь-Алтай аймаг
19. Өргөн сум, Дорноговь аймаг

ЗУРАГ 1.1.5.2: СУМЫН НУТАГ ДЭВСГЭРИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ХИЙГДСЭН СУМД



## 2017 ОНД ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР БОЛОВСРУУЛАГДСАН ЖУРАМ, ЗААВАР

- “Сумын бэлчээрийн чадавхийг зураглах заавар”
- “Өвөлжөө, хаваржааны доорх газар болон өвөлжөө, хаваржааны орчмын бэлчээрийн газрын жишиг хэмжээ”
- Газар зохион байгуулалтын ажлын хүнд хөнгөний зэрэглэл
- Монгол улсын иргэнд өмчлүүлэх газрын нөөц тогтоох, тогтоогдсон нөөц газарт газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах аргачилсан зөвлөмж
- Нийгэм, эдийн засгийн мэдээллийн санг бүрдүүлэх хөтлөх журам

## СУРГАЛТ, ХЯНАЛТ, ШАЛГАЛТ

- “Бэлчээрийн газрыг экологийн чадавхиар нь ангилан зураглах” сэдэвт сургалтыг аймгуудын ГХБХБГ-ын мэргэжилтэн-21, нийслэлийн Газрын албаны Газрын менежмент, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн-1, Хөдөө Аж Ахуйн Их Сургуулийн Бэлчээрийн лабораторийн оюутан-2 нийт 24 хүнийг хамруулан зохион байгууллаа.
- 2017 оны 12 дугаар сарын 20-21-ний өдрүүдэд “Газрын тогтвортой менежмент ба нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө” сэдэвт сургалтад Говь-Алтай, Баян-Өлгий, Увс, Завхан аймгуудын ГХБХБГ-аас 2 мэргэжилтэн, сумдын газрын даамлуудаас тус бүр 8 даамал нийт 50 хүнийг хамруулав.



ЗУРАГ 1.1.5.3: “ГАЗРЫН ТОГТВОРТОЙ МЕНЕЖМЕНТ БА НУТАГ ДЭВСГЭРИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ” СЭДЭВТ СУРГАЛТЫН ҮЕЭР.




### 1.1.6. КАДАСТРЫН ЧИГЛЭЛЭЭР:

#### ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН ТООЛЛОГО, ТОО БҮРТГЭЛ

Газар зүйн мэдээллийн системийн програм хангамжийг ашиглан 2009-2011 онд хийж гүйцэтгэсэн газрын нэгдмэл сангийн тооллого, тоо бүртгэлийн ажлын тоон мэдээллийг хиймэл дагуулын зураг /2013-2014 оны SPOT-5, 2015 оны Ландсат-8/, 1:100000 масштаб бүхий байр зүйн зургийн тодотгол, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийг солбицолжуулах ажлын үр дүн, улсын тусгай хэрэгцээний газрын болон “Ойн сан бүхий газрын мэдээллийн сан бүрдүүлэх ажил”-ын тоон мэдээллийг ашиглан 21 аймаг, нийслэлийн хэмжээнд шинэчлэн улсын хэмжээнд нэгтгэх ажлыг хийж гүйцэтгэж байна.

ЗУРАГ 1.1.6.1: СЭЛЭНГЭ АЙМГИЙН МАНДАЛ СУМЫН ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН ЗУРАГ



Иргэд олон нийт, мэргэжлийн байгууллагуудыг мэдээллээр хангах зорилгоор Монгол Улсын газрын нэгдмэл сангийн ангилал, тайлан, түүнтэй холбоотой бүх төрлийн мэдээллийг товхимол болгон жил бүр хэвлүүлэн нийтийн хүртээл болгож байна.

ЗУРАГ 1.1.6.2: ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН ТАЙЛАНГИЙН ТОВХИМЛУУД



## ГАЗРЫН КАДАСТРЫН МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ӨГӨГДЛИЙГ ЗАСВАРЛАХ, ГЕОДЕЗИЙН СОЛБИЦОЛ, ӨНДӨР, ТУСГАГИЙН НЭГДСЭН ТОГТОЛЦООНД ШИЛЖҮҮЛЭХ, ТУРШИХ, НЭГЖ ТАЛБАРЫН ХУВИЙН ХЭРГИЙГ ШИНЭЧЛЭН БҮРДҮҮЛЭХ

Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 25 дугаар тогтоолын дагуу 21 аймаг, 330 сумын нутаг дэвсгэр дээр байгаа нийт газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч нарын газрын кадастрын зургийг геодезийн солбицол, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэн зураглаж, газар өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой эрх зүйн баримт бичгийг дахин нягтлан нэгж талбарын хувийн хэргийг орон нутагт нь бүрдүүлэх, тоон байдлаар үүсгэх, газрын улсын бүртгэлийг нэг стандартын дагуу шинэчлэн бүрдүүлэх ажлыг 2013 оноос 2017 онд хэрэгжүүллээ.

ЗУРАГ 1.1.6.3: “ГАЗРЫН КАДАСТРЫН МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ӨГӨГДЛИЙГ ЗАСВАРЛАХ, ГЕОДЕЗИЙН СОЛБИЦОЛ, ӨНДӨР, ТУСГАГИЙН НЭГДСЭН ТОГТОЛЦООНД ШИЛЖҮҮЛЭХ, ТУРШИХ, НЭГЖ ТАЛБАРЫН ХУВИЙН ХЭРГИЙГ ШИНЭЧЛЭН БҮРДҮҮЛЭХ” АЖЛЫН АЧ ХОЛБОГДОЛ



“Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбицол, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх” ажлын гүйцэтгэгчээр “Геомастер” ХХК шалгаран 2013 онд гэрээ байгуулан гүйцэтгэсэн бөгөөд туслан гүйцэтгэгчээр 27 аж ахуйн нэгж 21 аймгийн 330 суманд ажиллаж, тухайн шатны Засаг даргын захирамжаар өмчилж, эзэмшиж, ашиглаж байгаа 525823 нэгж талбарыг хамруулсан.


**ЗУРАГ 1.1.6.4: “ГАЗРЫН КАДАСТРЫН МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ӨГӨГДЛИЙГ ЗАСВАРЛАХ, ГЕОДЕЗИЙН СОЛБИЦОЛ, ӨНДӨР, ТУСГАГИЙН НЭГДСЭН ТОГТОЛЦООНД ШИЛЖҮҮЛЭХ, ТУРШИХ, НЭГЖ ТАЛБАРЫН ХУВИЙН ХЭРГИЙГ ШИНЭЧЛЭН БҮРДҮҮЛЭХ” АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ**



## ГАЗРЫН КАДАСТРЫН МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН НЭГДСЭН СИСТЕМ

Монгол Улсын 2013 оны Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын XXI.1.43-д тусгагдсан “Газрын кадастрын мэдээллийн сан”-г солбицлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх ажлын хүрээнд “Газрын кадастрын мэдээллийн сангийн “Лэнд менежер” програм хангамжийг нэвтрүүлэх, хөгжүүлэх” гэрээт ажлыг 21 аймаг, 330 суманд зохион байгуулав.

**ЗУРАГ 1.1.6.5: ГАЗРЫН КАДАСТРЫН МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ЛЭНД МЕНЕЖЕР ПРОГРАМ ХАНГАМЖИЙГ НЭВТРҮҮЛСЭН БАЙДАЛ**



Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар нь Газрын тухай хууль, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль шинэчлэгдэн батлагдсанаас хойш хуульд заасан чиг үүргийнхээ хүрээнд Монгол Улсын хэмжээнд геодезийн сууриар баталгаажсан, кадастрын зурган мэдээлэлд суурилсан, газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэл, цахимжсан хувийн хэрэг бүхий иргэдийн газар ашиглахтай холбоотой өргөдөл, бүртгэл, түүний шийдвэрлэлтийг автоматжуулсан, иргэд, олон нийтэд нээлттэй, нийгэм, эдийн засгийн олон талт эрэлт, хэрэгцээг хангах зорилго бүхий Улсын хэмжээний Газрын кадастрын мэдээллийн нэгдсэн системийг байгуулсан ба үр дүнг гүйцэтгэгч байгууллага “Геомастер”, “Топмаф” ХХК-иудаас хүлээн авав.

ЗУРАГ 1.1.6.6: ГАЗРЫН КАДАСТРЫН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМИЙН ТҮЛХҮҮР ГАРДУУЛАН ӨГӨХ ЁСЛОЛЫН АЖИЛЛАГАА



“Газрын кадастрын нэгдсэн мэдээллийн систем”-ийг 21 аймаг 330 сумын хэмжээнд амжилттай нэвтрүүлснээр Газрын кадастрын мэдээллийн сангийн цахим системийг бүрдүүлж олон нийтэд ашиглах боломжтойгоор үйлчилгээнд гаргасан.

Газрын кадастрын мэдээллийн сангийн цахим систем нэвтэрснээр иргэд интернет ашиглан өөрсдийн газрын эрхийн баталгаажилтын талаарх мэдээллийг, өргөдөл шийдвэрлэлтийн явцын талаарх мэдээллийг, газар эзэмших, ашиглах гэрээний мэдээллийг, газрын төлбөрийн талаарх мэдээллийг, 21 аймаг, 330 суманд үнэ төлбөргүй газар өмчилсөн талаарх мэдээллийг тус тус авах боломжтой болсон юм.

ЗУРАГ 1.1.6.7: ГАЗРЫН КАДАСТРЫН МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ЦАХИМ СИСТЕМ /EGAZAR.GOV.MN/



Газрын кадастрын мэдээллийн сангийн Лэнд менежер програм хангамжийг нэвтрүүлэх, хөгжүүлэх ажлын хүрээнд Лэнд менежер програмд мэдээ хөрвүүлж, нэвтрүүлэх сургалтыг 2015 оны 3 дугаар сарын 24-ны өдрөөс эхлэн 5 удаагийн давтамжтайгаар улсын хэмжээнд зохион байгууллаа. Мөн Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2017 оны А/142 дугаар тушаалын дагуу Газрын кадастрын мэдээллийн сангийн Лэнд менежер програм хангамжийн төлбөртэй сургалтыг улиралд нэг удаа зохион байгуулан ажиллаж байна.

## ГАЗРЫН СУУРЬ ҮНЭЛГЭЭГ ШИНЭЧЛЭХ

Газрын төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 1997 оны 152 дугаар тогтоолоор 1 га-ийн суурь үнэлгээг баталсан бөгөөд энэхүү суурь үнэлгээ нь зах зээлийн бодит байдалтай нийцэхгүй байх, газар зүйн байршил, газар ашиглалтын зориулалттай уялдаагүй байх зэргээс үүдэн газрын төлбөр, татвар, газар эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн дуудлага худалдааны анхны үнэ, газрын нөхөх олговрын үнэ, бэлэглэх, барьцаалах, даатгуулах, газар ашиглалтын зөв оновчтой төлөвлөлтийг хийх зэрэг үйл ажиллагаанд хүндрэл гарч байна.

Иймээс Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар нь 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, нийслэлийн Газрын алба, мэргэжлийн багш, судлаачидтай хамтран “Газрын үнэлгээний бүс /тойрог, зэрэглэл/, суурь үнэлгээ, төлбөрийн хувь, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн.


Газрын нэгдмэл сангийн үнэлгээний бүсийг /зэрэглэл/ байгаль, нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцөлийн мужлалыг үндэслэн тогтоосон. Энэхүү байгаль нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцөлийн мужлалыг 1987 онд байгалийн бүс, бүслүүр, ландшафт, хөрс, ургамлын мэдээллийг үндэслэн боловсруулсан бөгөөд 1:1000000 масштабтай зургуудыг ашиглаж гаргасан нь тухайн үед Улсын төлөвлөгөөний комиссоор дэмжигдэж байсан бөгөөд тус мужлал дээр үндэслэн 1992 онд Газрын бодлогын хүрээлэнгээс “Байгаль нутаг дэвсгэрийн тойргуудын цогцолбор үнэлгээ”-г гаргасан байдаг. Үүний дараагаар 2002 онд “Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө”-г боловсруулахдаа Газрын бодлогын хүрээлэнгийн өмнө нь хийсэн мужлалыг илүү боловсронгуй болгож, одоогийн байгаль, нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцөлийн мужлалыг гаргасан. Энэхүү бүсийг ашиглан бэлчээр, хадлан, тариалангийн газрын суурь үнэлгээг бүс тус бүрээр тогтоож өгсөн.

ЗУРАГ 1.1.6.8: ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ БҮСИЙН ЗУРАГ



Төв суурин газрын суурь үнэлгээг тогтоохдоо 2010-2015 оны газрын зах зээлийн үнийн мэдээнд шинжилгээ хийж, түүн дээрээ газрын үнэд нөлөөлөх гол хүчин зүйлүүд болох дэд бүтэц /барилгажилт, инженерийн шугам сүлжээ, зам харилцааны нөхцөл/, нийгмийн үйлчилгээ /сургууль, цэцэрлэг, уст цэг, ЗДТГ, баг хорооны хил/, төв зах зээлээс алслагдсан байдал зэргийн нөлөөллийг тооцоолсны үндсэн дээр газрын суурь үнэлгээний бүс /зэрэглэл/, 1 га газрын суурь үнэлгээг тогтоосон.

ЗУРАГ 1.1.6.9: НИЙСЛЭЛИЙН ХЭМЖЭЭНИЙ ГАЗАР АШИГЛАЛТЫН 17 ЗОРИУЛАЛТАЙ, 16 СУУРЬ ҮНЭЛГЭЭНИЙ БҮС /ЗЭРЭГЛЭЛ/




## ГАЗРЫН БИРЖИЙН ЦАХИМ СИСТЕМ

Монгол Улсын хэмжээнд газрын зах зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, статистик мэдээллийг нэг цэгт төвлөрүүлэх, цогц мэдээллээр үйлчлэх, иргэд олон нийтэд ил тод болгох, газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтыг түргэн, шуурхай, ил тодоор зохион байгуулах, газрын барьцаа, түрээсийн бүртгэл, үнийн мэдээ цуглуулах мэдээллийн сан бий болгох зорилгоор “Газрын биржийн цахим систем”-ийг хөгжүүлээд байна.

Иргэд, олон нийт өөрийн сонирхсон газрыг эзэмшүүлэх, ашиглуулах, өмчлүүлэх эрхийн дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтад Газрын биржийн цахим системийг ашиглан орон зай харгалзахгүйгээр оролцож, газар, үл хөдлөх хөрөнгийн үнийн мэдээ, мэдээлэл авах боломжтой болсон.

### ЗУРАГ 1.1.6.10: ГАЗРЫН БИРЖИЙН ЦАХИМ СИСТЕМЭЭР ХИЙГДЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА



Улсын хэмжээнд Газрын биржийн цахим системийг ашиглаж эхэлснээс хойш нийт 1175 газар эзэмшүүлэх дуудлага худалдаа, 285 газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан. Мөн биржийн системд газрын барьцааны 10984, газрын үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн 13210 үнийн мэдээг бүртгэж оруулаад байна.

2017 онд нийт 565 газар эзэмшүүлэх дуудлага худалдаа, 137 газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалт, 9429 барьцааны, 2431 газрын үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээний мэдээлэл бүртгэсэн байна.

ХҮСНЭГТ 1.1.6.1: 2017 ОНД КАДАСТРЫН ЧИГЛЭЛЭЭР ГЗБГЗЗГ-ЫН ДАРГЫН ТУШААЛААР БАТЛАГДСАН  
ЖУРАМ, ЗААВАР

д/д	Эрх зүйн актын нэр	Огноо	Хавсралтын дугаар	Хавсралтын нэр
1	Журам батлах тухай	2017.05.08 А/139	Хавсралт	Газрын кадастрын мэдээллийн санг ажиллуулах журам
2	Сургалтын хөтөлбөр, батламжийн загвар батлах тухай	2017.05.09 А/142	1 дүгээр хавсралт	Газрын кадастрын мэдээллийн сангийн програм хангамжийн сургалтын хөтөлбөр
3			2 дугаар хавсралт	Батламжийн загвар
4	Журам, маягт батлах тухай	2017.05.16 №А/146	1 дүгээр хавсралт	Кадастрын хураамжийн орлого төвлөрүүлэлтийг зохион байгуулах журам
5			2 дугаар хавсралт	“Хураамжийн орлогын төлөвлөгөө”-ний Х1 маягт
6			3 дугаар хавсралт	“Хураамжийн тайлан”-гийн Х2 маягт
7	Журам батлах тухай	2017.05.30 №А/157	Хавсралт	Газрын кадастрын мэдээллийн сангийн архивын тоон мэдээллээс нотлох баримт болон лавлагаа гаргах үйл ажиллагааны журам
8	Заавар батлах тухай	2017.10.26 №А/248	Хавсралт	Нийслэлийн хэмжээнд Газрын кадастрын мэдээллийн сангийн Лэнд менежер програм хангамжийг нэвтрүүлэх заавар
9	Загвар батлах тухай	2017.09.26 №А/224	Хавсралт	Газрын кадастрын мэдээллийн санг геодезийн солбицол, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлсэнтэй холбоотойгоор талбайн хэмжээг өөрчлөн бүртгэсэн талаар хийх тэмдэглэгээний загвар
10	Гэрчилгээний загвар батлах хэвлүүлэх тухай	2018.01.29 №А/26	1 дүгээр хавсралт	УИХ-ын тогтоолоор улсын тусгай хэрэгцээнд авсан газрын гэрчилгээний загвар
11			2 дугаар хавсралт	ЗГ-ын тогтоолоор улсын тусгай хэрэгцээнд авсан газрын гэрчилгээний загвар
12	Заавар батлах тухай	2018.02.23 №А/40	Хавсралт	Харъяалах нутаг дэвсгэрийн хилийн цэсийн гадна иргэн, хуулийн этгээдэд газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгосон зөрчлийг арилгах ажлын заавар

### 1.1.7. ОРОН ЗАЙН ӨГӨГДӨЛ, МЭДЭЭЛЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас газрын зурагт суурилсан өгөгдөл, мэдээллийг иргэд, олон нийт, төрийн бусад байгууллагын албан хэрэгцээнд ашиглуулах зорилгоор хийгдэж буй Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн чиглэлээр дараах ажлууд хийгдсэн байна. Үүнд:


- 10 бүлгээс бүрдсэн 119 хуудас “Байгууллагын орон зайн өгөгдлийн дэд бүтцийн системийн техникийн баримт бичиг” 1.0 хувилбарыг боловсруулж,




ГЗГГЗЗГ-ын даргын 2017 оны А/263 тоот тушаалаар батлуулав.

- “Байгууллагын орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагааг зохицуулах журам”-ын төслийг ГЗГГЗЗГ-ын даргын 2017 оны А/253 тоот тушаалаар батлуулав.
- Байгууллагын орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үндсэн 6 системийн суурилуулалт, зохион байгуулалт, нэмэлт аппликейшныг хийж хэрэглээнд нэвтрүүлсэн бөгөөд бусад байгууллага, яам, агентлагуудад танилцуулах ажлыг хийсэн.

ЗУРАГ 1.1.7.1: БАЙГУУЛЛАГЫН ОРОН ЗАЙН ӨГӨГДЛИЙН ДЭД БҮТЦИЙН ҮНДСЭН 6 СИСТЕМ




ЗУРАГ 1.1.7.2: ГАЗРЫН БИРЖИЙН ЦАХИМ СИСТЕМД БҮРТГЭГДСЭН ЗАРУУДЫН БАЙРШИЛ



### 1.1.8. МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ЧИГЛЭЛЭЭР:


ГЗБГЗЗГ-аас “Юнивишн” ХХК-тай 2017 оны 11 дүгээр сард гэрээ байгуулж, ГЗБГЗЗГ-ыг нийслэлийн Газрын алба, 9 дүүргийн Газрын алба, 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газартай шилэн кабель ашиглан тусгайлсан холболт /VPN/-ыг хийхийн зэрэгцээ тухайн гэрээний дагуу өндөр хурдны интернет үйлчилгээг авч эхэлсэн. Мөн 335 сум, тосгоны газрын даамлыг гэр интернет төхөөрөмж ашиглан тусгайлсан холболт /VPN/-ыг үүсгэж салбарын хэмжээнд нэгдсэн нэг сүлжээнд холбогдох боломжийг бүрдүүлсэн нь тус байгууллага дээр үүсч байгаа олон төрлийн системүүдэд сум, дүүргээс шууд хандаж өгөгдөл, мэдээллийг аюулгүй шинэчлэх боломж бүрдээд байна.

ЗУРАГ 1.1.8.1: ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ САЛБАРЫН МЭДЭЭЛЭЛ ДАМЖУУЛАХ СҮЛЖЭЭНИЙ ХАМРАХ ХҮРЭЭ



Геодезийн багаж баталгаажуулалтын бүртгэлийн програм хангамжийн интерфэйсийг гаргаж хөгжүүлэлтийг хийж дууссан бөгөөд 2010-2017 оны хооронд баталгаажуулсан геодезийн хэмжлийн багажийн мэдээллийг засварлаж програм хангамжид оруулаад байна.


ЗУРАГ 1.1.8.2: ХЭМЖИЛТИЙН БАГАЖНЫ БҮРТГЭЛИЙН ПРОГРАМ ХАНГАМЖ



## 1.2. ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН СУДАЛГАА


Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар нь Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 06 дугаар тушаалаар баталсан стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт заасны дагуу Захиргаа, удирдлага, хамтын ажиллагааны газар, Газар зохион байгуулалтын хэлтэс, Геодези, зураг зүйн хэлтэс, Инженер хайгуул, мониторингийн хэлтэс, Кадастрын хэлтэс, Орон зайн мэдээлэл, технологийн хэлтэс, Хот төлөвлөлтийн хэлтэс, Барилгын техник, технологийн хөгжлийн хэлтэс, Норм, нормативын хэлтэс, Санхүү, эдийн засгийн хэлтэс, Архив, мэдээллийн төв гэсэн нийт 11 нэгж, нийслэлийн газрын алба, дүүргийн газрын алба, аймагт Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, сумдад Газрын даамал гэсэн нэгжтэйгээр ажиллаж байна /Зураг 1.2.1/.

■ ЗУРАГ 1.2.1: ГЗБГЗЗГ-ЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



Газрын харилцааны салбарт агентлагт 86, нийслэл, дүүргийн Газрын албанд 176, аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт 350, суманд Газрын даамал 355, нийт 967 албан хаагч ажиллаж байна /Зураг 1.2.2/.

ЗУРАГ 1.2.2: УЛСЫН ХЭМЖЭЭНД ГАЗРЫН САЛБАРТ АЖИЛЛАЖ БАЙГАА АЛБАН ХААГЧДЫН ТОО



Агентлаг нь ажлын байрны тодорхойлолтын дагуу эрхэлсэн ажлаа мэргэжлийн түвшинд чанартай гүйцэтгэх боломжийг бий болгох үүднээс албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлж ажиллалаа.


Мөн агентлагийн хэлтсүүд, мэргэжилтнүүд, орон нутгийн харъяа байгууллага, газрын мэргэжлийн байгууллагуудад мэргэжил, арга зүйн зөвлөгөөг тухай бүр хариуцсан ажлын чиглэлээр тогтмол өгч ажилласан.

Газрын харилцааны салбарт ажиллагсдын судалгааг насны ангилал, хүйсийн харьцаа, ажилласан жил, албан тушаалын ангилал, боловсрол, туршлага, нийгмийн хамгаалал гэсэн 4 бүлэг, нарийвчилсан 26 мэдээлэл бүхий үзүүлэлтээр гаргалаа.

### 1.2.1. НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН ГАЗРЫН АЛБА


ЗУРАГ 1.2.1.1: НИЙСЛЭЛИЙН ХЭМЖЭЭНД ГАЗРЫН САЛБАРТ АЖИЛЛАЖ БАЙГАА АЛБАН ХААГЧДЫН ХҮЙСИЙН ХАРЬЦАА

Нийслэлийн Газрын албанд нийтдээ 176 албан хаагч ажиллаж байна. Хүйсийн харьцаагаар 51% эрэгтэй, 49% эмэгтэй ажилтнууд байна / Зураг 1.2.1.1/.




Насны ангиллаар 18-30 насны 23%, 31-40 насны 51%, 41-50 насны 16%, 51-с дээш насны 11% албан хаагч ажиллаж байна /Зураг 1.2.1.2/.

■ ЗУРАГ 1.2.1.2: НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН ГАЗРЫН АЛБАНЫ АЛБАН ХААГЧДЫН НАСНЫ АНГИЛАЛ




Нийслэл, дүүргийн Газрын албанд 2-15 жил төрийн албанд ажиллаж байгаа албан хаагчид хамгийн их буюу 72%-ийг эзэлж байна /Зураг 1.2.1.3/.

■ ЗУРАГ 1.2.1.3: НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН ГАЗРЫН АЛБАНЫ АЛБАН ХААГЧДЫН ТӨРИЙН АЛБАНД МЭРГЭШСЭН БАЙДАЛ




Нийслэл, дүүргийн Газрын албан хаагчдын 150 буюу 85% нь төрийн захиргааны албан хаагч, 26 буюу 15% нь төрийн үйлчилгээний албан хаагч байна. Төрийн захиргааны албан хаагчид ТЗ-5-аас ТЗ-10 хүртэл албан тушаалын зэрэглэлтэй байна /Зураг 1.2.1.4/.

■ ЗУРАГ 1.2.1.4: АЛБАН ТУШААЛЫН АНГИЛАЛ, ЗЭРЭГЛЭЛ




Нийслэл, дүүргийн Газрын албаны 176 албан хаагчид 100% дээд боловсролтой, үүнээс 136 буюу 77% бакалавр зэрэгтэй, 40 албан хаагч буюу 23% магистр зэрэгтэй ажилчид байна /Зураг 1.2.1.5/.

■ ЗУРАГ 1.2.1.5: НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН ГАЗРЫН АЛБАНЫ АЛБАН ХААГЧДЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН




Газрын харилцааны салбарт ажиллагсдын ажлын байранд шаардагддаг газар зүйн мэдээллийн системийн ArcGIS, AutoCAD, LM програм хангамжийг нийслэл, дүүргийн Газрын албаны албан хаагчдын 84% дундаас дээд түвшинд эзэмшсэн байна /Зураг 1.2.1.6/.

ЗУРАГ 1.2.1.6: НИЙСЛЭЛИЙН ГАЗРЫН АЛБАНЫ АЛБАН ХААГЧДЫН ГАЗАР ЗҮЙН МЭДЭЭЛЛИЙН ПРОГРАМ ХАНГАМЖИД АЖИЛЛАХ УР ЧАДВАР




Гадаад хэлний мэдлэгийн хувьд 58 албан хаагч 2 буюу түүнээс дээш хэлний мэдлэгтэй, үүний ихэнх нь англи, орос хэлний хосолсон, нийт албан хаагчдын 58% англи, 36% орос хэлийг эзэмшсэн бусад буюу Солонгос, Хятад, Герман, Япон хэлийг 12 хүн эзэмшсэн байна /Зураг 1.2.1.7/.

ЗУРАГ 1.2.1.7: НИЙСЛЭЛИЙН ГАЗРЫН АЛБАНЫ АЛБАН ХААГЧДЫН ХЭЛНИЙ МЭДЛЭГ



Албан хаагчдын 129 буюу 73% нь газар эзэмших, өмчлөх, ашиглах эрхтэй байна. Нийслэл, дүүргийн 129 албан хаагч банк, санхүүгийн байгууллагад зээлтэй, 47 буюу 27% нь зээлгүй байна. /Зураг 1.2.1.8/

ЗУРАГ 1.2.1.8: НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН АЛБАН ХААГЧДЫН НИЙГМИЙН АСУУДАЛ




## 1.2.2. АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРУУД

21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт ажиллаж байгаа албан хаагчдыг насны байдлаар ангилж үзвэл:

Нийт албан хаагчдын 30% нь 18-30 насны, 46% нь 31-40 насны, 24% нь 40 ба түүнээс дээш насныхан байгаа ба үүнээс 41 албан хаагч 50-иас дээш настай байна /Зураг 1.2.2.1/.


ЗУРАГ 1.2.2.1: АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН НИЙТ АЛБАН ХААГЧДЫН НАСНЫ ХАРЬЦУУЛАЛТ






Нийт албан хаагчдын 55% нь эрэгтэй, 45% нь эмэгтэй албан хаагчдын 85% нь тухайн орон нутгийн уугуул иргэд ажиллаж байна /Зураг 1.2.2.2/.

ЗУРАГ 1.2.2.2: АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН АЛБАН ХААГЧДЫН ХҮЙСИЙН ХАРЬЦАА БОЛОН ТУХАЙН ОРОН НУТГИЙН УУГУУЛ ИРГЭН ЭСЭХ




Албан хаагчдын 90% нь 1-ээс 15 жил ажиллаж байгаа бөгөөд 16-аас дээш жил ажиллаж байгаа 28 /нийт албан хаагчдын 10% / албан хаагч байна /Зураг 1.2.2.3/.

ЗУРАГ 1.2.2.3: АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРУУДЫН АЛБАН ХААГЧДЫН ТӨРИЙН АЛБАНД МЭРГЭШСЭН БАЙДАЛ /ЖИЛЭЭР/




Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын нийт 366 албан хаагчдаас Төрийн захиргааны албан хаагч 243, Төрийн үйлчилгээний албан хаагч байна /Зураг 1.2.2.4/.

ЗУРАГ 1.2.2.4: АЛБАН ТУШААЛЫН АНГИЛАЛ, ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ХААГЧИЙН ЗЭРЭГ ДЭВТЭЙ ЭСЭХ




Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газруудын нийт албан хаагчдын 75% нь бакалаврын зэрэгтэй, 15% буюу 54 албан хаагч магистрын зэрэгтэй, 9% буюу 33 албан хаагч бүрэн болон тусгай дунд боловсролтой байна. Бүрэн болон тусгай дунд боловсролтой албан хаагчид өдөр тутмын үйл ажиллагаа хэвийн явуулахад дэмжлэг үзүүлэх чиглэлийн үйлчилгээний албан үүргийг гүйцэтгэж байна /Зураг 1.2.2.5/.

ЗУРАГ 1.2.2.5: АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН АЛБАН ХААГЧДЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН




Ажлын байранд шаардагддаг газар зүйн мэдээллийн системийн програм хангамжийг нийт албан хаагчдын 74 хувь нь бүрэн болон сайн эзэмшсэн, давхардсан тоогоор англи хэлний мэдлэгтэй 288, орос хэлний мэдлэгтэй 132, бусад хэл буюу Солонгос, Япон, Хятад, Герман хэлний мэдлэгтэй 13 албан хаагч ажиллаж байна /Зураг 1.2.2.6/.

**ЗУРАГ 1.2.2.6: АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН АЛБАН ХААГЧДЫН УР ЧАДВАР**



Нийт албан хаагчдын 52 хувь нь буюу 192 албан хаагч эзэмших, ашиглах, өмчлөх эрхийн газартай, 86 хувь нь буюу 316 албан хаагч болон санхүүгийн байгууллагад тодорхой хэмжээний зээлтэй байна /Зураг 1.2.2.7/.

**ЗУРАГ 1.2.2.7: АЙМГУУДЫН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРУУДЫН АЛБАН ХААГЧДЫН НИЙГМИЙН АСУУДАЛ**




### 1.2.3. СУМДЫН ГАЗРЫН ДААМЛУУД

21 аймгийн нийт 330 суманд 355 газрын даамал ажиллаж байгаа бөгөөд ажлын онцлогоос шалтгаалж цөөн тооны суманд 2 газрын даамал ажиллаж байна.


Сумдын газрын даамлуудыг нас болон хүйсээр нь харьцуулан авч үзэхэд: нийт газрын даамлуудын 44% нь 18-30 насны, 41% нь 31-40 насны, 15% нь 40 ба түүнээс дээш насны албан хаагчид ажиллаж байна /Зураг 1.2.3.1/.

■ ЗУРАГ 1.2.3.1: СУМДЫН ГАЗРЫН ДААМЛЫН НАСНЫ АНГИЛАЛ




Нийт албан хаагчдын 55% нь эрэгтэй, 45% нь эмэгтэй албан хаагчид байгаа ба 85% нь тухайн орон нутгийн уугуул иргэд ажиллаж байна /Зураг 1.2.3.2/.

■ ЗУРАГ 1.2.3.2: СУМДЫН ГАЗРЫН ДААМЛУУДЫН ХҮЙСИЙН ХАРЬЦАА, ТУХАЙН ОРОН НУТГИЙН УУГУУЛ ИРГЭД ЭСЭХ




Газрын даамлуудын 92% нь төрийн албанд 1-ээс 15 жил ажиллаж байна. 26 албан хаагч буюу 8% нь төрийн албанд 16-аас дээш жил ажиллаж байна /Зураг 1.2.3.3/.

ЗУРАГ 1.2.3.3: СУМДЫН ГАЗРЫН ДААМЛУУДЫН АЖИЛЛАСАН ЖИЛ



Төрийн албан хаагчийн ангиллын зэрэглэлийн хувьд 95% нь төрийн захиргааны албан хаагчид байна /Зураг 1.2.3.4/.


ЗУРАГ 1.2.3.4: СУМДЫН ГАЗРЫН ДААМЛУУДЫН ТӨРИЙН АЛБАНЫ АНГИЛАЛ




346 даамал бакалаврын зэрэгтэй /нийт газрын даамлуудын 97%/, магистрын зэрэгтэй 4, бүрэн болон тусгай дунд боловсролтой 5 газрын даамал ажиллаж байна.

Давхардсан тоогоор англи хэлний мэдлэгтэй 285, орос хэлний мэдлэгтэй 77, бусад хэлний мэдлэгтэй 4 газрын даамал ажиллаж байна. Сумдын газрын даамлуудын 76% нь буюу 269 газрын даамал ажлын байранд шаардагдах програм хангамжийг тодорхой хэмжээгээр эзэмшсэн ба үүнээс 16 нь бүрэн, 253 нь сайн, 86 нь дунд хэмжээгээр эзэмшсэн байгаагаас харахад цаашид улам мэргэшүүлэхэд анхаарч ажиллах нь зүйтэй байна.

ЗУРАГ 1.2.3.5: СУМДЫН ГАЗРЫН ДААМЛУУДЫН ТӨРИЙН АЛБАНЫ АНГИЛАЛ




ЗУРАГ 1.2.3.6: СУМДЫН ГАЗРЫН ДААМЛУУДЫН УР ЧАДВАР



Нийт газрын даамлуудын 50% нь буюу 178 газрын даамал эзэмших, ашиглах, өмчлөх эрхийн газартай, 50% буюу 177 албан хаагч болон санхүүгийн байгууллагад тодорхой хэмжээний зээлтэй байна.


ЗУРАГ 1.2.3.7: СУМДЫН ГАЗРЫН ДААМЛУУДЫН НИЙГМИЙН БАЙДАЛ



### 1.3. ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР ХИЙСЭН ХЯНАЛТ, ШАЛГАЛТ


2017 онд 21 аймгийн хэмжээнд Газрын талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд давхардсан тоогоор нийт 993 удаагийн хяналт, шалгалт хийснээс нийт 9530 зөрчил илэрсэн байна /Зураг 1.3.1/.

ЗУРАГ 1.3.1: 2017 ОНД ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ХИЙГДСЭН ТОО БОЛОН ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН ТОО /АЙМАГ ТУС БҮРЭЭР/



Улсын хэмжээнд Газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн хяналт, шалгалтын тоо, хэмжээ өмнөх онуудад жил дараалан өссөн үзүүлэлттэй байсан бол 2017 онд буурсан үзүүлэлттэй байна /Зураг 1.3.2/.

**ЗУРАГ 1.3.2: ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ХИЙСЭН ТОО**




2017 онд Хөвсгөл, Баянхонгор, Булган, Сэлэнгэ, Төв, Увс аймгууд газрын харилцааны хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналт, шалгалтыг хамгийн олон удаагийн давтамжтай буюу ихэнх сумдаа хамруулж 77-159 удаа явуулсан байна /Зураг 1.3.3/.

Харин Говьсүмбэр, Дархан-Уул, Орхон аймгууд хамгийн бага давтамжтай буюу 2-4 удаа хяналт шалгалтыг явуулсан байна.

Орон нутагт хийсэн хяналт, шалгалтын ажлын давтамжаас хамаарч илэрсэн зөрчлийн тоо харилцан адилгүй байна.


**ЗУРАГ 1.3.3: ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ТОО**





2017 онд Газрын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн хяналт, шалгалтаар нийт 9530 зөрчил илэрсэн байна. Үүний 84.4% нь газар эзэмших, ашиглах гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, 11.6% нь эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүй газар ашигласан, 3% нь төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагаанаас хамаарсан зөрчил, 1% нь бусад зөрчлүүд тус тус эзэлж байна /Зураг 1.3.4/.


**ЗУРАГ 1.3.4: ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ, ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЙН ТӨРӨЛ, ТҮҮНИЙ ХАРЬЦУУЛАЛТ**



2017 онд эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр газар ашигласан, төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагаанаас хамаарсан зөрчил өмнөх онуудаас буурсан үзүүлэлттэй, харин газар эзэмших, ашиглах гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй зөрчил өссөн үзүүлэлттэй байна.

Газар эзэмших, ашиглах гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй зөрчлийг дотор нь ангилж авч үзвэл хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан зориулалтын дагуу 2 жил дараалан ашиглаагүй 2894 /36%/, гэрээнд заасан зориулалт бусаар газар ашигласан 275 /4%/, газар эзэмших, ашиглах эрхийн хугацаа дууссан 270 /3%/, газрын төлбөрөө хугацаанд нь төлөөгүй 4527 /56%/, газрын хэмжээг өөрчлөн хашаагаа сунгасан 76 /1%/ зөрчил тус тус эзэлж байна /Зураг 1.3.5/.

ЗУРАГ 1.3.5: ГАЗАР ЭЗЭМШИХ, АШИГЛАХ ГЭРЭЭГЭЭР ХҮЛЭЭСЭН ҮҮРГЭЭ  
БИЕЛҮҮЛЭХГҮЙ БАЙХ ЗӨРЧИЛ




Зураг 1.3.5-аас харахад гэрээнд заасан зориулалт бусаар газар ашигласан зөрчил өмнөх оныхоос 21%-иар буурсан бол газар эзэмших, ашиглах эрхийн хугацаа дууссан зөрчил 41%-иар, газрын төлбөрөө хугацаанд нь төлөөгүй зөрчил 11%-иар, 2 жил дараалан ашиглаагүй зөрчил 9%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

#### 1.4. ӨРГӨДӨЛ, ХҮСЭЛТ, ТЭДГЭЭРИЙН БАРАГДУУЛАЛТЫН СУДАЛГАА

Улсын хэмжээнд 2017 онд аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад хандан газрын харилцааны талаар гаргасан өргөдөл хүсэлтийн судалгааг нэгтгэн дүгнэхэд нийт 163226 өргөдөл, хүсэлт ирүүлснээс шинээр газар эзэмших 40472 /24.7%/, шинээр газар ашиглах 627 /0.3%/, газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх 12658 /7.7%/, газар эзэмших эрхийн гэрчилгээгээ барьцаалах 13713 /8.4%/, газар ашиглалтын зориулалт өөрчлөх 1503 /0.9%/, газар эзэмших, ашиглах гэрээ, гэрчилгээний хугацаа сунгуулах 4731 /2.8%/, эзэмшил газраа бусдад ашиглуулах 105 /0.06%/, газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ нөхөн авах 4563 /2.7%/, эзэмшиж байгаа газраа өмчлөх 8041 /4.9%/, өмчилсөн газрынхаа хэмжээг өөрчлөх 2580 /1.5%/, өмчилсөн газраа барьцаалах 16202 /9.9%/, шинээр газар өмчлөх 53156 /32.5%/, өмчлөх эрхээ шилжүүлэх 3823 /2.3%/, газар эзэмших, ашиглах эрхээ хүчингүй болгуулах хүсэлт 464 /0.2%/, бусад 588 /0.3 %/ өргөдөл хүсэлт ирүүлсэн байна.


Үүнээс тайлант онд 92 хувийг шийдвэрлэж, 8 хувийг шийдвэрлэгдээгүй байна /Зураг 1.4.1/.

■ ЗУРАГ 1.4.1: ӨРГӨДӨЛ, ХҮСЭЛТИЙН ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДЛЫН СУДАЛГАА



2016 оны тайлангийн дүнтэй харьцуулахад шинээр газар эзэмших өргөдөл 11305-аар буурч, өмчилсөн газраа барьцаалсан тоо 14496-аар ихэссэн байна.

ЗУРАГ 1.4.2: ӨРГӨДӨЛ, ХҮСЭЛТИЙН ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДЛЫН СУДАЛГААГ 2016 ОНТОЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ




Өргөдөл, хүсэлт дараах шалтгааны улмаас шийдвэрлэгддэггүй байна.

Үүнд:

- Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй газарт газар өмчлөх, эзэмших, ашглах хүсэлт гаргасан;
- Өргөдөл, хүсэлтийн баримт бүрдүүлэлт дутуу;
- Дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт явагдсанаас хойш материалаа ирүүлсэн;
- Хүсэлт ирүүлсэн газар бусдад олгогдсон, давхардсан;
- Бичиг баримтын зөрчилтэй, баримт бичгийн бүрдүүлэлт дутуу, инженерийн шугам сүлжээ бүхий газар, авто замын зурвас газарт орсон;
- Нисэхийн хориотой бүсэд, үерийн аман дээр газар ашиглах, эзэмших, өмчлөх, зөвшөөрөлгүй газар дээр газар ашиглах;
- Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан газрыг авахаас татгалзсан;
- Суурин судалгааны явцад шийдвэрлэгдэх боломжгүй нь тодорхойлогдсон.

Тайлант онд газар өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой өргөдөл шийдвэрлэлтийн талаарх гарын авлагыг боловсруулан иргэн, хуулийн этгээдэд тараах ажлыг зохион байгуулж, Газар зохион байгуулалт геодези, зураг зүйн газрын цахим хуудсанд мэдээлэл, шторк зэргийг байршуулсан.

ЗУРАГ 1.4.3: ГАЗАР ӨМЧЛӨХ, ЭЗЭМШИХ, АШИГЛАХТАЙ ХОЛБООТОЙ МАТЕРИАЛ



2017 онд Газрын кадастрын мэдээллийн сангийн “Лэнд менежер” програм хангамжийг 21 аймаг, 330 суманд нэвтрүүлснээр иргэн, хуулийн этгээдээс газар өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой гаргасан өргөдөл, гомдлыг цахимаар бүртгэж, иргэн хуулийн этгээд интернет хуудас ашиглан түргэн шуурхай өргөдлийн явц, байдлын талаар мэдэх боломжийг бүрдүүлээд байна.

## 1.5. ГАЗРЫН МАРГААН, ТҮҮНИЙГ ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ


Улсын хэмжээнд 2017 онд газар эзэмших, ашиглах, өмчлөх эрхтэй холбогдон гарсан маргааны судалгааг нэгтгэн дүгнэхэд нийт 6420 маргаан гарснаас газар эзэмшихтэй холбоотой 1490 /23%/, газар өмчлөхтэй холбоотой 247 /4%/, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэстэй холбоотой 4651 /72%/, газар ашиглахтай холбоотой 32 /1%/ маргаан тус тус гарсан байна /Хүснэгт 1.5.1/.

■ ХҮСНЭГТ 1.5.1: ГАЗРЫН МАРГААН, ТҮҮНИЙГ ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ /АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР/

№	Аймгийн нэр	Маргааны тоо				Үүнээс							
		Эзэмших	Өмчлөх	Хилийн цэстэй холбоотой	Ашиглах	Шийдвэрлэгдсэн				Шийдвэрлэгдээгүй			
						Эзэмших	Өмчлөх	Хилийн цэстэй холбоотой	Ашиглах	Эзэмших	Өмчлөх	Хилийн цэстэй холбоотой	Ашиглах
1	Архангай	29	10	49	0	25	10	9	0	4	0	40	0
2	Баянхонгор	54	11	67	5	44	8	32	5	10	3	35	0
3	Баян-Өлгий	0	20	945	0	0	0	0	0	0	0	945	0
4	Булган	142	28	85	4	123	23	18	4	19	5	67	0
5	Говь-Алтай	43	2	30	1	40	2	3	1	3	0	27	0
6	Говьсүмбэр	31	1	0	0	7	0	0	0	24	1	0	0
7	Дархан-Уул	118	4	1	0	47	4	0	0	71	0	1	0
8	Дорнод	5	22	12	2	5	22	3	0	0	0	9	2
9	Дорноговь	93	2	26	0	53	2	16	0	40	0	10	0
10	Дундговь	35	3	4	0	31	3	2	0	4	0	2	0
11	Завхан	289	2	692	1	116	2	13	1	173	0	679	0
12	Орхон	99	8	164	0	99	8	0	0	0	0	164	0
13	Өвөрхангай	16	3	172	0	9	3	10	0	7	0	162	0
14	Өмнөговь	14	14	34	0	10	11	4	0	4	3	30	0
15	Сүхбаатар	9	10	5	3	8	8	3	3	1	2	2	0
16	Сэлэнгэ	42	1	0	4	35	1	0	4	7	0	0	0
17	Төв	125	61	1822	0	113	44	14	0	12	17	1808	0
18	Увс	18	0	3	0	16	0	2	0	2	0	1	0
19	Ховд	65	12	406	11	44	8	0	0	21	4	406	11
20	Хөвсгөл	70	6	122	0	63	2	9	0	7	4	113	0
21	Хэнтий	26	15	12	1	21	7	11	1	5	8	1	0
22	Улаанбаатар	167	12	0	0	138	11	0	0	29	1	0	0
	Дүн	1490	247	4651	32	1047	179	149	19	443	48	4502	13


Улсын хэмжээнд нийт 6420 зөрчил, маргаан гарснаас 1394 газрын маргааныг шийдвэрлэсэн байна /Зураг 1.5.1/.

■ ЗУРАГ 1.5.1: ГАЗРЫН МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ



2017 онд гарсан маргааны тоог 2016 онд гарсан маргааны тоотой харьцуулахад газар эзэмших талаар гарсан маргаан 41, хилийн цэстэй холбоотой маргаан 4515-аар тус тус нэмэгдэн, өмчлөх талаарх маргаан 241, газар ашиглалттай холбоотой маргаан 50-иар буурсан дүнтэй байна /Зураг 1.5.2/.

■ ЗУРАГ 1.5.2: ГАЗРЫН МАРГААНЫ ТООГ ӨНГӨРСӨН ОНТОЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ



2017 оны байдлаар харьяалах нутаг дэвсгэрийн хилийн цэсийн гадна газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгосон нийт 4414 зөрчилтэй нэгж талбар байна /Хүснэгт 1.5.2/.

ХҮСНЭГТ 1.5.2: ХАРЪЯАЛАХ НУТАГ ДЭВСГЭРИЙН ХИЛИЙН ЦЭСИЙН ГАДНА ГАЗАР ӨМЧЛӨХ, ЭЗЭМШИХ, АШИГЛАХ ЭРХ ОЛГОСОН БАЙДАЛ /АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР/

Д/д	Аймгийн нэр	Харъяалах нутаг дэвсгэрийн хилийн цэсийн гадна газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгосон байдал	
		Нэгж талбарын тоо	Талбайн хэмжээ /га-аар/
1	Архангай	40	2954.9
2	Баян-Өлгий	945	97.5
3	Баянхонгор	13	15.0
4	Булган	53	1573.1
5	Говь-Алтай	1	147.9
6	Дорнод	9	119.4
7	Дундговь	2	1638.9
8	Завхан	679	112.2
9	Орхон	164	2461.3
10	Өвөрхангай	162	743.8
11	Өмнөговь	18	4.8
12	Төв	1808	11043.2
13	Ховд	406	225.7
14	Хөвсгөл	113	2823.2
15	Хэнтий	1	100.5
Улсын хэмжээнд нийт		4414	23694.3

Дээрх зөрчлийг арилгахаар Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2018 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/40 дүгээр тушаалаар “Харъяалах нутаг дэвсгэрийн хилийн цэсийн гадна газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгосон зөрчлийг арилгах ажлын заавар”-ыг батлан аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нар болон 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга, нийслэлийн Газрын албаны дарга нарт хүргүүлээд байна.

2017 оны байдлаар улсын хэмжээнд нийт 2582 захиргааны хэрэг хянан шийдвэрлэгдсэнээс газартай холбоотой захиргааны 551 хэрэг буюу нийт захиргааны хэргийн 21.34 хувийг эзэлж байна /Хүснэгт 1.4.3/.



ХҮСНЭГТ 1.5.3: ХЯНАН ШИЙДВЭРЛЭГДСЭН ЗАХИРГААНЫ ХЭРГИЙГ ТӨРЛӨӨР ХАРУУЛСАН  
БАЙДАЛ /ЭХ СУРВАЛЖ МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ЦАХИМ САН WWW.SHUUKH.MN/

Д/д	Шүүхийн үе шат	2015			2016			2017		
		Нийт	Газартай холбоотой маргаан	Эзлэх хувь	Нийт	Газартай холбоотой маргаан	Эзлэх хувь	Нийт	Газартай холбоотой маргаан	Эзлэх хувь
1	Захиргааны хэргийн анхан шатны шүүх	1457	344	23.6	1858	402	21.6	1609	277	17.2
	Давж заалдах шатны шүүх	600	136	22.6	740	179	24.1	441	178	40.3
	Хяналтын шатны шүүх	350	85	24.2	433	119	27.4	532	96	17.4
	НИЙТ	2407	565	23.4	3031	700	23.0	2582	551	21.3

Дээрх судалгаанаас үзэхэд улсын хэмжээнд хянан шийдвэрлэгдэж буй нийт 5 хэрэг тутмын 1 нь газартай холбоотой хэрэг байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд газрын маргаан тодорхой хэмжээгээр буурч байгаа нь дараах үндсэн шалтгаантай байна. Үүнд:

- ✓ Бүх шатны шүүх байгууллагад хандан нэхэмжлэл гаргаж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагын тоо буурсан, газартай холбоотой нийт хэргийн хэрэг хянан шийдвэрлэгдэх үйл ажиллагаа хойшлогдсон, хэрэг хянан шийдвэрлэгдээгүй;
- ✓ Газрын кадастрын мэдээллийн сангийн “Лэнд менежер” програм хангамжийг 2013 оноос шат дараалан /үе шаттайгаар/ 21 аймаг, 330 суманд нэвтрүүлсэн. Уг програм хангамж нь Газрын тухай хууль болон бусад хууль, тогтоомжид нийцүүлэн хийгдсэн тул аливаа зөрчилтэй нэгж талбар бүртгэгддэггүй бөгөөд зөрчлийг арилгах үйл ажиллагааг аймгийн ГХБХБГ болон сумын газрын даамлууд зохион байгуулсан;
- ✓ Газрын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад танилцуулах, энэ талаарх мэдлэгийг дээшлүүлэх, тулгарч буй асуудлыг шийдвэрлэх зорилгоор жил бүрийн “Газрын харилцааны ажилтны өдөр”-өөр нээлттэй хаалганы үйл ажиллагааг зохион байгуулдаг;
- ✓ ГЗБГЗЗГ-аас 21 аймгийн ГХБХБГ, нийслэлийн Газрын албадад хяналт шалгалтыг хийдэг бөгөөд энэхүү хяналт шалгалтын үр дүнгээр илэрсэн зөрчлийг арилгах ажлыг зохион байгуулдаг.

ХҮСНЭГТ 1.5.4: 2017 ОНД УЛСЫН ХЭМЖЭЭНД НИЙТ ГАЗАРТАЙ ХОЛБООТОЙ ХЯНАН ШИЙДВЭРЛЭГДСЭН ЗАХИРГААНЫ ХЭРГИЙГ ХАРИУЦАГЧИЙН ТӨРЛӨӨР ХАРУУЛСАН БАЙДАЛ /ЭХ СУРВАЛЖ МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ЦАХИМ САН WWW.SHUUKH.MN/

д/д	Хариуцагчийн төрөл	Анхан шатны шүүх	Давж заалдах шатны шүүх	Хяналтын шатны шүүх /Дээд шүүх/
1	Монгол улсын ЗГ-ын гишүүн, ИТХ-д холбогдох	27	12	13
2	Монгол улсын яам	3	1	2
3	ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг	15	5	0
4	Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, Засаг даргад холбогдох	224	158	76
5	Аймаг, нийслэлийн тохируулагч агентлаг	8	2	4
НИЙТ ДҮН		277	178	96

Тайлант онд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт бүх шатны шүүх болон иргэдээс ирүүлсэн албан бичиг, өргөдөлд хариу өгсөн байдлыг дүгнэхэд шинжээчийн дүгнэлт 56 ба өмнөх оноос 2-аар өссөн байна.

ГЗБГЗЗГ-ын Кадастрын хэлтсээс бүх шатны шүүх байгууллагад 292 удаагийн нотлох баримт хүргүүлсэн нь өмнөх оноос 42-оор буурсан дүнтэй байна.

2017 онд тус Газрын даргын тушаалаар байгуулагдсан шинжээчийн дүгнэлт болон магадлан хэмжилт хийж дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг нь 56 шинжээчийн дүгнэлт гаргасан байх бөгөөд үүнийг төрлөөр нь авч үзвэл:

- Захиргааны хэргийн анхан шатны шүүх – 21
- Иргэний хэргийн анхан шатны шүүх – 18
- Иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн – 14
- Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн – 2
- Дундговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх-1 байна.

Дээрх тайлан, мэдээнээс дүгнэхэд газрын маргаан гарах үндсэн шалтгаан нь:

Газартай холбоотой хууль, тогтоомж, журам, зааврын хэрэгжилт болон түүнд тавих хяналт хангалтгүй байх, албан тушаалтны санаатай болон санаандгүй үйлдэл, шийдвэр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын зөвшөөрөлгүйгээр төрийн болон бусдын өмчлөл, эзэмшил, ашиглалтын газарт үйл ажиллагаа явуулах, хашаа барих зэрэг шалтгааны улмаас газрын маргаан гарч байна.

Тайланд онд газрын зөрчил, маргаанаас урьдчилан сэргийлэх, бууруулах талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад Газрын тухай хууль тогтоомжийг сурталчлан таниулах, мэдлэгийг дээшлүүлэхээр гарын авлага, боршур, шторк зэргийг боловсруулан Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын цахим хаягт / [www.gazag.gov.mn/](http://www.gazag.gov.mn/) байршуулах, иргэн, аж ахуйн нэгж байгууллагад гарын авлага тараах зэргээр олон нийтийн хүртээл болгон ажилласан.

ЗУРАГ 1.5.3: ГАЗРЫН ЗӨРЧИЛ, МАРГААНЫ ТАЛААР ГАРЫН АВЛАГА

**ГАЗРЫН ЗӨРЧИЛ, МАРГААН**  
Газрын маргаан гарч буй үндсэн шалтгаан нь газартай холбоотой хууль, тогтоомж, журам, зааврын хэрэгжилт болон түүнд тавих хяналт хангалтгүй, албан тушаалтны санаатай болон санаандгүй үйлдэл, бусдын өмчлөл, эзэмшил, ашиглаж буй газарт үйл ажиллагаа явуулах, хашаа барих зэрэг болно.


- ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ТОГТООМЖ**
- Газрын тухай хууль
  - Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль
  - Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
  - Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
  - Захиргааны ерөнхий хууль
  - Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль
  - Кадастрын зураглалын ажил БНБД 11-11-16

**ТАНД ГАЗАРТАЙ ХОЛБООТОЙ ДАРААХ АСУУЛТ БАЙВАЛ НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН ГАЗРЫН АЛБАНД ХАНДАНА УУ.**

1. Та Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй газар өмчилж, эзэмшиж, ашиглаж байгаа эсэх;
2. Таны газар бусдын өмчилж, эзэмшиж, ашиглаж буй газартай давхцалтай эсэх;
3. Таны газар Засаг даргын захирамжид тусгагдсан талбайн хэмжээнээс илүү эсвэл дутуу эсэх;
4. Таны газар Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэгдэн баталгаажсан эсэх;
5. Та өөрийн өмчилж, эзэмшиж, ашиглаж буй газрынхаа хил заагийг бодит газар дээрээ хашиж тэмдэглүүлсэн эсэх;
6. Таны газрын гэрээ, гэрчилгээний хугацаа дууссан эсэх;
7. Та газрын төлбөр, татвар хугацаандаа төлсөн эсэх;

**ГАЗАР ӨМЧЛӨХ, ЭЗЭМШИХ, АШИГЛАХ ЭРХ БАТАЛГААЖСАНЫГ НОТЛОХ БАРИМТ БИЧИГ**

1. Газар эзэмших, ашиглах гэрчилгээ /Газар өмчилж буй үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ
2. Газар эзэмших, ашиглах гэрээ /Газар эзэмших, ашиглах гэрээнд тусгагдсан газрын төлбөрийг хугацаанд нь төлсөн байх/;
3. Газрын кадастрын зураг;
  - ✓Газар эзэмших, ашиглаж буй гэрчилгээн дээрх нэгж талбарын дугаар, талбайн хэмжээ, кадастрын зураг дээрх нэгж талбарын дугаар, талбайн хэмжээтэй тохирч байх;
  - ✓Газрын кадастрын зураг дээрх солбицлын дагуу бодит газар дээр газар өмчилж, эзэмшиж, ашиглаж байх;
  - ✓Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмчилж, эзэмшиж, ашиглаж буй газар Газрын кадастрын мэдээллийн санд бусдын өмчилж, эзэмшиж, ашиглаж буй газартай давхцалгүй байх;



**ЛАВЛАГАА ГАРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

Лавлагаа гэж тухайн газрын өмчлөгч, эзэмшигч, ашиглагч өөрийн өмчилж, эзэмшиж, ашиглаж буй газрын талаарх мэдээллийг Газрын кадастрын мэдээллийн сангийн архивын мэдээллээс шүүн өгч буй мэдээллийг хэлнэ.  
Газрын кадастрын мэдээллийн сан нь 2006 оноос хойш архивлагдан хадгалагдаж байна.  
Газрын кадастрын мэдээллийн сангийн архивын зурган мэдээллээс гаргаж өгч буй лавлагаа нь зурган мэдээлэл байна.



Зураг 2.ГКМС-ийн архивын зурган мэдээллийг агаар, сансрын зурагтай давхцуулсан байдал

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага өөрийн өмчилж, эзэмшиж, ашиглаж буй газрын талаарх лавлагаа авахыг хүсвэл дараах баримт бичгийг бүрдүүлэн Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт хандана.

1. Иргэний үнэмлэхний хуулбар /Аж ахуйн, нэгж байгууллагын гэрчилгээний хуулбар/;
2. Газрын кадастрын зураг;
3. Газар эзэмших, өмчлөх, ашиглах гэрчилгээний хуулбар;
4. Шаардлагатай гэж үзсэн тохиолдолд бусад бичиг баримт.

**1.6. ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХ БОЛОН ӨМЧИЙН ГАЗРАА БАНК, САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГАД БАРЬЦААЛСАН БАЙДЛЫН ТАЙЛАН**

Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1. дэх хэсэгт “Газар эзэмших эрхийн гэрчилгээг хуулиар зөвшөөрсөн хэлбэрээр бусдад шилжүүлж, барьцаалж болно. Эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх, барьцаалах үйл ажиллагаа нь зөвхөн Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд явагдана” гэж заасан ба газар эзэмших эрхийн гэрчилгээгээ барьцаалагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага улсын бүртгэлд бүртгүүлэхээр хуульчилсан билээ.

“Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ын 8 дугаар зүйлийн 8.8-д эрхийн гэрчилгээ барьцаалах болон эзэмшил газраа бусдад ашиглуулах хүсэлтийг тухайн шатны Засаг дарга зөвшөөрсөн тохиолдолд энэ тухай албан бичгийг үндэслэн газрын кадастрын мэдээллийн сантай бол мэдээллийн санд, байхгүй бол энэ журмын 5 дугаар хавсралт “Газар ашиглуулсан, барьцаалсан тухай бүртгэл”-д бүртгэж өргөдөл гаргагчид мэдэгдэнэ гэж заасан байдаг.

Тус заалтыг үндэслэн жил бүр аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, нийслэл, дүүргийн Газрын алба, сумын Газрын даамал газар ашиглуулсан, барьцаалсан бүртгэлийг бүртгэдэг ба бүртгэлийг жилийн эцсээр нэгтгэн тайлан гаргаж байна.

Тухайн бүртгэлээс харахад 2017 онд улсын хэмжээнд 10984 газар эзэмших эрхээ банк, санхүүгийн байгууллагад барьцаалсан байна. Мөн Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газраас авсан судалгаагаар 39409 Монгол Улсын иргэн өөрийн өмчийн газраа банк, санхүүгийн байгууллагад барьцаалсан ба нийт 50393


нэгж талбар /газар эзэмших эрх, өмчийн газар/ буюу Монгол Улсын нийт нэгж талбарын 4.5 хувь нь барьцаанд байна. Энэ нь өмнөх онуудаас өссөн дүнтэй байгаа бөгөөд газрын үр өгөөж нэмэгдэж, эдийн засгийн эргэлтэнд орж байгаагийн том илрэл гэж үзэж байна.

2017 онд газар эзэмших эрх болон өмчийн газраа барьцаалсан байдлыг улсын хэмжээнд нэгтгэн үзүүлэв /Хүснэгт 1.6.1, Зураг 1.6.1/.

**ХҮСНЭГТ 1.6.1: 2017 ОНД ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХ БОЛОН ӨМЧИЙН ГАЗРАА БАРЬЦААЛСАН БАЙДАЛ**

№	Аймаг, нийслэл	Барьцаалсан нэгж талбарын тоо	Үүнээс	
			Эзэмших	Өмчлөх
1	Архангай	295	153	142
2	Баян-Өлгий	1000	107	893
3	Баянхонгор	1971	524	1447
4	Булган	558	160	398
5	Говь-Алтай	814	561	253
6	Говьсүмбэр	800	151	649
7	Дархан-Уул	2339	409	1930
8	Дорнод	474	74	400
9	Дорноговь	526	365	161
10	Дундговь	809	161	648
11	Завхан	1115	391	724
12	Орхон	2524	130	2394
13	Өвөрхангай	2275	313	1962
14	Өмнөговь	1662	91	1571
15	Увс	2167	859	1308
16	Сүхбаатар	1090	82	1008
17	Сэлэнгэ	2227	361	1866
18	Төв	1365	67	1298
19	Ховд	1721	380	1341
20	Хөвсгөл	1070	320	750
21	Хэнтий	954	173	781
22	Нийслэл	22637	5152	17485
ДҮН		50393	10984	39409

ЗУРАГ 1.6.1: ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХЭЭ БОЛОН ӨМЧИЙН ГАЗРАА БАРЬЦААЛСАН БАЙДАЛ.




2017 онд улсын хэмжээнд эзэмших эрхийг банк, санхүүгийн байгууллагад барьцаалсан ба дээрх бүртгэлийг Улсын хэмжээнд нэгтгэн сүүлийн 5 жилийн мэдээтэй харьцуулав /Хүснэгт 1.6.2, Зураг 1.6.2/.

ХҮСНЭГТ 1.6.2: 2013-2017 ОНД УЛСЫН ХЭМЖЭЭНД ЭЗЭМШИХ ЭРХЭЭ БАНК, САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГАД БАРЬЦААЛСАН БАЙДАЛ

д/д	Аймаг, нийслэл	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он
1	Архангай	155	298	104	122	153
2	Баян-Өлгий	1940	533	934	31	107
3	Баянхонгор	334	1040	707	433	524
4	Булган	438	231	168	131	160
5	Говь-Алтай	2461	386	605	449	561
6	Говьсүмбэр	52	61	65	103	151
7	Дархан-Уул	469	1283	423	189	409
8	Дорнод	291	102	63	297	74
9	Дорноговь	237	352	93	35	365
10	Дундговь	148	57	50	73	161
11	Завхан	246	114	358	0	391
12	Орхон	376	136	42	744	130
13	Өвөрхангай	628	317	323	127	313
14	Өмнөговь	312	185	313	58	91
15	Увс	1242	970	966	130	859
16	Сүхбаатар	177	488	156	156	82
17	Сэлэнгэ	1010	882	1226	8	361
18	Төв	475	524	295	199	67
19	Ховд	140	393	449	392	380
20	Хөвсгөл	1374	615	499	343	320
21	Хэнтий	194	156	141	56	173
22	Нийслэл	0	913	828	4521	5152
	Нийт	12699	10036	8808	8597	10984

ЗУРАГ 1.6.2: ӨМНӨХ ОНЫ МЭДЭЭТЭЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ



2017 онд газар эзэмших эрхээ банк, санхүүгийн байгууллагад барьцаалсан бүртгэлийг өмнөх онтой харьцуулахад 1.27 хувиар өсч 10984 болсон байна.


2017 онд газар эзэмших эрхээ банк, санхүүгийн байгууллагад барьцаалсан байдлаас харахад 36 хувь нь Хаан банкинд, 19 хувь нь Төрийн банк, Голомт банк, Капитал банк, Худалдаа хөгжлийн банкинд, үлдсэн 44 хувь нь буюу бусад банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо гэх мэт өөр газарт барьцаалсан байна /Хүснэгт 1.6.3, Зураг 1.6.3./.

ХҮСНЭГТ 1.6.3: ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХЭЭ БАНК, САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГАД БАРЬЦААЛСАН БАЙДАЛ /ТООГООР/

Аймаг/ дүүрэг	Эзэмших эрхээ барьцаалсан	Барьцаалагч							
		Банк						Бусад	
		Хаан Банк	Төрийн банк	Хас банк	Голомт Банк	Худалдаа Хөгжлийн Банк	Бусад банк	ББСБ	Бусад
Архангай	153	53	27	49	8	1	9	3	3
Баян-Өлгий	107	35	11	4	9	5	23	0	20
Баянхонгор	524	402	18	22	5	0	61	13	3
Булган	160	82	10	16	1	3	6	22	20
Говь-Алтай	561	428	89	18	2	10	0	7	7
Говьсүмбэр	151	72	12	24	4	2	1	18	18
Дархан-Уул	409	178	41	29	33	75	12	23	18

Дорнод	74	27	13	8	15	6	3	1	1
Дорноговь	365	109	48	107	16	30	35	10	10
Дундговь	161	43	23	39	24	3	17	6	6
Завхан	391	150	68	156	0	0	5	11	1
Орхон	130	43	23	12	20	2	8	11	11
Өвөрхангай	313	103	37	20	32	12	85	12	12
Өмнөговь	91	31	25	10	4	12	7	1	1
Увс	859	582	86	102	40	3	21	25	0
Сүхбаатар	82	22	27	14	13	6	0	0	0
Сэлэнгэ	361	99	54	56	43	31	37	20	21
Төв	67	22	10	1	11	0	7	8	8
Ховд	380	153	145	19	46	9	4	2	2
Хөвсгөл	320	157	35	29	8	2	8	31	50
Хэнтий	173	100	6	14	21	10	2	10	10
Нийслэл	5152	1024	188	127	258	348	2802	258	147
Нийт дүн	10984	3915	996	876	613	570	3153	492	369

ЗУРАГ 1.6.3: ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙГ БАНК, САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГАД БАРЬЦААЛСАН БАЙДАЛ



Газар эзэмших эрх болон өмчийн газрыг банк, санхүүгийн байгууллагад барьцаалан санхүүгийн эх үүсвэр бүрдүүлж буй хугацааны хувьд дунджаар 1.26 жил байна.

## 1.7. ГАЗРЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

Газар, газар дээрх үл хөдлөх эд хөрөнгийн зах зээлийн үнэ ханш, эрэлт хэрэгцээ, ханган нийлүүлэлтийг жигд тогтвортой байлгах, энэ талаарх мэдээллээр олон нийтэд үйлчилгээ үзүүлэх, мэдээллийг нээлттэй ил тод болгох, газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулах, татвар, төлбөр авах замаар Монгол улсын эдийн засгийн хөгжилд бодитой дэмжлэг үзүүлэхэд газрын зах зээлийн асуудлууд чухал юм. Мөн газрыг татвар, төлбөрийн, барьцаат зээллэгийн, арилжааны, дуудлага худалдааны, хөрөнгө оруулалтын, нөхөн олговрын, шүүхийн, шинжээчийн, судалгааны зэрэг олон зориулалтаар мэргэжлийн үүднээс үнэлэх шаардлага, эрэлтийг бий болгосоор байна.

Иймээс Газрын харилцаа, барилга, геодези, зураг зүйн газар /хуучин нэрээр/-ын даргын 2011 оны 182 тоот тушаалаар “Газар, үл хөдлөх эд хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээ цуглуулах заавар, маягт”-ыг баталгаажуулан хэрэгжүүлж байна.

Газрын татвар, төлбөрийг зах зээлийн бодит үнэнд ногдуулах, дуудлага худалдааны анхны үнэ, барьцаа зээлийн үнэ, нөхөн олговрын үнэ, худалдан борлуулах үнийг зах зээлийн нөхцөл байдалд нийцүүлэн бодитойгоор тогтоох зорилгоор дээрх заавар, маягтын дагуу улирал бүр газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээг гэр бүлийн хэрэгцээний зориулалттай /ГХ/, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалттай /ХАА/, худалдаа үйлчилгээний зориулалттай /ХҮ/, хөдөө аж ахуйн газраас бусад үйлдвэрлэлийн зориулалттай /Ү/ гэсэн 4 төрлөөр цуглуулж байна.

Газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээг бүрдүүлж, дүн шинжилгээ хийх, мэдээллийн сан байгуулах үүднээс Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас Газрын биржийн цахим системийг хэрэглээнд нэвтрүүлээд байгаа бөгөөд тус системийг ашиглан нийслэлийн Газрын алба, 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, дүүргүүдийн Газрын алба, сумдын Газрын даамлууд газрын зах зээлийн үнийн мэдээг цуглуулж байна.

Мөн үл хөдлөх хөрөнгийн зуучийн “Тэнхлэг зууч” ХХК-тай хамтран газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээг бүрдүүлж, дүн шинжилгээ хийх, мэдээллийн сан байгуулахаар, Монголын Нотариатчдын танхим, Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институтээр дамжуулан газрын зах зээлийн үнийн мэдээг цуглуулах боломжийг бүрдүүлэхээр тус тус ажиллаж байна.

Тайлант оны байдлаар Газрын биржийн цахим системд нийт 13210 газрын газар, үл хөдлөх эд хөрөнгийн үнийн мэдээ бүртгэгдээд байгаа бөгөөд үүнээс тайлант онд 2431 газрын зах зээлийн үнийн мэдээ бүртгэгдсэнээс гэр бүлийн хэрэгцээний зориулалттай 2144, худалдаа үйлчилгээний зориулалттай 180, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалттай 78, хөдөө аж ахуйн газраас бусад үйлдвэрлэлийн зориулалттай 29 үнийн мэдээг тус тус бүрдүүлсэн байна.




■ ХҮСНЭГТ 1.7.1: ГАЗРЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНИЙН МЭДЭЭ ЦУГЛУУЛСАН БАЙДАЛ

№	Аймаг/ нийслэл	Нийт үнийн мэдээ	Үүнээс							
			Гэр бүлийн хэрэгцээний газар	Үүнээс		Худалдаа үйлчилгээний газар	Үүнээс		Хөдөө аж ахуйн газар	Үйлдвэрийн газар
				Үл хөдлөх хөрөнгөтэй	Үл хөдлөх хөрөнгөгүй		Үл хөдлөх хөрөнгөтэй	Үл хөдлөх хөрөнгөгүй		
1	Нийслэл	192	163	32	131	13	9	4	3	13
2	Архангай	85	72	40	32	9	4	5	4	-
3	Баян-Өлгий	52	25	19	6	17	14	3	5	5
4	Баянхонгор	95	83	21	62	6	6	-	3	3
5	Булган	64	42	25	17	12	6	6	10	-
6	Говь-Алтай	171	152	27	125	12	12	-	5	2
7	Говьсүмбэр	12	9	6	3	3	1	2	-	-
8	Дархан-Уул	253	238	139	99	5	4	1	9	1
9	Дорноговь	175	126	29	97	41	13	28	8	-
10	Дорнод	2	2	-	2	-	-	-	-	-
11	Дундговь	100	99	30	69	1	1	-	-	-
12	Завхан	31	24	10	14	4	2	2	1	2
13	Орхон	437	425	124	301	12	-	12	-	-
14	Өвөрхангай	53	50	18	32	2	1	1	1	-
15	Өмнөговь	71	69	26	43	2	-	2	-	-
16	Сэлэнгэ	22	12	9	3	8	1	7	2	-
17	Сүхбаатар	24	19	3	16	5	5	-	-	-
18	Төв	126	122	7	115	-	-	-	4	-
19	Увс	68	56	21	35	4	4	-	8	-
20	Ховд	168	165	150	15	2	1	1	1	-
21	Хэнтий	50	36	15	21	11	6	5	3	-
22	Хөвсгөл	180	155	48	107	11	6	5	11	3
Нийт дүн		2,431	2,144	799	1,345	180	96	84	78	29


Зах зээлийн үнийн мэдээний 88 хувийг гэр бүлийн хэрэгцээний зориулалттай, 8 хувийг худалдаа үйлчилгээний зориулалттай, 3 хувийг хөдөө аж ахуйн зориулалттай, 1 хувийг үйлдвэрлэлийн зориулалттай газрын үнийн мэдээ тус тус эзэлж байна.

ЗУРАГ 1.7.1: ГАЗРЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНИЙН МЭДЭЭНИЙ ЭЗЛЭХ ХУВЬ.



Нийт цуглуулсан үнийн мэдээний хувьд 2236 буюу 92 хувь нь шууд худалдагдсан үнэ байна. Мөн дуудлага худалдаагаар худалдагдсан үнийн мэдээ нийт үнийн мэдээний 5 хувийг, үнэлэгдсэн болон худалдахаар санал болгож буй үнэ үлдсэн 3 хувийг нь эзэлж байна.


ЗУРАГ 1.7.2: ГАЗРЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНИЙН МЭДЭЭНИЙ ТӨРӨЛ.



Үнийн мэдээний эх сурвалжийн хувьд газрын эрхээ шилжүүлж байгаа 988 иргэнээс, шилжүүлж авч байгаа 1313 иргэнээс болон бусад эх сурвалжаас 130 үнийн мэдээг бүрдүүлсэн байна.

Мөн нийт цуглуулсан үнийн мэдээг эрхийн төрлөөр нь ангилахад 960 өмчилсөн газрын, 946 эзэмшил газрын, 525 ашиглалтын газрын үнийн мэдээ бүртгэгдсэн байна.


ЗУРАГ 1.7.3: ГАЗРЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНИЙН МЭДЭЭНИЙ ЭРХИЙН ТӨРӨЛ.



### ГЭР БҮЛИЙН ХЭРЭГЦЭЭНИЙ ГАЗАР

Газрын биржийн цахим системд бүртгэгдсэн 2144 гэр бүлийн хэрэгцээний газрын үнийн мэдээнд дүн шинжилгээ хийж үзэхэд газрын үнэ нь байршил, орон нутгийн эдийн засаг, нийгмийн байдлаас хамаарч харилцан адилгүй, эрс зөрүүтэй байгаа тул газрын үнийг улсын хэмжээнд дундажлан гаргах боломжгүй байна. Иймд аймаг тус бүрээр нь газрын дундаж үнийг тооцон гаргалаа.

ЗУРАГ 1.7.4: ГЭР БҮЛИЙН ХЭРЭГЦЭЭНИЙ М.КВ ГАЗРЫН ДУНДАЖ ҮНЭ




Тайлант хугацаанд гэр бүлийн хэрэгцээний газрын дундаж үнэ нийслэл Улаанбаатар хотод хамгийн өндөр бөгөөд нэг айлын 0.07 га газрын дундаж үнэ хөрөнгө оруулалт хийгдээгүй бол 16,736,300 төгрөг, хөрөнгө оруулалт хийгдсэн бол 29,750,000 төгрөгөөр эдийн засгийн эргэлтэнд орж байна. Энэ нь байршлаас хамаарч харилцан адилгүй байна. Тухайлбал: Сонгинохайрхан дүүргийн 7 дугаар хороонд дунджаар нэг айлын хөрөнгө оруулалт хийгдсэн газар 31,507,463 төгрөгөөр, хөрөнгө оруулалт хийгдээгүй газар 7,680,000 төгрөгөөр зарагдаж байгаа бол Баянгол дүүргийн 11 дугаар хороонд дунджаар нэг айлын хөрөнгө оруулалт хийгдсэн газар 55,875,000 төгрөгөөр, хөрөнгө оруулалт хийгдээгүй газар 21,000,000 төгрөгөөр зарагдаж байна.

Аймгуудын хувьд хөрөнгө оруулалт хийгдсэн гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын дундаж үнэ Дундговь, Завхан, Увс, Ховд, Сэлэнгэ, Дорноговь аймагт 14.0 -18.0 сая төгрөг, Өвөрхангай, Баянхонгор, Архангай, Баян-Өлгий, Булган, Төв, Говьсүмбэр, Орхон, Говь-Алтай аймагт 7.0-14.0 сая төгрөг бусад аймагт 5.0-7.0 сая төгрөг байна.

## ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОРИУЛАЛТТАЙ ГАЗАР

Улсын хэмжээнд худалдаа үйлчилгээний зориулалттай газрын зах зээлийн үнийн мэдээнд дүн шинжилгээ хийж үзэхэд дараах байдалтай байна.

■ ЗУРАГ 1.7.5: ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОРИУЛАЛТТАЙ ГАЗРЫН ДУНДАЖ ҮНЭ




Жишээ нь Архангай аймагт 0.05 га худалдаа үйлчилгээний зориулалттай газрын үнэ 15-17.7 сая төгрөг байгаа бол Улаанбаатар хотод 70-200 сая төгрөг байна.

## ХАА-Н ЗОРИУЛАЛТТАЙ ГАЗАР

Улсын хэмжээнд хөдөө аж ахуйн зориулалттай /Төмс, хүнсний ногоо тариалан, Жимс, жимсгэний усалгаагүй тариалан, Үр тарианы усалгаагүй тариалан, Өвөлжөө, хаваржааны/ газрын зах зээлийн үнийн үнийн мэдээнд дүн шинжилгээ хийж үзэхэд дараах байдалтай байна.


■ ЗУРАГ 1.7.6: ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ГАЗРЫН ДУНДАЖ ҮНЭ



## ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР

Үйлдвэрийн зориулалттай газрын зах зээлийн үнийн мэдээнд төмс, хүнсний ногоо тариалах зориулалттай газар болон үр тариа тариалах зориулалттай газрын зах зээлийн үнийн мэдээ байна. Тайлант онд Баян-Өлгий, Баянхонгор, Завхан, Хөвсгөл аймаг болон Улаанбаатар хотын үйлдвэрийн зориулалттай газрын үнэ бүртгэгдсэн.

■ ЗУРАГ 1.7.7: ҮЙЛДВЭР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОРИУЛАЛТТАЙ ГАЗРЫН ДУНДАЖ ҮНЭ.




2017 оны байдлаар улсын хэмжээнд 1036117 нэгж талбар бүртгэгдсэн ба үүнээс 76746 нь буюу 4.58 хувь нь газрын зах зээлийн эргэлтэнд оржээ /Хүснэгт 1.7.2, Зураг 1.7.8./.

■ ХҮСНЭГТ 1.7.2: ГАЗАР ӨМЧЛӨГЧ, ЭЗЭМШИГЧИЙН ЭРХИЙН ӨӨРЧЛӨЛТӨНД ОРСОН БАЙДАЛ

Он	Газар эзэмших эрхийн өөрчлөлт	Үүнээс		Газар өмчлөх эрхийн өөрчлөлт	Үүнээс		
		Газар эзэмших эрхээ шилжүүлсэн	Газар эзэмших эрхээ барьцаалсан		Газар өмчлөх эрхээ худалдсан	Газар өмчлөх эрхээ бэлгэлсэн	Газар өмчлөх эрхээ барьцаалсан
2014 он	14742	5521	9221	44025	8341	4982	30702
2015 он	14684	5876	8808	41521	7011	4406	30104
2016 он	23949	10848	13101	42105	7284	3525	31296
2017 он	24344	10984	13360	52409	9117	3876	39409

■ ЗУРАГ 1.7.8: ГАЗАР ӨМЧЛӨГЧ, ЭЗЭМШИГЧИЙН ЭРХИЙН ӨӨРЧЛӨЛТӨНД ОРСОН БАЙДАЛ



2017 онд 20755 га газар буюу ойролцоогоор нийт газар нутгийн **0.012** хувь нь эдийн засгийн эргэлтэнд орсон байна. Харин газар өмчлөх, эзэмших эрхийн санхүүгийн эргэлтийн хэмжээ 949 тэрбум төгрөг болж, 25 хувиар нэмэгдсэн судалгаа гарсан байна.

Тухайн тайлант онд Үндэсний статистикийн хорооны гаргасан судалгаагаар Монгол улсын ДНБ 27167.0 тэрбум төгрөг ба үүнээс газрын зах зээлийн санхүүгийн эргэлтийн хэмжээ ДНБ-ний **3.4%** эзэлж байна.

Үүнээс үзэхэд Монгол улсын нийт үл хөдлөх эд хөрөнгийг улсын бүртгэлд бүртгэж, газрыг нягтлан бодох бүртгэлд бүртгэж, газрын зах зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрлийг иргэд, олон нийтийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн бий болговол ДНБ-ний хэмжээг өсгөх нөөц боломж байгаа нь харагдаж байна.

Хэдийгээр ДНБ-д газрын зах зээлийн санхүүгийн эргэлтийн эзлэх хувь нэмэгдэж байгаа ч Монгол улсад газар эзэмших, ашиглах эрхийг нягтлан бодох бүртгэлд өмч гэж үзэж бүртгэхгүй байсаар байна.

Иймд улсын хэмжээнд газрын суурь үнийг зах зээлийн нөхцөл байдалд нийцүүлэн шинэчлэн тогтоож, зах зээлийг нээлттэй уян хатан болгосноор газраас хүртэх эдийн засгийн өгөөжийг нэмэгдүүлэх боломж бүрдэнэ.

## 1.8. ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ЭРХИЙН ДУУДЛАГА ХУДАЛДАА, ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ТАЛААРХ МЭДЭЭ, ТАЙЛАН

### А. ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ЭРХИЙН ДУУДЛАГА ХУДАЛДАА

2017 онд улсын хэмжээнд 583 удаа газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдааг зохион байгуулснаас 380 дуудлага худалдаа хүчинтэй болж, 8007.27 га газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлжээ. Энэ нь өмнөх оныхтой харьцуулж үзвэл газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа зохион байгуулсан тоо 13.2 хувиар буурсан бол эзэмшүүлсэн газрын хэмжээ 3884.56 га-гаар нэмэгдсэн байна /Хүснэгт 1.8.1/.

#### ХҮСНЭГТ 1.8.1: 2017 ОНД ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ЭРХИЙН ДУУДЛАГА ХУДАЛДАА ЗОХИОН БАЙГУУЛСАН БАЙДАЛ

№	Аймаг, нийслэл	Дуудлага худалдаа зохион байгуулсан тоо		Газрын хэмжээ /м2/		Төсөвт орсон орлого /мян.төг/	
		2016 он	2017 он	2016 он	2017 он	2016 он	2017 он
1	Архангай	92	60	5,220,914	10,392,979	83,283.99	171,281.91
2	Баян-Өлгий		3		13,164		75,014.00
3	Баянхонгор	5	14	1,670	30,617	7,002.00	28,991.40
4	Булган	51	45	2,728,604	129,815	125,434.44	70,253.14
5	Говь-Алтай						
6	Говьсүмбэр	3	11	73,150	48,236	7,620.00	49,068.80
7	Дархан-Уул	26	29	171,929	205,146	210,270.00	406,800.00
8	Дорноговь	164	96	1,182,594	3,835,300	182,464.77	1,202,510.07

9	Дорнод	33	36	24,206,297	40,245,701	852,179.17	556,710.33
10	Дундговь	7	5	7,877	4,900	5,550.00	
11	Завхан		2		1,400		244.00
12	Орхон	28	25	19,359	41,695	389,920.00	420,320.00
13	Өвөрхангай	15	12	2,491,300	22,000	12,477.44	39,070.00
14	Өмнөговь	1	10	10,000	181,400	10,758.00	67,760.00
15	Увс	3	16	12,000	9,800	6,870.00	35,444.00
16	Сүхбаатар	4	5	300	40,000	2,000.00	14,640.00
17	Сэлэнгэ	27	11	75,964	17,796	61,731.33	43,172.67
18	Төв	78	24	1,812,565	1,988,500	198,565.28	212,101.35
19	Ховд	13	6	4,325	4,500	9,893.00	5,856.00
20	Хөвсгөл	30	46	170,031	231,525	29,402.20	93,953.76
21	Хэнтий	90	91	3,025,558	20,967,600	100,113.56	45,898.09
22	Нийслэл	2	36	12,700	1,660,670	86,484.07	765,606.85
	ДҮН	672	583	41,227,137	80,072,744	2,382,019.26	4,304,696.36


2017 онд Архангай, Булган, Дорноговь, Хөвсгөл, Хэнтий аймгууд хамгийн олон буюу 50-иас дээш газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа, Баян-Өлгий, Дундговь, Завхан, Сүхбаатар, Ховд аймгууд, нийслэл хамгийн бага буюу 6-аас доош газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа зохион байгуулсан бол Говь-Алтай аймаг газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдааг зохион байгуулаагүй байна.

Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдааг зохион байгуулсан байдлыг сум тус бүрээр авч үзвэл Архангай, Булган, Дорноговь, Хэнтий аймгийн бүх сумд газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдааг тогтмол зохион байгуулж байгаа бөгөөд Архангай аймгийн Цахир сум, Булган аймгийн Рашаант сум, Дархан-Уул аймгийн Дархан сум, Дорноговь аймгийн Сайншанд сум, Орхон аймгийн Баян-Өндөр сум, Төв аймгийн Зуунмод сум, Хэнтий аймгийн Бор-Өндөр сумд, нийслэлийн Хан-Уул дүүрэг хамгийн олон буюу 15-аас дээш газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдааг зохион байгуулжээ.

2016 он, 2017 онд газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа явуулсан тоог аймаг, нийслэлээр харьцуулан дараах зурагт үзүүлэв. /Зураг 1.8.1/.




ЗУРАГ 1.8.1: 2016 ОН, 2017 ОНД ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ЭРХИЙН ДУУДЛАГА ХУДАЛДАА ЯВУУЛСАН ТОО



2017 онд 583 удаагийн дуудлага худалдааг зохион байгуулснаас 201 удаагийн буюу 34.5 хувь нь хүчингүй болсон ба үүнээс 209 удаагийн буюу 86.3 хувь нь оролцогчгүйн улмаас хүчингүй болж, 32 удаагийн буюу нийт зохион байгуулсан дуудлага худалдааны 13.7 хувь нь дуудлага худалдааны үнийг “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-д заасан хугацаанд төлөөгүй байна /Зураг 1.8.2/.

ЗУРАГ 1.8.2: ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ ОРОЛЦОГЧИЙН ЭЗЛЭХ ХУВЬ




Мөн дуудлага худалдаанд 1 оролцогч оролцсон тохиолдол 3.6 хувийг, 2 оролцогч оролцсон тохиолдол 41.9 хувийг эзэлж байна.

Дээрхээс харахад танхимын дуудлага худалдааны зар олон нийтэд хүрэхгүй, дуудлага худалдаанд оролцохоор сонирхсон этгээд байршлаас шалтгаалан оролцож чадахгүй байх, мөн дуудлага худалдааны анхны үнэ өндөр зэрэг асуудлуудаас хамаараад дуудлага худалдаа хүчингүй болох тохиолдол их байна.

Засгийн газрын 2010 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-д цахим хэлбэрээр дуудлага худалдааг зохион байгуулахаар журамласны дагуу 2016 онд Сэлэнгэ, Ховд, Хэнтий зэрэг 3 аймаг цахим дуудлага худалдаа зохион байгуулсан бол 2017 онд Архангай, Баян-Өлгий, Булган, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Хэнтий, Хөвсгөл зэрэг 12 аймаг дуудлага худалдааг цахим хэлбэрээр зохион байгуулсан байна.

2017 онд газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаагаар улсын хэмжээнд нийт 4 тэрбум 304 сая 696 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлснээс Дорноговь аймгаас 27.9 хувь буюу 1 тэрбум 202 сая төгрөг, нийслэлээс 17.8 хувь буюу 765 сая төгрөг, Дорнод аймгаас 12.9 хувь буюу 556 сая төгрөг, Орхон аймгаас 9.8 хувь буюу 420 сая төгрөг, Дархан-Уул аймгаас 9.5 хувь буюу 406 сая төгрөгийг тус тус төвлөрүүлснээр тэргүүлж байна /Зураг 1.8.3/.

ЗУРАГ 1.8.3: 2016-2017 ОНД УЛСЫН ХЭМЖЭЭНД ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ЭРХИЙН ДУУДЛАГА ХУДАЛДААГААР УЛСЫН ТӨСӨВТ ОРСОН ОРЛОГО /МЯН.ТӨГ/



2016 онд газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдааны орлогоос орон нутгийн төсөвт 2.4 тэрбум төгрөг төвлөрүүлж байсан бол уг дүн 2017 онд 80.7 хувиар нэмэгдсэн байна.

Дуудлага худалдааны ялагчийн 71.6 хувь нь иргэн байгаа бол үлдсэн 28.4 хувь нь аж ахуйн нэгж байна.

## Б. ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ЭРХИЙН ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ

2017 онд Улсын хэмжээнд 304 удаа газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулснаас 238 хүчинтэй болж 3473.72 га газрыг эзэмшүүлжээ. Энэ нь өмнөх онтой харьцуулж үзвэл газар эзэмшүүлэх эрхийн төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулсан тоо 22.4 хувиар, эзэмшүүлсэн газрын хэмжээ 3758.18 га-гаар тус тус буурсан байна /Хүснэгт 1.8.2/.

### ■ ХҮСНЭГТ 1.8.2: 2017 ОНЫ ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН МЭДЭЭ

№	Аймаг, нийслэл	Төсөл сонгон шалгаруулалт явуулсан тоо		Төсөл сонгон шалгаруулалтаар эзэмшүүлсэн газрын талбайн хэмжээ /м2/	
		2016 он	2017 он	2016 он	2017 он
1	Архангай	29	20	889,180	161,938
2	Баян-Өлгий	1	1	14,000	216
3	Баянхонгор	4	16	53,000	10,746,653
4	Булган	30	4	182,498	195,000
5	Говь-Алтай	4	3	5,200	473
6	Говьсүмбэр	3	13	1,003,500	3,836,500
7	Дархан-Уул	71	59	2,193,723	2,025,505
8	Дорноговь	63	16	11,994,873	2,448,800
9	Дорнод		1		300,000
10	Дундговь	2	3	2,051	20,900
11	Завхан		1		1,400
12	Орхон	22	3	32,893	20,305
13	Өвөрхангай	26	22	13,531,400	1,677,345
14	Өмнөговь	26	18	17,881,800	217,400
15	Увс		2		3,200
16	Сүхбаатар				
17	Сэлэнгэ	4	3	120,000	10,500
18	Төв	36	44	438,100	7,450,000
19	Ховд		8		150,000
20	Хөвсгөл	3	3	21,200	21,200
21	Хэнтий	55	64	22,905,500	5,449,823
22	Нийслэл	13		1,050,000	
ДҮН		392	304	72,318,918	34,737,158


Улсын хэмжээнд Дархан-Уул, Төв, Хэнтий аймгууд хамгийн олон буюу 44-өөс дээш газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулсан бол Баян-Өлгий, Завхан, Дорнод аймгууд хамгийн бага буюу тус бүр 1 газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулсан, харин Сүхбаатар аймаг, нийслэл газар эзэмшүүлэх, төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулаагүй байна.

Газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулсан байдлыг сум,

дүүрэг тус бүрээр авч үзвэл Баянхонгор аймгийн Өлзийт сум, Говьсүмбэр аймгийн Сүмбэр сум, Дархан-Уул аймгийн Дархан сум, Орхон сум, Өвөрхангай аймгийн Тарагт сум, Өмнөговь аймгийн Цогтцэций сум, Төв аймгийн Сэргэлэн сум, Хэнтий аймгийн Хэрлэн, Дэлгэрхаан сумд хамгийн олон буюу 10-аас дээш газар эзэмшүүлэх эрхийн төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулжээ.

2016 он, 2017 онд газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалт явуулсан тоог аймаг, нийслэлээр харьцуулж харуулав. /Зураг 1.7.5/.

ЗУРАГ 1.8.4: 2016-2017 ОНД ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ ЯВУУЛСАН ТОО



2017 онд 304 газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулснаас 54 удаагийн буюу 17.8 хувь нь төсөл ирээгүйн улмаас хүчингүй болжээ /Зураг 1.8.5/.

ЗУРАГ 1.8.5: ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ОРОЛЦОГЧИЙН ЭЗЛЭХ ХУВЬ



Төсөл сонгон шалгаруулалтын ялагчийн 59 хувь нь аж ахуйн нэгж бол үлдсэн 41 хувь нь иргэн байна.

Төсөл сонгон шалгаруулалтаар газар эзэмшүүлэхдээ улсын хэмжээнд үр тариа, төмс хүнсний ногоо, шатахуун түгээх станц, аялал жуулчлал, худалдаа үйлчилгээ, зочид буудал, авто угаалга, авто засвар гэх мэт зориулалтуудаар зохион байгуулсан нь “Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах журам”-ын 3 дугаар хэсэгт заасныг зөрчиж байгаа юм.

Харин 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар Газрын тухай хуулийн 33.5. /Энэ хуулийн 33.1.2-т заасны дагуу төсөл шалгаруулах хэлбэрээр газар эзэмших эрхийг зөвхөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эсхүл гадаад улс, олон улсын байгууллагын буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрт зориулж олгоно/ нэмсэн. Энэхүү нэмэлт өөрчлөлт нь 2018 оны 1 дүгээр сараас эхэлж хэрэгжих бөгөөд энэ хууль хэрэгжсэнээр дээрх зөрчил гарахгүй байх нөхцөл бүрдээд байна.

Газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтаар эзэмшүүлсэн хугацааны хувьд авч үзвэл ихэвчлэн 15 жилээр эзэмшүүлсэн байна.


## 1.9. ГАЗРЫН КАДАСТРЫН СУДАЛГАА, ХЭМЖИЛ, ЗУРАГЛАЛ

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар нь Газрын тухай хууль, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль шинэчлэгдэн батлагдсанаас хойш хуульд заасан чиг үүргийнхээ хүрээнд Монгол Улсын хэмжээнд геодезийн сууриар баталгаажсан, кадастрын зурган мэдээлэлд суурилсан, газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэл, цахимжсан хувийн хэрэг бүхий иргэдийн газар ашиглахтай холбоотой өргөдөл, бүртгэл, түүний шийдвэрлэлтийг автоматжуулсан, иргэд, олон нийтэд нээлттэй, нийгэм, эдийн засгийн олон талт эрэлт, хэрэгцээг хангах газрын кадастрын мэдээллийн систем байгуулахаар зорьж ирсэн.

Энэхүү зорилтын хүрээнд Газрын кадастрын мэдээллийн сангийн “Лэнд менежер” програм хангамжийг 21 аймаг, 330 суманд бүрэн нэвтрүүлээд байна.

Мөн иргэд, олон нийтэд Газрын кадастрын мэдээллийн сангийн мэдээллээр онлайнаар үйлчлэх зорилго бүхий <http://www.egazar.gov.mn> хаягийг байршуулан хэрэглээнд нэвтрүүлээд байна.


### ЗУРАГ 1.9.1: WEBGIS ПРОГРАМ ХАНГАМЖИЙН ХАРАГДАЛТ



Улсын хэмжээнд Газрын кадастрын мэдээллийн санд 2016 онд 595566 нэгж талбар улсын бүртгэлд бүртгэгдсэн ба 2017 оны сүүлийн байдлаар 645558 нэгж талбар болж 49992 нэгж талбараар нэмэгдсэн байна.

Тайлант онд 700 нэгж талбарыг хуваах буюу нэгтгэж, 6131 нэгж талбарын талбайн хэмжээ өөрчлөгдөж, 40371 нэгж талбар болон 13488 барилга нэмэгдэж, 3145 нэгж талбар хасагдан Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэгдсэн байна.


ЗУРАГ 1.9.2: ТАЙЛАНТ ОНД ГАЗРЫН КАДАСТРЫН МЭДЭЭЛЛИЙН САНД ӨӨРЧЛӨЛТ ОРСОН БАЙДАЛ



2017 онд 7932 нэгж талбарын газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн мэдээлэл өөрчлөгдөн бүртгэгдэж, эрхийн шилжилт хөдөлгөөн хийгдсэн байна.

Үүнээс газар өмчлөх эрхийн шилжсэн 4252 нэгж талбар, газар эзэмших эрх шилжсэн 3663 нэгж талбар, газар ашиглах эрх шилжсэн 17 нэгж талбар байна.

ЗУРАГ 1.9.3: ГАЗРЫН ЭРХИЙН ШИЛЖИЛТ ХИЙГДСЭН НЭГЖ ТАЛБАРЫН ТОО



Барилга, хот байгуулалтын Сайдын 2015 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 246 дугаар тушаалын дагуу Геодези, зураг зүйн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий 207 аж ахуйн нэгж, газар зохион байгуулалт, газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллагын эрх бүхий 58 аж ахуйн нэгж байгаагаас 21 хэмжээнд 35 аж ахуйн нэгж кадастрын хэмжилт, зураглалын ажлыг хийж гүйцэтгэж байна.

## 1.10. ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН 2017 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, 2018 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

### 1.10.1. ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН 2017 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ


#### ХОТ, ТОСГОН, БУСАД СУУРИН ГАЗРЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ:

Улсын хэмжээнд сумдын газар зохион байгуулалтын 2017 оны төлөвлөгөөний хот, тосгон бусад суурины ангиллын газарт нийт 83998 байршил бүхий 193701.75 га газрыг төлөвлөснөөс 35018 байршилд 156667.57 га газрыг өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.


ХҮСНЭГТ 1.10.1.1: ХОТ, ТОСГОН БУСАД СУУРИНЫ АНГИЛЛЫН ГАЗАР ДАХЬ ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН 2017 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ

№	Аймаг, нийслэл	Төлөвлөсөн		Хэрэгжсэн	
		Газрын хэмжээ	Газар зохион байгуулалтын 2017 оны төлөвлөгөөнд тусгагдсан байршлын тоо	Газрын хэмжээ	Газар зохион байгуулалтын 2017 оны төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн байршлын тоо
1	Архангай	276.01	2644	82.79	934
2	Баян-Өлгий	451.76	2428	167.02	760
3	Баянхонгор	1661.60	604	1479.76	363
4	Булган	811.08	2595	394.29	1290
5	Говь-Алтай	1844.55	974	81.27	784
6	Говь-Сүмбэр	3618.67	1941	527.02	1688
7	Дархан-Уул	547.01	188	259.66	75
8	Дорноговь	86873.17	589	85718.95	423
9	Дорнод	1986.99	4817	332.78	2457
10	Дундговь	1262.43	3323	1320.92	2292
11	Завхан	318.88	1041	253.16	801
12	Орхон	88.60	64	345.49	76
13	Өвөрхангай	834.46	3469	616.68	768
14	Өмнөговь	23026.35	5414	19329.36	2496
15	Сүхбаатар	1415.95	1653	77.72	802
16	Сэлэнгэ	29222.52	10379	22377.72	2317
17	Төв	20343.44	31282	13507.30	10431
18	Увс	673.24	1607	507.36	678
19	Ховд	3707.81	3576	1070.78	507
20	Хөвсгөл	3281.04	3295	532.65	1348
21	Хэнтий	979.33	1413	781.07	629
22	Улаанбаатар	10476.85	698	6903.79	3096
	Нийт дүн	193701.75	83998	156667.57	35018

ЗУРАГ 1.10.1.1: ХОТ, ТОСГОН, БУСАД СУУРИН ГАЗРЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ БАЙРШЛЫН ТООГООР НЬ 2016, 2017 ОНТОЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ



ЗУРАГ 1.10.1.2: ХОТ СУУРИНЫ АНГИЛЛЫН ГАЗРЫН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУССАН АРГА ХЭМЖЭЭ /ТАЛБАЙН ХЭМЖЭЭ ГА-ГААР/






Газар зохион байгуулалтын 2016 оны хот, тосгон бусад суурины ангиллын газрын төлөвлөгөөний хэрэгжилтийг 2017 онтой харьцуулахад Говьсүмбэр аймаг 87.0 хувь, Говь-Алтай аймаг 80.5 хувь, Завхан аймаг 76.9 хувь, Дорноговь аймаг 71.8 хувь, Дундговь аймаг 69.0 хувьтай байгаа нь хэрэгжилт сайн байна.

Харин төлөвлөгөөний хэрэгжилт хангалтгүй Ховд аймаг 14.2 хувь, Өвөрхангай аймаг 22.1 хувь, Сэлэнгэ аймаг 22.3 хувь, Баян-Өлгий аймаг 31.3 хувь Төв аймаг 33.3 хувьтай байгаа нь хэрэгжилт хангалтгүй биелэлттэй байна.

ЗУРАГ 1.10.1.2: 2016-2017 ОНЫ ГЗБТ-НИЙ ХЭРЭГЖҮҮЛЭЛТИЙН ХАРЬЦУУЛАЛТ /%-ИАР/



## ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭРЭГЖИЛТ


Улсын хэмжээнд сумдын газар зохион байгуулалтын 2017 оны төлөвлөгөөний хөдөө аж ахуйн ангиллын газарт нийт 13803 байршил бүхий 7002198.33 га газрыг төлөвлөснөөс 31180 байршилд 5108025.62 га газрыг эзэмшүүлэх болон өмчлүүлэх, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

ХҮСНЭГТ 1.10.1.2: ХӨДӨӨ АЖ АХУЙН АНГИЛЛЫН ГАЗАР ДАХЬ ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН 2017 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ


№	Аймаг, нийслэл	Төлөвлөсөн		Хэрэгжсэн	
		Газрын хэмжээ	Газар зохион байгуулалтын 2017 оны төлөвлөгөөнд тусгагдсан байршлын тоо	Газрын хэмжээ	Газар зохион байгуулалтын 2017 оны төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн байршлын тоо
1	Архангай	75826.36	237	38663.08	120
2	Баян-Өлгий	13441.37	361	3362.59	155
3	Баянхонгор	704266.92	809	570405.10	309
4	Булган	286161.46	787	271146.71	460
5	Говь-Алтай	1638916.51	844	1271428.41	602
6	Говь-Сүмбэр	1363.37	94	42325.07	20100
7	Дархан-Уул	490.89	26	497.19	20
8	Дорноговь	586.70	622	278.90	300

9	Дорнод	241827.83	680	124606.47	335
10	Дундговь	38511.96	722	38229.70	834
11	Завхан	145545.33	712	145146.42	629
12	Орхон	19526.65	38	14534.02	18
13	Өвөрхангай	228606.46	720	194922.61	548
14	Өмнөговь	24250.49	954	24255.19	961
15	Сүхбаатар	164546.64	260	153878.10	234
16	Сэлэнгэ	144405.69	326	147335.40	2220
17	Төв	243146.35	1240	229820.15	913
18	Увс	1302246.01	637	314542.92	456
19	Ховд	858.00	1089	241.05	581
20	Хөвсгөл	1656941.35	2239	1463121.54	1028
21	Хэнтий	70732.00	405	59285.00	356
22	Улаанбаатар	0.00	0	0.00	0
Нийт		7002198.33	13803	5108025.62	31180

ЗУРАГ 1.10.1.3: ХАА-Н АНГИЛЛЫН ГАЗРЫН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУССАН АРГА ХЭМЖЭЭ /БАЙРШЛЫН ТООГООР/



ЗУРАГ 1.10.1.4: ХАА-Н АНГИЛЛЫН ГАЗРЫН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУССАН АРГА ХЭМЖЭЭ /ТАЛБАЙН ХЭМЖЭЭГЭЭР, ГА/




Аймаг, орон нутаг хөдөө аж ахуйн ангиллын газар дахь газар зохион байгуулалтын асуудалд зохих хэмжээгээр анхаарлаа хандуулж, төлөвлөдөг болсон нь сайшаалтай байна. Хөдөө аж ахуйн ангиллын газарт төлөвлөсөн арга хэмжээнүүд нь ихэвчлэн газрыг хамгаалах, сайжруулах зэрэг хөрөнгө мөнгө шаарддаг тул төдийлөн бүрэн хэрэгжихгүй байна.

### ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭРЭГЖИЛТИЙН БАЙРШЛЫН ТООГООР НЬ 2016, 2017 ОНТОЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ:

Газар зохион байгуулалтын 2016 оны хөдөө аж ахуйн ангиллын газрын төлөвлөгөөний хэрэгжилтийг 2017 онтой харьцуулахад Дундговь аймаг 115 хувь, Өмнөговь аймаг 101 хувь, Сүхбаатар аймаг 90 хувь, Хэнтий аймаг 88 хувь, Завхан аймаг 88 хувьтай байгаа нь хэрэгжилт сайн байна.

Харин төлөвлөгөөний хэрэгжилт хангалтгүй Баянхонгор аймаг 38.2 хувь Баян-Өлгий аймаг 43 хувь, Хөвсгөл аймаг 45.9 хувь, Дорноговь аймаг 48.4 хувь, Дорнод аймаг 49 хувьтай байгаа нь хэрэгжилт хангалтгүй биелэлттэй байна.

ЗУРАГ 1.10.1.5: 2016-2017 ОНЫ ГЗБТ-НИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ХАРЬЦУУЛАЛТ /%-ИАР/



2017 оны тайланд Сэлэнгэ аймаг гэрээгээр ашиглуулах хадлангийн талбайг 14 байршилд төлөвлөсөн боловч хэрэгжилт 2061 байршилд, Говьсүмбэр аймаг Нөөц хадлангийн талбай төлөвлөөгүй боловч хэрэгжилт 41964 байгаа нь хэт зөрүүтэй буюу графикт оруулах боломжгүй байгаа тул тайлан төлөвлөгөөг гаргахдаа сайн тулгаж үнэн зөв мэдээлэл гаргаж байх шаардлагатай байна.

### 1.10.2. Газар зохион байгуулалтын 2018 оны төлөвлөгөө


Улсын хэмжээнд сумдын газар зохион байгуулалтын 2018 оны төлөвлөгөөний хөдөө аж ахуйн ангиллын газарт нийт 5042237.67 га газрыг болон хот, тосгон бусад суурины газарт 158532.51 га газрыг, бусад ангиллын газарт 2339906.264 га газрыг өмчлүүлэх, эзэмшүүлэх, хамгаалахаар тус тус төлөвлөжээ. Үүнд:

ХҮСНЭГТ 1.10.2: СУМДЫН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН 2018 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН ГАЗРЫН ХЭМЖЭЭ

№	Аймаг, нийслэлийн нэр	Хөдөө аж ахуйн газрын ашиглалт, хамгаалалтын 2018 оны төлөвлөгөөнд тусгагдсан газрын хэмжээ /га-аар/	Хот, тосгон бусад суурины газрын ашиглалт, хамгаалалтын 2018 оны төлөвлөгөөнд тусгагдсан газрын хэмжээ /га-аар/	Бусад ангиллын газрын 2018 оны төлөвлөгөөнд тусгагдсан газрын хэмжээ /га-аар/
1	Архангай	213248.59	450.35	1.03
2	Баян-Өлгий	0	660.67	0
3	Баянхонгор	236339.69	3962.70	0
4	Булган	285714	635.78	60722.544
5	Говь-Алтай	721701.04	347.62	35650
6	Говь-Сүмбэр	20.7	168.23	20.7
7	Дархан-Уул	523.19	507.61	19

8	Дорноговь	54.54	31619.36	1499896.73
9	Дорнод	235778.52	6520.20	26.57
10	Дундговь	65231.9862	83607.11	477.47
11	Завхан	429206.308	2607.21	4672.93
12	Орхон	18326.79	156.02	5.04
13	Өвөрхангай	349452.02	764.52	2.78
14	Өмнөговь	2095.186	3194.97	56.25
15	Сүхбаатар	155123.84	168.40	0.1
16	Сэлэнгэ	372538.83	9462.14	1908.38
17	Төв	463209.35	5989.87	13056.68
18	Увс	497848.84	788.89	407495.91
19	Ховд	1347.1	2293.55	210366
20	Хөвсгөл	978350.25	1916.28	104874.13
21	Хэнтий	16145.4	1572.81	654.02
22	Улаанбаатар	0	1138.24	0
Нийт		5042237.67	158532.51	2339906.264


ЗУРАГ 1.10.2.1: ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН 2018 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНД  
ТУСАГДСАН ГАЗРЫН ХЭМЖЭЭ /%-ИАР/



## 1.11. СУУЦ ӨМЧЛӨГЧДИЙН ХОЛБОНД АШИГЛУУЛЖ БУЙ ГАЗРЫН ТАЙЛАН

2017 оны байдлаар улсын хэмжээнд нийт 684 Сууц өмчлөгчдийн холбоо үйл ажиллагаа байгаагаас нийслэлд 567, орон нутагт 117 бүртгэгдсэн байна /Зураг 1.11.1/.

■ ЗУРАГ 1.11.1. СӨХ-НЫ ТОО



■ ХҮСНЭГТ 1.11.1. СӨХ-НЫ ОРЧНЫ ГАЗРЫН БАТАЛГААЖИЛТЫН ЯВЦ /УЛСЫН ХЭМЖЭЭНД/

Д/д	Аймаг	Нийт СӨХ-ны тоо	Тооллогонд хамрагдсан СӨХ-ны тоо	Газар ашиглахаар хүсэлт гаргасан СӨХ-ны тоо	Аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар баталгаажсан	Үүнээс					
						Захирамжаар баталгаажигдсан СӨХ-эс газар ашиглах эрхийн гэрээ байгуулсан	Нийт СӨХ-ны ашиглаж байгаа талбайн хэмжээ /м <sup>2</sup> /	Маргаантай болон судалж байгаа	Захирамж гарахаар хүлээгдэж байгаа	Ерөнхий төлөвлөгөө хийгдэж байгаа СӨХ-ийн тоо	Ерөнхий төлөвлөгөө хийгдсэн СӨХ-ийн тоо
1	Архангай	1	1	1	1	1	47900.0	0	11	11	0
2	Баянхонгор	5	5	0	3	3	32925.0	0	0	0	0
3	Баян-Өлгий	0	0	0	0	0	0	0	0	0	0
4	Булган	1	1	0	1	1	32197.9	0	0	0	0
5	Говь-Алтай	5	5	0	5	5	51000.0	0	0	0	0
6	Говьсүмбэр	4	4	0	4	4	131331.0	0	0	0	0
7	Дархан-Уул	36	30	29	26	20	559764.0	6	3	0	30
8	Дорнод	8	8	12	8	8	160579.0	0	4	0	0
9	Дорноговь	15	15	15	9	9	151197.4	0	6	5	0
10	Дундговь	1	1	1	1	1	15700.0	0	0	0	0
11	Завхан	0	0	0	0	0	0	0	0	0	0
12	Орхон	24	24	24	24	24	854500.0	0	0	0	0
13	Өвөрхангай	4	0	0	0	4	33415.0	0	0	0	0
14	Өмнөговь	1	1	1	1	1	10662.0	0	0	0	0

15	Сүхбаатар	1	1	0	1	1	3500.0	0	0	0	0
16	Сэлэнгэ	8	8	8	8	8	337199.0	0	0	0	0
17	Төв	0	0	0	0	0	0.0	0	0	0	0
18	Увс	1	1	0	1	1	49000.0	0	0	0	0
19	Ховд	0	0	0	0	0	0	0	0	0	0
20	Хөвсгөл	2	2	0	1	1	51429.9	0	0	0	0
21	Хэнтий	0	0	0	0	0	0	0	0	0	0
22	Нийслэл	567	0	5	562	557	2554648	5	0	0	0
	Нийт	684	107	96	656	649	5076948	11	24	16	30

2017 оны байдлаар улсын хэмжээнд 684 СӨХ үйл ажиллагаа явуулж байгаагаас 656 нь орчны **5076948м<sup>2</sup>** газраа аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар баталгаажуулсан байна.


## 2

## ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН ТАЙЛАН

### 2.1. ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН ҮНДСЭН АНГИЛАЛ, ГАЗАР АШИГЛАЛТЫН ТӨРӨЛД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ, ШИЛЖИЛТИЙН ҮНДЭСЛЭЛ /МАЯГТ ГТ-1, 5/

2017 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын газрын нэгдмэл санд хөдөө аж ахуйн газар 114843.6 мянган га буюу 73.4 хувь, хот, тосгон бусад суурины газар 840.1 мянган га буюу 0.5 хувь, зам, шугам сүлжээний газар 471.7 мянган га буюу 0.3 хувь, ойн сан бүхий газар 14341.3 мянган га буюу 9.2 хувь, усны сан бүхий газар 686.1 мянган га буюу 0.4 хувь, улсын тусгай хэрэгцээний газар 25228.8 мянган га буюу 16.1 хувийг тус тус эзэлж байна /Зураг 2.1.1/

■ ЗУРАГ 2.1.1: ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН ҮНДСЭН АНГИЛЛЫН ТУС БҮРИЙН ЭЗЛЭХ ХУВЬ



2017 оны газрын нэгдмэл сангийн тайланг 2016 оны тайлангийн дүнтэй харьцуулахад хөдөө аж ахуйн газар 91.3 мянган га-гаар хасагдаж, хот тосгон, бусад суурины газар 86.5 мянган га, зам, шугам сүлжээний газар 3.4 мянган га, ойн сан бүхий газар 7.1 га-гаар тус тус нэмэгдэж, усны сан бүхий газар болон улсын тусгай хэрэгцээний газар /ГТ-4 тайлангийн тайлбарыг харна уу/-т өөрчлөлт ороогүй байна /Хүснэгт 2.1.1/.



■ ХҮСНЭГТ 2.1.1: УЛСЫН ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН АНГИЛЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ТОВЧОО /МЯН.ГА/

№	Газрын нэгдмэл сангийн ангилал	2016	2017	Зөрүү /мян га/
I	Хөдөө аж ахуйн газар	114934.9	114843.6	-91.3
1	Бэлчээрийн газар	110493.8	110429.4	-64.4
2	Хадлангийн талбай	1742.4	1710.2	-32.3
3	Тариалангийн газар	1067.7	1086.8	19.1
4	Атаршсан газар	260.6	241.0	-19.6
5	ХАА-н барилга, байгууламжийн дэвсгэр газар	110.6	116.6	5.9
6	ХАА-н хэрэгцээнд тохиромжгүй газар	1259.7	1259.7	0.0
II	Хот, тосгон бусад суурины газар	753.6	840.1	86.5
7	Барилга, байгууламжийн дэвсгэр газар	77.6	78.0	0.3
8	Нийтийн эдэлбэр газар	324.7	324.2	-0.5
9	Үйлдвэрийн газар	43.5	44.1	0.6
10	Уурхайн газар	236.1	319.0	82.9
11	Гэр хорооллын газар	71.7	74.8	3.1
III	Зам, шугам сүлжээний газар	473.8	471.7	-2.1
12	Авто замын газар	335.9	335.6	-0.3
13	Төмөр замын газар	32.5	31.8	-0.7
14	Агаарын тээврийн газар	9.5	8.8	-0.7
15	Шугам сүлжээний газар	95.9	95.5	-0.5
16	Усан тээврийн буудлын газар	0.0	0.0	0.0
IV	Ойн сан бүхий газар	14334.3	14341.3	7.1
17	Ой модоор бүрхэгдсэн газар	12189.2	12188.9	-0.3
18	Ой модыг нь огтолсон газар	142.5	142.9	0.4
19	Мод үржүүлгийн газар	57.9	65.0	7.1
20	Ой тэлэн ургах нөөц газар	743.6	743.4	-0.1
21	Ойн сангийн бусад газар	1201.2	1201.2	0.0
V	Усны сан бүхий газар	686.1	686.1	0.0
22	Гол мөрний эзлэх газар	228.5	228.5	0.0
23	Нуур, цөөрөм, тойрмын эзлэх газар	443.6	443.6	0.0
25	Горхи, булаг, шандны эзлэх газар	12.4	12.4	0.0
24	Мөнх цас, мөсөн голын эзлэх газар	1.6	1.6	0.0
VI	Улсын тусгай хэрэгцээний газар	25228.8	25228.8	0.0

26	Улсын тусгай хамгаалалттай газар	21140.9	21140.9	0.0
27	Улсын хилийн зурвас газар	3112.0	3112.0	0.0
28	Улсын батлан хамгаалах зориулалтын газар	124.1	124.1	0.0
29	Гадаадын дипломат, консул, төлөөлөгчийн газар	0.0	0.0	0.0
30	ШУ, туршилт, цаг уурын ажиглалтын талбай	23.0	23.0	0.0
31	Аймаг дундын отрын бэлчээр	691.4	691.4	0.0
32	Улсын тэжээлийн сангийн хадлангийн газар	110.9	110.9	0.0
33	Газрын тосны гэрээт талбай	24.5	24.5	0.0
34	Чөлөөт бүсийн газар	2.1	2.1	0.0
НИЙТ ДҮН		156411.6	156411.6	

## 2.1.1. ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР

Хөдөө аж ахуйн газар 114843.6 мянган га буюу нийт нутаг дэвсгэрийн 73.4 хувийг эзэлж байна.

Хөдөө аж ахуйн газарт бэлчээрийн газар 110429.4 мянган га буюу 96.2 хувь, хадлангийн газар 1710.2 мянган га буюу 1.5 хувь, тариалангийн газар 1086.8 мянган га буюу 0.9 хувь, атаршсан газар 241.0 мянган га буюу 0.2 хувь, хөдөө аж ахуйн барилга, байгууламжийн дэвсгэр газар 116.6 мянган га буюу 0.1 хувь, хөдөө аж ахуйн хэрэгцээнд тохиромжгүй газар 1259.7 мянган га буюу 1.1 хувийг тус тус эзэлж байна.

### ■ ХҮСНЭГТ 2.1.1.1: ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ӨӨРЧЛӨЛТ /МЯН ГА/

№	Газрын нэгдмэл сангийн ангилал	2016	2017	Зөрүү /мян га/
1	Хөдөө аж ахуйн газар	114934.9	114843.6	-91.3
1	Бэлчээрийн газар	110493.8	110429.4	-64.4
2	Хадлангийн талбай	1742.4	1710.2	-32.3
3	Тариалангийн газар	1067.7	1086.8	19.1
4	Атаршсан газар	260.6	241.0	-19.6
5	ХАА-н барилга, байгууламжийн дэвсгэр газар	110.6	116.6	5.9
6	ХАА-н хэрэгцээнд тохиромжгүй газар	1259.7	1259.7	0.0

## БЭЛЧЭЭРИЙН ГАЗАР

Бэлчээрийн газар нь 2016 оны тайлангийн дүнтэй харьцуулахад 64.4 мянган га-аар хасагдсан байна. Тайлант онд бэлчээрийн газраас ХАА-н барилга, байгууламжийн дэвсгэр газар, зам, шугам сүлжээний газар, хот, тосгон бусад суурины газар, ойн сан бүхий газрын мод үржүүлгийн газрын ангилал руу шилжилт хийгдсэн байна.

## ХАДЛАНГИЙН ГАЗАР

Хадлангийн газар нь 2016 оны тайлангийн дүнтэй харьцуулахад 32.3 мянган га-аар хасагдсан байна.

2017 онд Баянхонгор аймагт 240.8 га, Төв аймагт 2005.1 га, Увс аймагт 105.1 га талбайг хадлангийн зориулалтаар иргэн, аж ахуйн нэгж байгууллагад шинээр эзэмшүүлсэн боловч Сүхбаатар аймагт Эрдэнэцагаан, Сүхбаатар, Асгат, Мөнххаан зэрэг сумд болон нийт аймгийн хэмжээнд тайлант онд ихэнх нутгаар гандуу, ургамлын гарц муу байгаагаас шалтгаалан хадлангийн талбай 34615.3 га-гаар хасагдсанаас улсын хэмжээнд хадлангийн талбайн 32.3 мянган га-гаар буурсан байна.

## ТАРИАЛАНГИЙН ГАЗАР

Тариалангийн газар нь 2016 оны тайлангийн дүнтэй харьцуулахад 19.1 мянган га-аар нэмэгдсэн байна.

### ■ ХҮСНЭГТ 2.1.1.2. ТАРИАЛАНГИЙН ГАЗРЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ТОВЧОО /ГА/


№	Аймгийн нэр	2016	2017	Зөрүү
1	Архангай	22286.3	23366.3	1080.0
2	Баянхонгор	2696.8	2700.8	4.0
3	Баян-Өлгий	1770.6	2609.9	839.3
4	Булган	81765.2	88827.6	7062.3
5	Говь-Алтай	5108.4	5141.2	32.8
6	Говьсүмбэр	3328.0	3320.0	-8.0
7	Дархан-Уул	33928.5	34205.5	276.9
8	Дорноговь	532.2	546.2	14.0
9	Дорнод	97638.2	101168.9	3530.7
10	Дундговь	700.3	701.3	1.0
11	Завхан	2535.7	6401.3	3865.6
12	Орхон	4792.7	5079.6	287.0
13	Өвөрхангай	23749.2	24852.4	1103.2
14	Өмнөговь	749.4	749.8	0.5
15	Сүхбаатар	16725.7	16725.7	0.0
16	Сэлэнгэ	315279.5	315270.5	-9.0
17	Төв	258245.0	258245.0	0.0
18	Увс	66273.3	66599.3	326.0

19	Ховд	8803.8	9044.9	241.1
20	Хөвсгөл	33533.6	33630.1	96.5
21	Хэнтий	79759.9	80147.9	388.0
22	Нийслэл	7520.0	7451.9	-68.2
Нийт дүн		1067722.2	1086786.0	19063.7

2016 оны дүнтэй харьцуулахад тариалангийн газар хамгийн их нэмэгдсэн нь Архангай аймагт 1080.0 га, Булган аймагт 7062.3 га, Дорнод аймагт 3530.7 га, Завхан аймагт 3865.6 га, Өвөрхангай аймагт 1103.2 га байна. Эдгээр нь атаршсан талбайг эргүүлэн үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, таримал ургамал тариалах зориулалтаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад шинээр эзэмшүүлсэнтэй холбоотойгоор гарсан өөрчлөлт юм.

1990 оноос хойшхи тариалангийн газрын талбайн хэмжээг дараах зурагт үзүүлэв /Зураг 2.1.1.1/.

■ ЗУРАГ 2.1.1.1: ТАРИАЛАНГИЙН ГАЗРЫН ӨӨРЧЛӨЛТ /МЯН.ГА/



## 2.1.2. ХОТ, ТОСГОН, БУСАД СУУРИНЫ ГАЗАР

Хот, тосгон бусад суурины газар 840.1 мянган га буюу нийт нутаг дэвсгэрийн 0.5 хувийг эзэлж байна.

Хот, тосгон, бусад суурины газарт барилга, байгууламжийн дэвсгэр газар 78.0 мянган га буюу 9.3 хувийг, нийтийн эдэлбэр газар 324.2 мянган га буюу 38.6 хувийг, үйлдвэрийн газар 44.1 мянган га буюу 5.3 хувийг, уурхайн газар 319.0 мянган га буюу 38.0 хувийг, гэр хорооллын газар 74.8 мянган га буюу 8.9 хувийг тус тус эзэлж байна.

■ ХҮСНЭГТ 2.1.2.1: ХОТ, ТОСГОН, БУСАД СУУРИН ГАЗРЫН ӨӨРЧЛӨЛТ /МЯН.ГА/

№	Газрын нэгдмэл сангийн ангилал	2016	2017	Зөрүү /мян.га/
II	Хот, тосгон бусад суурины газар	753.6	840.1	86.5
1	Барилга, байгууламжийн дэвсгэр газар	77.6	78.0	0.4
2	Нийтийн эдэлбэр газар	324.7	324.2	-0.5
3	Үйлдвэрийн газар	43.5	44.1	0.6
4	Уурхайн газар	236.1	319.0	82.9
5	Гэр хорооллын газар	71.7	74.8	3.1

2017 оны тайлангийн дүнгээр гэр хорооллын газар 3.1 мянган га-аар өссөн нь нийслэл, орон нутагт Монгол Улсын иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар шинээр газар эзэмшүүлж өмчлүүлж байгаатай холбоотой юм. Тухайлбал нийслэлд цахим систем ашиглан Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх ажлыг илүү нээлттэй, ил тод болгосноор газар өмчлөгч иргэдийн тоо нэмэгдэж, тухайн газар буюу гэр хорооллын газрын хэмжээ нэмэгдсэн дүнтэй байна. Мөн тайлант онд уурхайн газар 89.2 мянган га-аар өссөн нь Дорноговь аймагт уурхайн газар 708253.9 га, Баянхонгор, Дархан-Уул, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Хэнтий аймгуудад тус бүр 76.6 га-аас 9777.0 га-аар тус тус нэмэгдсэнтэй холбоотой юм.

Дорноговь аймгийн Айраг, Даланжаргалан, Иххэт, Мандах, Өргөн, Сайхандулаан, Улаанбадрах сумдын нутаг дэвсгэрт илэрсэн ашигт малтмалын нөөцөд тулгуурлан мэргэжлийн эрх бүхий байгууллагаас олгосон ашиглалтын лицензийг үндэслэн 2017 онд ашигт малтмал олборлох зориулалтаар үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад ашиглуулах газрын байршлыг эдгээр сумдын Иргэдийн Төлөөлөлөгчдийн Хурлаар баталж, 2017 онд нийт 15 аж ахуйн нэгж, байгууллагад 71160,31 га газрыг уул уурхайн зориулалтаар ашиглуулах шийдвэр гаргаж, гэрээ байгуулсан байна. Үүнд:

- Айраг суманд 1 аж ахуйн нэгж-112 га
- Даланжаргалан суманд 3 аж ахуйн нэгж-8088,41 га
- Иххэт суманд 1 аж ахуйн нэгж-1308,47 га
- Мандах суманд 3 аж ахуйн нэгж-7194,94 га
- Өргөн суманд 1 аж ахуйн нэгж-43 га
- Сайхандулаан суманд 3 аж ахуйн нэгж-1121,06 га
- Улаанбадрах суманд 3 аж ахуйн нэгж-53292,43 га

Мөн тус аймгийн Айраг сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэр Хүрэн-1 нэртэй газарт ашигт малтмал олборлох зориулалтаар газар ашиглагч “Айвароу” ХХК нь ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайгаасаа 156,71 га газрыг хэсэгчлэн буцаах хүсэлт гаргасныг хүлээн авч сумын Засаг даргын 2017 оны А/76 тоот захирамжаар, Өргөн сумын нутаг дэвсгэрт уурхайн эдэлбэр газрын зориулалтаар 177,7 га газрыг ашиглаж байсан Монголросцветмет ХХК нь Монгол Улсын Газрын тухай хуулийн

40 дүгээр зүйлийн 40.1.5 дахь заалтыг зөрчсөн тул газар ашиглах эрхийг нь сумын Засаг даргын 2017 оны А/131 тоот захирамжаар тус тус хүчингүй болгосон байна.

### 2.1.3. ЗАМ, ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ГАЗАР

Зам, шугам сүлжээний газар 471.7 мянган га буюу нийт нутаг дэвсгэрийн 0.3 хувийг эзэлж байгаа бөгөөд 2016 оны тайлангийн дүнтэй харьцуулахад 3.4 мянган га-аар нэмэгдсэн байна /Хүснэгт 2.1.3.1/.

Зам, шугам сүлжээний газарт авто замын газар 335.6 мянган га буюу 71.2 хувийг, төмөр замын доорх газар 31.8 мянган га буюу 6.7 хувийг, агаарын тээврийн газар 8.8 мянган га буюу 1.9 хувийг, шугам сүлжээний газар 95.5 мянган га буюу 20.2 хувийг тус тус эзэлж байна.

#### ■ ХҮСНЭГТ 2.1.3.1: ЗАМ, ШУГАМ, СҮЛЖЭЭНИЙ ГАЗРЫН АНГИЛЛЫН ӨӨРЧЛӨЛТ /МЯН.ГА/

№	Газрын нэгдмэл сангийн ангилал	2016	2017	Зөрүү /мян.га/
III	Зам, шугам сүлжээний газар	468.3	471.7	3.4
1	Авто замын газар	334.9	335.6	0.7
2	Төмөр замын газар	31.2	31.8	0.6
3	Агаарын тээврийн газар	9.0	8.8	-0.2
4	Шугам сүлжээний газар	93.2	95.5	2.3
5	Усан тээврийн буудлын газар	0.0	0.0	0.0

Дэд бүтцийн салбарын бүтээн байгуулалтууд жил тутам нэмэгдэж байгаатай холбогдон зам, шугам сүлжээний газрын хэмжээ мөн адил өсөн нэмэгдэж байна.

Сүүлийн жилүүдэд авто зам, шугам сүлжээний газрын хэмжээ тогтмол нэмэгдэж ирсэн нь тус салбар дахь бүтээн байгуулалт болоод тухайн газруудыг холбогдох журмын дагуу газрын улсын бүртгэлд бүртгэж, хариуцах эзэнтэй болгосонтой холбоотой юм.

Агаарын тээврийн зориулалтаар ашиглагдаж байгаа газрын хэмжээ Завхан аймагт 115.0 га, Орхон аймагт 90.4 га-гаар тус тус буурсан байгаа нь Завхан аймагт “Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбицол, өндөр тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх ажил”-ын хүрээнд хийгдсэн хэмжилт зураглалын ажлын үр дүнд Тосонцэнгэл сумын нисэх буудлын талбайн бодит хэмжээг шинэчлэн тогтоосон, Орхон аймгийн Баян-Өндөр суманд Төрийн өмчийн хорооноос газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаагаар аймгийн нисэх онгоцны буудлын зориулалтаар ашиглагдаж байсан газрыг 1 иргэнд аймгийн Засаг даргын захирамжаар үйлдвэрийн зориулалтаар эзэмшүүлснээс ангилал шилжин өөрчлөгдсөн байна.

## 2.1.4. ОЙН САН БҮХИЙ ГАЗАР

Ойн сан бүхий газар 14341.3 мянган га буюу нийт нутаг дэвсгэрийн 9.2 хувийг эзэлж байна.

Ойн сан бүхий газарт ойгоор бүрхэгдсэн газар 12188.9 мянган га буюу 85 хувийг, ой модыг нь огтолсон газар 142.9 мянган га буюу 1 хувийг, мод үржүүлгийн газар 65.0 мянган га буюу 0.5 хувийг, ой тэлэн ургах нөөц газар 743.4 мянган га буюу 5.2 хувийг, ойн сангийн бусад газар 1201.2 мянган га буюу 8.4 хувийг тус тус эзэлж байна.

### ■ ХҮСНЭГТ 2.1.4.1: ОЙН САН БҮХИЙ ГАЗРЫН ӨӨРЧЛӨЛТ /МЯН.ГА/

№	Газрын нэгдмэл сангийн ангилал	2016	2017	Зөрүү /мян.га/
IV	Ойн сан бүхий газар	14334.3	14341.3	7.1
1	Ой модоор бүрхэгдсэн газар	12189.2	12188.9	-0.3
2	Ой модыг нь огтолсон газар	142.5	142.9	0.4
3	Мод үржүүлгийн газар	57.9	65.0	7.1
4	Ой тэлэн ургах нөөц газар	743.6	743.4	-0.1
5	Ойн сангийн бусад газар	1201.2	1201.2	0.0

2017 онд мод үржүүлгийн газар 7.1 мянган га-гаар нэмэгдсэн нь Өмнөговь аймгийн Баяндалай суманд 1 га, Булган суманд 10.3 га, Даланзадгад суманд 31 га, Мандал-Овоо суманд 5 га, Ноён суманд 0.1 га, Хүрмэн суманд 6955,7 га газрыг мод үржүүлгийн зориулалтаар шинээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлсэн байна.

## 2.1.5. УСНЫ САН БҮХИЙ ГАЗАР

Усны сан бүхий газар 686.1 мянган га буюу нийт газар нутгийн 0.4 хувийг эзэлж байна.


Усны сан бүхий газарт мөрөн, гол, горхи 228.5 мянган га буюу 33.3 хувийг, нуур, цөөрөм 443.6 мянган га буюу 64.7 хувийг, горхи, булаг, шанд 12.4 мянган га буюу 1.8 хувийг, мөнх цас, мөсөн гол 1.6 мянган га буюу 0.2 хувийг тус тус эзэлж байна.

■ ХҮСНЭГТ 2.1.5.1: УСНЫ САН БҮХИЙ ГАЗРЫН ӨӨРЧЛӨЛТ /МЯН.ГА/

№	Газрын нэгдмэл сангийн ангилал	2016	2017	Зөрүү /мян.га/
V	Усны сан бүхий газар	686.1	686.1	0.0
1	Гол мөрний эзлэх газар	228.5	228.5	0.0
2	Нуур, цөөрөм, тойрмын эзлэх газар	443.6	443.6	0.0
3	Горхи, булаг, шандны эзлэх газар	12.4	12.4	0.0
4	Мөнх цас, мөсөн голын эзлэх газар	1.6	1.6	0.0

**2.2. УЛСЫН ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭНИЙ ГАЗАР /МАЯГТ ГТ-4/**

Улсын тусгай хэрэгцээний нийт газрын хэмжээ 25,228.9 мянган га газар буюу Монгол улсын нийт нутаг дэвсгэрийн 16 хувийг эзэлж байна.



Улсын тусгай хэрэгцээний газрын ангилалд улсын тусгай хамгаалалттай газар 21,140.8 мянган га буюу 84.1 хувийг, улсын хилийн зурвас газар 3,111.0 мянган га буюу 13.0 хувийг, улсыг батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар 124.1 мянган га буюу 1.0 хувийг, гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газарт олгосон газар 0.033 мянган га буюу 0.001 хувийг, шинжлэх ухаан, технологийн сорилт, туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай 22.9 мянган га буюу 0.009 хувийг, аймаг дундын отрын бэлчээр 691.4 мянган га буюу 2.3 хувийг, улсын тэжээлийн сангийн хадлангийн талбай 110.9 мянган га буюу 0.4 хувийг, бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хайгуулын зориулалтаар ашиглах газрын тосны гэрээт талбай 24.5 мянган га буюу 0.1 хувийг, чөлөөт бүсийн газар 2.1 мянган га буюу 0.008 хувийг тус тус эзэлж байна.

Тайлант онд Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай 254 дүгээр тогтоолоор 0.21 га газрыг Монгол Улсын геодезийн сүлжээний эхлэл цэгийг байгуулах болон Монгол орны газрын царцдаст давхаргын тавцангуудын шилжилт хөдөлгөөн, хэв гажилт,



тэдгээрийн босоо, хэвтээ динамик хүч, хөдөлгөөнийг хянах байнгын ажиглалтын үйл ажиллагаа явуулах зориулалтаар Улсын тусгай хэрэгцээний газар/Шинжлэх ухаан, технологийн сорилт, туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай/-т авсан болон Дорнод аймгийн Чулуунхороот сумын төв нь Улсын хилийн зурвас газарт хамаардаг бөгөөд сумын Засаг даргын захирамжаар нийт 0.7 га газрыг иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар эзэмшүүлснээр хот, тосгон, бусад суурины газрын нийтийн эдэлбэр газраас гэр хорооллын газарт 0.7 га газар шилжсэн өөрчлөлтийг тус тус ГТ-4 тайланд тусгав. / Хүснэгт 2.2.1/.

■ ХҮСНЭГТ 2.2.1: УЛСЫН ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭНИЙ ГАЗРЫН ӨӨРЧЛӨЛТ /ГА/

№	Газрын нэгдмэл сангийн ангилал	2016	2017	Зөрүү
VI	Улсын тусгай хэрэгцээний газар	25,228,899.05	25,228,899.26	0.21
1	Улсын тусгай хамгаалалттай газар	21,140,880.62	21,140,880.62	-
2	Улсын хилийн зурвас газар	3,111,994.94	3,111,994.94	-
3	Улсыг батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар	124,097.61	124,097.61	-
4	Гадаадын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газар	33.68	33.68	-
5	Шинжлэх ухаан, технологийн сорилт, туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай	22,960.00	22,960.21	0.21
6	Аймаг дундын отрын бэлчээр	691,413.80	691,413.80	-
7	Улсын тэжээлийн сангийн хадлангийн талбай	110,940.00	110,940.00	-
8	Газрын тосны гэрээт талбай	24,470.00	24,470.00	-
9	Чөлөөт бүсийн газар	2,108.40	2,108.40	-

■ ЗУРАГ 2.2.2: УЛСЫН ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭНИЙ ГАЗРЫН АНГИЛЛЫН ТАЛБАЙН ХЭМЖЭЭ /ГА-ГААР/



Газрын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.13 -т заасны дагуу Үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх газрын ангилалд дараах газруудыг тус тус Улсын тусгай хэрэгцээнд аваад байна. Үүнд:

- 2015 онд Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн “Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай” 456 дугаар тогтоолоор Үндэсний их баяр наадмын “Монгол наадам цогцолбор”-т зориулан нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт хамаарах 551 га, Төв аймгийн Аргалант сумын нутаг дэвсгэрт хамаарах 12,031 га, нийт 12,582 га газар;
- 2015 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн “Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай” 487 дугаар тогтоолоор Улаанбаатар хот-Хөшигийн хөндийн олон улсын шинэ нисэх онгоцны буудал чиглэлийн хурдны авто зам барихад шаардагдах 6,132.6 га газар;
- 2016 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн газрыг Улсын тусгай хэрэгцээнд авах тухай 285 дугаар тогтоолоор Булган аймгийн нутаг дэвсгэрт Эгийн голын усан цахилгаан станцын барилга байгууламж, далан, усан сан, дэд бүтцийн болон туслах үйлчилгээний барилга байгууламж барихад шаардагдах 36,980.8 га газар;
- 2016 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн Хөдөө аж ахуйн “Халх гол” үндэсний бүтээн байгуулалтын бүс байгуулах тухай 328 дугаар тогтоолоор Дорнод аймгийн нутаг дэвсгэрт Хөдөө аж ахуйн “Халх гол” үндэсний бүтээн байгуулалтын бүс болгоход шаардагдах 500,000 га газар.

Тайлант онд “Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт орших Тост, Тосон бумбын нуруу орчмын 743,058 га газрыг Байгалийн нөөц газраар Улсын тусгай хамгаалалтанд авах тухай” Монгол улсын Засгийн газрын 2017 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 91 дүгээр тогтоол гарсан.


Гэвч дээрх газруудыг улсын тусгай хэрэгцээнд авахдаа Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан “Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах журам”-ыг холбогдох байгууллагууд мөрдөж ажиллахгүй байгаагаас газрын нэгдмэл сангийн ангиллыг тодорхойлоогүйгээс шалтгаалан Засгийн газрын 2003 оны 204 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Улсын тусгай хэрэгцээний газрын тайлан”-гийн маягт ГТ-4 тайланд нийт 1,298.7 мянган га газрыг тусгах боломжгүй байна.

Дээрх Улсын тусгай хэрэгцээнд авсан 1,298.7 мянган га газрыг Улсын тусгай хэрэгцээний газрын ГТ-4 тайланд тусгавал 26,527.6 мянган га газар болж нэмэгдэх юм.

### **2.3. ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТАЙЛАН /МАЯГТ ГТ-2/**


2017 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд нийт 6794758.83 га газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмчлөл, эзэмшил, ашиглалтад олгоод байна. Үүнээс 57767.26 га-г өмчилж, 6405966.14 га-г эзэмшиж, 303166.01 га газрыг ашиглаж байна. Мөн бусдын эзэмшил газрыг ашиглагч Монгол улсын иргэн, аж ахуйн нэгж, төрийн байгууллага 27859.43 га газрыг тус тус ашиглаж байна /Зураг 2.3.1/.

ЗУРАГ 2.3.1: 2017 ОНЫ БАЙДЛААР ӨМЧЛӨЛ, ЭЗЭМШИЛ, АШИГЛАЛТАД БАЙГАА ГАЗАР / ХУВИАР/




Тайлант оны газар, өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн нийт талбайг 2016 онтой харьцуулбал 35312.38 га-гаар өссөн байна /Зураг 2.3.2/.

ЗУРАГ 2.3.2: НИЙТ ӨМЧЛӨЛ, ЭЗЭМШИЛ, АШИГЛАЛТАНД БАЙГАА ГАЗРЫГ УРЬД ОНЫ ДҮНТЭЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ /ГА-ГААР/




Газрын эрхийн төрлөөр 2016 оны үзүүлэлттэй харьцуулахад иргэн, хуулийн этгээдийн өмчлөлийн газар 57767.26 га болж 1268.22 га-аар /Зураг 2.3.3/, иргэн, хуулийн этгээдийн ашиглаж байгаа газар 303166.01 га болж 61577.21 га-гаар /Зураг 2.3.6/, бусдын эзэмшил газрыг ашиглагч Монгол улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар 27859.43 га болж 12124.21 га-гаар /Зураг 2.3.5/ тус тус өссөн дүнтэй байна. Харин иргэн, хуулийн этгээдийн эзэмшлийн газар 6405966.14 га болж 41804.90 га-аар хасагдсан байна /Зураг 2.3.4/.


■ ЗУРАГ 2.3.3: ӨМЧЛҮҮЛСЭН ГАЗАР /ГА-ГААР/




■ ЗУРАГ 2.3.4: ЭЗЭМШҮҮЛСЭН ГАЗАР /ГА-ГААР/



■ ЗУРАГ 2.3.5: БУСАД АШИГЛУУЛЖ БҮЙ  
ЭЗЭМШЛИЙН ГАЗАР/ГА-ГААР/




■ ЗУРАГ 2.3.6: АШИГЛУУЛСАН ГАЗАР /ГА-ГААР/



Газар эзэмшигч нь газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа дуусахад сунгуулах хүсэлт гаргаагүй, хууль болон гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй гэсэн үндэслэлээр Нийслэлд 1850.4 га, Дундговь аймагт 96842.7 га, Увс аймагт 5152.6 га, Хөвсгөл аймагт 3818.0 га газрын эзэмших эрхийг холбогдох Засаг даргын шийдвэрээр хүчингүй болгосон нь 2017 оны байдлаар эзэмшлийн газрын хэмжээг өмнөх оны тоотой харьцуулахад 41804.9 га-аар багасаж байгаатай холбоотой юм.

Газрын нэгдмэл сангийн дэлгэрэнгүй ангиллаар авч үзвэл хөдөө аж ахуйн газарт 1347026.1 га, хот тосгон, бусад суурины газарт 536258.1 га, зам, шугам сүлжээний газарт 171307.1 га, ойн сан бүхий газарт 679519.7 га, усны сан бүхий газарт **83209.5** га, улсын тусгай хэрэгцээний газарт 3977438.3 га газар өмчлөл, эзэмшил, ашиглалтанд олгогдоод байна /Зураг 2.3.7/.

ЗУРАГ 2.3.7: НИЙТ ГАЗАР ӨМЧЛӨГЧ, ЭЗЭМШИГЧ, АШИГЛАГЧДЫГ ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН АНГИЛЛААР ҮЗҮҮЛСЭН БАЙДАЛ /ХУВИАР/




ХҮСНЭГТ 2.3.1. ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН АНГИЛАЛ ДАХЬ ЭРХИЙН ТӨРЛИЙН ӨӨРЧЛӨЛТ

д/д	Газрын нэгдмэл сангийн ангилал	Эрхийн төрөл	2016 он	2017 он	Зөрүү
1	Хөдөө аж ахуйн газар	өмчлөгч	135.4	131.6	-3.7
		эзэмшигч	1296625.9	1297347.0	721.1
		бусдын эзэмшил газрыг ашиглагч	7008.9	7144.3	135.5
		ашиглагч	40764.6	42403.1	1638.6
		нийт	1344534.8	1347026.1	2491.4
2	Хот, тосгон, бусад суурины газар	өмчлөгч	54215.0	57635.6	3420.6
		эзэмшигч	376526.1	314841.6	-61684.5
		бусдын эзэмшил газрыг ашиглагч	3220.1	17018.3	13798.2
		ашиглагч	88209.1	146762.7	58553.6
		нийт	522170.3	536258.1	14087.9
3	Зам, шугам сүлжээний газар	эзэмшигч	148939.5	148320.6	-618.9
		бусдын эзэмшил газрыг ашиглагч	5207.7	3367.7	-1840.0
		ашиглагч	16022.6	19618.9	3596.2
		нийт	170169.9	171307.1	1137.3
4	Ойн сан бүхий газар	эзэмшигч	670806.0	673584.5	2778.5
		ашиглагч	5931.5	5935.2	3.7
		нийт	676737.5	679519.7	2782.2
5	Усны сан бүхий газар	эзэмшигч	86210.3	86210.3	0.0
		ашиглагч	2222	2222	0.0
		нийт	88432.3	88432.3	0.0
6	Улсын тусгай хэрэгцээний газар	эзэмшигч	3868663.3	3888663.0	19999.7
		бусдын эзэмшил газрыг ашиглагч	298.6	329.1	30.6
		ашиглагч	88440.0	88446.2	6.1
		нийт	3957401.8	3977438.3	20036.4

## 2.4. ГАЗРЫН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТАЙЛАН /МАЯГТ ГТ-3/


2017 онд улсын хэмжээнд нийт 1036117 газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч байгаа нь өмнөх оныхоос нийт дүнгээрээ 68547-аар өссөн байна /Зураг 2.4.1/.

ЗУРАГ 2.4.1: НИЙТ ӨМЧЛӨГЧ, ЭЗЭМШИГЧ, АШИГЛАГЧДЫГ УРЬД ОНЫ ДҮНТЭЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ /ТООГООР/




Тайлант онд газар өмчлөгч **570771**, эзэмшигч **463313**, бусдын эзэмшил газрыг ашиглагч Монгол улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага **1061**, газар ашиглагч **972** иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тус тус байна /Зураг 2.4.2/.

ЗУРАГ 2.4.2: НИЙТ ГАЗАР ӨМЧЛӨГЧ, ЭЗЭМШИГЧ, АШИГЛАГЧИД




Газрын эрхийн төрлөөр 2016 оны үзүүлэлттэй харьцуулахад газар өмчлөгчийн тоо 570771 болж 33450-аар /Зураг 2.4.3/, газар эзэмшигчийн тоо 463313 болж 34958-аар /Зураг 2.4.4/, бусдын эзэмшил газрыг ашиглагч Монгол улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын тоо 1061 болж 51-ээр /Зураг 2.4.5/, газар ашиглагчийн тоо 972 болж 88-аар тус тус өссөн дүнтэй байна /Зураг 2.4.6/.


■ ЗУРАГ 2.4.3. ГАЗАР ӨМЧЛӨГЧ /ТООГООР/




■ ЗУРАГ 2.4.4. ГАЗАР ЭЗЭМШИГЧ /ТООГООР/



■ ЗУРАГ 2.4.5. БУСДЫН ЭЗЭМШИЛ ГАЗРЫГ АШИГЛАГЧ МОНГОЛ УЛСЫН ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА /ТООГООР/




■ ЗУРАГ 2.4.6. ГАЗАР АШИГЛАГЧ /ТООГООР/



Нийт газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчдыг газрын нэгдмэл сангийн дэлгэрэнгүй ангиллаар үзүүлбэл хөдөө аж ахуйн газарт 177049, хот тосгон, бусад суурины газарт 783247, зам, шугам сүлжээний газарт 2018, ойн сан бүхий газарт 3486, усны сан бүхий газарт 78, улсын тусгай хэрэгцээний газарт 1692 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага газар өмчилж, эзэмшиж, ашиглаж байна /Зураг 2.4.7/.

ЗУРАГ 2.4.7: ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН АНГИЛЛААР ҮЗҮҮЛСЭН БАЙДАЛ /ЭЗЛЭХ ХУВЬ/



ХҮСНЭГТ 2.4.1. ГАЗАР ЭЗЭМШИГЧ, АШИГЛАГЧДЫН ӨӨРЧЛӨЛТ /ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН АНГИЛЛААР/

д/д	Газрын нэгдмэл сангийн ангилал	Эрхийн төрөл	2016	2017	Зөрүү
1	Хөдөө аж ахуйн газар	өмчлөгч	123	109	-14
		эзэмшигч	176724	193969	17245
		бусдын эзэмшил газрыг ашиглагч	161	1061	900
		ашиглагч	41	972	931
		нийт	177049	194293	17244
2	Хот, тосгон, бусад суурины газар	өмчлөгч	537198	570662	33464
		эзэмшигч	245240	262421	17181
		бусдын эзэмшил газрыг ашиглагч	153	170	17
		ашиглагч	656	690	34
		нийт	783247	833943	50696
3	Зам, шугам шүлжээний газар	эзэмшигч	1830	2072	242
		бусдын эзэмшил газрыг ашиглагч	14	29	15
		ашиглагч	174	208	34
		нийт	2018	2309	291
4	Ойн сан бүхий газар	эзэмшигч	3480	3712	232
		ашиглагч	6	6	0
		нийт	3486	3718	232
5	Усны сан бүхий газар	эзэмшигч	72	61	-11
		ашиглагч	6	0	-6
		нийт	78	61	-17




6	Улсын тусгай хэрэгцээний газар	эзэмшигч	1009	1078	69
		бусдын эзэмшил газрыг ашиглагч	682	695	13
		ашиглагч	1	20	19
		нийт	1692	1793	101

## 2.5. ГАЗАРТ УЧРУУЛСАН ХОХИРЛЫН ТАЙЛАН /МАЯГТ ГТ-6/

Улсын хэмжээнд газарт учруулсан хохирлын тайланг ГТ-6 маягтын дагуу дэлгэрэнгүй байдлаар нэгтгэхэд тариалангийн 70881.4 га, бэлчээр ба бусад өвслөг ургамал газрын 3140911.3 га, хот тосгон, бусад суурин газрын 11615.0 га, ойн сан бүхий газрын 225506.6 га, усны сан бүхий газрын 6056.6 га газарт тус тус хохирол учирсан байна. Ухагдаж эвдэрсэн 3117.8 га газар бүртгэгдсэн байна. Улсын хэмжээнд нийт 3458717.4 га газарт хохирол учирсан байна /Зураг 2.5.1/.

ЗУРАГ 2.5.1: ГАЗАРТ УЧРУУЛСАН ХОХИРОЛ. АЙМГААР




### ТАРИАЛАНГИЙН ГАЗАР

Тариалангийн газарт учирсан хохирлыг салхи, усны элэгдэл эвдрэлд орсон, үржил шим буурсан, хортон шавьжид нэрвэгдсэн, хөрс бохирдсон, химийн бодисоор бохирдсон болон бусад гэсэн үзүүлэлтүүдээр ангилан улсын хэмжээнд нэгтгэхэд нийт 70881.4 га талбай хохиролд өртсөн байна. Өөрөөр хэлбэл тариалангийн газрын хохирол улсын хэмжээнд нийт хохирол учирсан талбайн 2.04 хувийг эзэлж байна. Энэ нь 2016 оны дүнгээс 16000 га талбайгаар илүү байна.

Тариалангийн газарт учирсан хохирлын 62.7 хувь буюу 44469.2 га талбай мэрэгчид, хортон шавьжинд нэрвэгдсэн, 34.1 хувь буюу 24162.5 га талбайн үржил шим буурсан, 1.1 хувь буюу 757.9 га талбай салхины эвдрэлтэй, 1.4 хувь буюу 1007.0 га талбай усны эвдрэлтэй, үлдсэн 484.8 га талбайн хөрс бохирдох, аюултай хог ургамалд нэрвэгдэх, бусад байдлаар хохиролд нэрвэгдсэн байна /Зураг 2.5.2/.

ЗУРАГ 2.5.2: ТАРИАЛАНГИЙН ГАЗАРТ УЧИРСАН ХОХИРЛЫН АНГИЛАЛ




Бусад аймагтай харьцуулбал Төв, Увс, Архангай аймгийн тариалангийн газарт их хохирол учирсан байна.

### БЭЛЧЭЭР

2016 онд 6,4 сая га бэлчээрт хохирол учирч байсан бол 2017 онд 3,1 сая га газарт хохирол учирсан нь улсын хэмжээнд хохирол учирсан талбайн 90.8 хувь болж байна.

Хохиролд өртсөн бэлчээрийн газрыг ангилж үзвэл 587,2 мян.га бэлчээр талхлагдаж, 7,7 мян.га бэлчээр салхи, усны эвдрэлд орж, 96,3 га бэлчээр намагжиж, 139,1 мян.га бэлчээр элсний нүүлтэд өртөж, 195,6 мян.га бэлчээр мэрэгчид болон хортон шавьжид нэрвэгдэж, 385,6 мян.га бэлчээр цөлжиж, 64,2 мян.га бэлчээр ашигт малтмалын олборлолтод өртсөн байна. /Зураг /

ЗУРАГ 2.5.3: БЭЛЧЭЭРИЙН ГАЗАРТ УЧИРСАН ХОХИРОЛ, ТӨРЛӨӨР /ИХ ХОХИРОЛ УЧРУУЛСНААР ЭРЭМБЭЛЭВ/



Бэлчээрт хохирол учирсан байдлаас харвал мэрэгчид болон хортон шавьжийн нөлөө хамгийн их нөлөөлсөн бол түүний дараа талхлагдал, цөлжилт, элсний нүүлт, ашигт малтмалын олборлолт гэсэн дарааллаар хохирлыг эрэмбэлж болохоор байна.


Бэлчээрт учирсан хохирлын талбай ихтэй аймгуудад Архангай, Завхан, Төв, Дорнод, Дундговь аймгууд орж байна.

## ХОТ ТОСГОН, БУСАД СУУРИН ГАЗАР

2016 онд 5,4 мян.га хот тосгон, бусад суурины газарт хохирол учирч байсан бол 2017 онд 11,6 мян.га газарт хохирол учирсан нь улсын хэмжээнд хохирол учирсан талбайн 0.3 хувь болж байна.

Хот тосгон, бусад суурины нийт 11615.0 га газарт хохирол учирснаас ургамлан бүрхэвчгүй болсон 1.9 хувь буюу 220.2 га, элсний нүүлтэд орсон 5.3 хувь буюу 612.6 га, үйлдвэрийн хог хаягдлаар бохирдсон 0.3 хувь буюу 33.6 га, ахуйн хог хаягдлаар бохирдсон 91.0 хувь буюу 10572.9 га, бусад 1.5 хувь буюу 175.8 га газар тус тус бүртгэгджээ /Зураг 2.5.4/.


■ ЗУРАГ 2.5.4: ХОТ, ТОСГОН БУСАД СУУРИНЫ ГАЗАРТ УЧИРСАН ХОХИРОЛ, ТӨРЛӨӨР



Дээрх зургаас харахад суурьшил бүхий газарт ахуйн хог хаягдлаар бохирдсон газар их байгаа нь харагдаж байна.

Хот суурин газарт учирсан хохирлыг аймаг бүрээр харьцуулж харуулбал Өмнөговь аймаг хамгийн их хохирол учирсан талбайтайгаар тэргүүлж байна.


ЗУРАГ 2.5.5: ХОТ, ТОСГОН БУСАД СУУРИНЫ ГАЗАРТ УЧИРСАН ХОХИРОЛ, АЙМГААР



### ОЙН САН БҮХИЙ ГАЗАР

2016 онд ойн сан бүхий газрын 513,2 мян.га талбай хохирол өртсөн гэсэн дүн гарч байсан бол 2017 онд 225,5 мян.га талбайд хохирол учирснаас түймэрт нэрвэгдсэн 46.4 хувь буюу 104599.1 га, өвчин, хортон шавьжид идэгдсэн 45.9 хувь буюу **103429.2** га, мод бут, сөөг, загийг устгасан 7.2 хувь буюу 16145.9 га, ашигт малтмалын олборлолтонд өртсөн 0.6 хувь буюу 1332.3 га газар тус тус бүртгэгдсэн байна.

ЗУРАГ 2.5.6: ОЙН САН БҮХИЙ ГАЗАРТ УЧИРСАН ХОХИРОЛ, ХУВИАР



■ ХҮСНЭГТ 2.5.1: ОЙН САН БҮХИЙ ГАЗАРТ УЧИРСАН ХОХИРЛЫН ХЭМЖЭЭ /МЯН.ГА/

Он	Түймэрт нэрвэгдсэн	Өвчин, хортон шавьжид идэгдсэн	Ашигт малтмалын олборлолтод өртсөн	Мод бут, сөөг, загийг устгасан
2009	448,2	255,5	0,04	130,0
2010	67.4	177.1	0.04	131.2
2011	55.5	107.5	111,6	129,8
2012	217.7	63.1	0.04	147.7
2013	37.3	85.8	19.1	85.8
2014	33.0	138.6	0.01	16.9
2015	276.7	61.3	0.03	0.7
2016	82.7	404.1	0.03	19.0
2017	46.4	45.9	7.2	0.6

Хохиролд учирсан талбайн ихэнх хувийг түймэр, өвчин хортон шавьжинд идэгдсэн талбай эзэлж байгаа нь өнгөрсөн жил хур бороо багатай, хуурайшилттай холбоотой байна.

Түймэрт шатсан ой Сэлэнгэ, Төв, Хэнтий, Булган аймгууд зонхилж байгаа бол өвчин хортон шавьжид идэгдсэн талбай Сэлэнгэ, Архангай, Булган аймагт их байна.

### УСНЫ САН БҮХИЙ ГАЗАР

2016 онд усны сан бүхий газрын 214,2 га талбай хохирол өртсөн гэсэн дүн гарч байсан бол 2017 онд нийт 6056.6 га хохиролд өртсөн байна. Үүнийг ангилж үзвэл гадаргын болон гүний усны бохирдолтой 0.5 хувь буюу 28.9 га, ашигт малтмалын олборлолтын улмаас хохиролд өртсөн эрэг хавийн газар 98.8 хувь буюу 5985.8 га, бусад шалтгаанаар 0.7 хувь буюу 42. 0 га талбай тус тус бүртгэгджээ. Энэ жилийн дүнд гол нөлөөлсөн зүйл нь Сэлэнгэ аймагт 5898 га усны сан бүхий газрыг ашигт малтмал олборлолтын нөлөөгөөр өөрчлөлтөд оруулсан байна.

### УХАГДАЖ ЭВДЭРСЭН ГАЗАР

2016 онд 6680,1 га талбай ухагдаж эвдэрсэн байсан бол 2017 онд нийт 3746.5 га талбай ухагдаж эвдэрсэн байна.

Үүнийг ангилж үзвэл геологийн эрэл хайгуулын ажлаас 4.1 хувь буюу 153.9 га, ашигт малтмалын олборлолтоос 83.2 хувь буюу 3117.8 га, батлан хамгаалах аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны улмаас 5.4 хувь буюу 202.8 га, барилга, инженерийн шугам сүлжээ барих, засвар үйлчилгээ хийх ажлаас 5.7 хувь буюу 213.3 га, зам тээвэр холбооны барилга засвар үйлчилгээний ажлаас 1.6 хувь буюу 58.7 га талбай тус тус ухагдаж эвдэрсэн байна.

ЗУРАГ 2.5.7: УХАГДАЖ ЭВДЭРСЭН ГАЗАР, ХУВИАР




## 2.6. ГАЗАР ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН /МАЯГТ ГТ-7/

Улсын хэмжээнд газар хамгаалах арга хэмжээний тайланг ГТ-7 маягтын дагуу нэгтгэхэд нийт 1939033.5 га газарт хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан байна.

Үүнээс тариалангийн газрын 175536.1 га, бэлчээр ба бусад өвслөг ургамал бүхий газрын 1619998.0 га, хот тосгон бусад суурин газрын 21639.3 га, ойн сан бүхий газрын 120515.3 га, усны сан бүхий газрын 212.3 га, уурхайн эдэлбэр газрын 1132.4 га газарт тус тус хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан байна /Зураг/.


ЗУРАГ 2.6.1: ГАЗАР ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ, АЙМГААР



ЗУРАГ 2.6.2: ГАЗАР ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ, ХУВИАР



ЗУРАГ 2.6.3: ГАЗАР ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ, ГА-ААР




## ТАРИАЛАНГИЙН ГАЗАР

2016 онд тариалангийн 193,9 мян.га газарт нөхөн сэргээх, хамгаалах арга хэмжээ авч байсан бол 2017 онд нийт 175,1 мян.га талбайд уг арга хэмжээг хэрэгжүүлжээ.

Үүнийг ангилан авч үзвэл 303,1 га талбайд олон наст ургамал тариалж, 26444.5 га талбайд зурваслан тариалж, 61.6 га талбайг ойн зурвасаар хамгаалан, 34493.6 га талбайд химийн, 39176,9 га талбайд шим ба эрдэс бордоогоор бордож, 75056.4 га талбайд хортон шавьж, мэрэгчдийн хөнөөлтэй тэмцсэн байна. /Зураг 2.6.4/.

■ ЗУРАГ 2.6.4: ТАРИАЛАНГИЙН ТАЛБАЙН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ, ХУВИАР




### БЭЛЧЭЭРИЙН ГАЗАР

2016 онд бэлчээрийн 1.9 сая.га газарт нөхөн сэргээх, хамгаалах арга хэмжээ авч байсан бол 2017 онд нийт 1.6 сая.га талбайд хэрэгжүүлсэн байна.

Нийт 1619998.0 га бэлчээрт хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан бөгөөд элсний нүүлтээс 58.1 га бэлчээрийг хамгаалж, 6235.2 га бэлчээрийг тордон сайжруулж, 756651.2 га бэлчээрт хортон мэргэгчдийн хөнөөлтэй тэмцсэн бол 877.9 га бэлчээрийг хог хаягдлаас цэвэрлэж, 186841.2 га бэлчээрийг даацыг нь тохируулан ашиглаж, 40459.0 га бэлчээрийг ашиглалтаас чөлөөлж, 628875.4 га бэлчээрийг сэлгэж ашигласан байна. /Зураг 2.6.5/.

■ ЗУРАГ 2.6.5: БЭЛЧЭЭР БА БУСАД ӨВСЛӨГ УРГАМАЛТ ГАЗАРТ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ, ХУВИАР



### ХОТ, ТОСГОН, БУСАД СУУРИНЫ ГАЗАР

Хот, тосгон, бусад суурины газрын хувьд нийт 21639.3 га талбайд хамгаалах арга хэмжээ авснаас 8.0 га газарт хөрсжүүлэн зүлэгжүүлсэн, 235.1 га газарт мод бут сөөг тарьсан, 2.7 га газрыг далан хаалтаар хамгаалсан, 71.3 га нүх жалгыг тэгшилж янзалсан, 21311.2 га ахуйн хог хаягдлаас цэвэрлэсэн, 11.2 га газрыг үйлдвэрийн хог хаягдлаас цэвэрлэсэн байна.

2016 онд хот суурин газрын 10.7 мян.га газарт нөхөн сэргээх, хамгаалах арга хэмжээ авч байсан бол 2017 онд нийт 21.6 мян.га талбайд хэрэгжүүлсэн байна.



## ОЙН САН БҮХИЙ ГАЗАР

Ойн сан бүхий газарт нийт 120515.3 га талбайд хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан бөгөөд 3236.9 га газарт ойд цэвэрлэгээ хийж, 112914.6 га газарт ойн өвчин, хортон шавьжтай тэмцэж, 4363.8 га газарт мод, бут, сөөг шинээр тарьж, нөхөн суулгалт хийсэн байна.

2016 онд хот суурин газрын 100.7 мян.га газарт нөхөн сэргээх, хамгаалах арга хэмжээ авч байсан бол 2017 онд нийт 120.5 мян.га талбайд хэрэгжүүлсэн байна.

## УСНЫ САН БҮХИЙ ГАЗАР

Усны сан бүхий газарт нийт 212.3 га газарт хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан бөгөөд 57.9 га газарт ус, усан орчныг цэвэрлэх, цэвэршүүлэх арга хэмжээг, 154.5 га газарт усны эх булаг, эрэг орчмын газрын хөрсийг цэвэрлэж хамгаалах арга хэмжээг тус тус авчээ.

2016 онд хот суурин газрын 676.4 га газарт нөхөн сэргээх, хамгаалах арга хэмжээ авч байсан бол 2017 онд нийт 212.3 га талбайд хэрэгжүүлсэн байгаа нь 464,1 га-аар бага байна.

## УУРХАЙН ЭДЭЛБЭР ГАЗАР

Геологийн эрэл хайгуул, уул уурхайн ашиглалтын явцад ухагдаж эвдэрсэн 1132.4 га газарт хамгаалалтын арга хэмжээ авснаас 847.3 га талбайг эргүүлэн дарж булсан, 285.2 га дарж булсан талбайг хөрсжүүлж ургамалжуулсан /биологийн нөхөн сэргээлт хийсэн/ байна.

2016 онд хот суурин газрын 1561.9 га газарт нөхөн сэргээх, хамгаалах арга хэмжээ авч байсан бол 2017 онд нийт 1132.4 га талбайд хэрэгжүүлсэн нь 429.5 га-аар бага байна.


## 2.7. ГАЗРЫН ТӨЛБӨР НОГДУУЛАЛТ, ТӨЛӨЛТ /МАЯГТ ГТ-8/

Улсын хэмжээнд Газрын төлбөрийн тухай хууль болон Засгийн газрын 1997 оны “Газрын төлбөрийн хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 152 дугаар тогтоол, ГХБГЗЗГ /хуучин нэрээр/-н даргын 2011 оны “Газрын төлбөр ногдуулах аргачилсан заавар” 531 дүгээр тушаал, ГХБГЗЗГ /хуучин нэрээр/-ын, ТЕГ-ын хамтарсан 2012 “Газрын төлбөр, албан татвар төлөгчийн мэдээллийн санг хөтлөх, мэдээ, тайлан солилцох журам” 01/01 дүгээр тушаалын дагуу газрын төлбөрийг ногдуулж, төвлөрүүлж байна. Газрын төлбөрийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш газрын төлбөрийн орлогоос орон нутгийн төсөвт өссөн дүнгээр нийт 479 тэрбум 64 сая төгрөгийг төвлөрүүлээд байна /Хүснэгт 2.7.1, Зураг 2.7.1/.

■ ХҮСНЭГТ 2.7.1: ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН ГҮЙЦЭТГЭЛ /ОН ТУС БҮРЭЭР/

Он	Газрын төлбөрийн төлөвлөгөө /сая.төг/	Гүйцэтгэл / сая.төг/	Гүйцэтгэл /%/
1998	1919.6	1524.5	80
1999	2678.6	1764.2	66
2000	3221.5	2895.0	90
2001	4673.6	5401.9	116
2002	5570.7	6163.1	110
2003	7303.4	7962.0	109
2004	11840	11795.2	99
2005	13867.6	14045.2	101
2006	14323.0	15780.7	110
2007	19786.8	20093.7	102
2008	24790.4	25543.4	102
2009	28006.6	29472.4	105
2010	29311.7	30448.6	104
2011	31280.7	33556.8	107
2012	39031.3	43623.2	112
2013	37912.0	43185.1	114
2014	42326.9	44950.9	106
2015	45712.56	44556.18	97
2016	47002.63	46940.38	99.87
2017	47683.35	49361.92	103.5
Нийт	458516.20	479064.38	

■ ЗУРАГ 2.7.1: ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ГҮЙЦЭТГЭЛ /ОН ТУС БҮРЭЭР/




Тайлант оны байдлаар улсын хэмжээнд газрын төлбөрийн орлогоос нийт 49 тэрбум 361.92 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, газрын төлбөрийн төлөвлөгөө 1 тэрбум 678.57 сая төгрөгөөр давж биелсэн бөгөөд гүйцэтгэл 103.5 хувьтай байна /Хүснэгт 2.7.2/.

Тайлант оны газрын төлбөрийн орлогыг өмнөх онтой харьцуулахад 2 тэрбум 421.54 сая төгрөгөөр өссөн дүнтэй байгаа нь жил ирэх бүр газар эзэмшигч, ашиглагч иргэн, хуулийн этгээдийн тоо нэмэгдэж байгаатай холбоотой юм.


**ХҮСНЭГТ 2.7.2: АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН 2017 ОНЫ ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

№	Аймаг, Нийслэл	Газрын төлбөрийн төлөвлөгөө /мян.төг/	Гүйцэтгэл /мян.төг/	Гүйцэтгэл /%/
1	Архангай	33000.60	57507.90	174.26
2	Баянхонгор	120000.00	149743.45	124.79
3	Баян-Өлгий	102912.00	112103.50	108.93
4	Булган	221000.00	334839.00	151.51
5	Говь-Алтай	174390.50	189449.60	108.64
6	Говьсүмбэр	90000.00	117471.34	130.52
7	Дархан-Уул	652000.00	664715.56	101.95
8	Дорнод	391831.30	431370.60	110.09
9	Дорноговь	414620.20	437079.00	105.42
10	Дундговь	190000.00	183855.56	96.77
11	Завхан	185000.00	194758.74	105.27
12	Орхон	8300000.00	9192796.38	110.76
13	Өвөрхангай	103094.87	107916.18	104.68
14	Өмнөговь	3525100.00	3679082.90	104.37
15	Сүхбаатар	100000.00	125235.99	125.24
16	Сэлэнгэ	392887.00	418812.00	106.60
17	Төв	1628730.90	1657057.88	101.74
18	Увс	135000.00	146817.74	108.75
19	Ховд	123960.00	143480.58	115.75
20	Хөвсгөл	167821.30	237922.99	141.77
21	Хэнтий	132000.00	185132.47	140.25
22	Нийслэл	30500000.00	30594767.99	100.31
23	НИЙТ	47683348.67	49361917.35	103.52

ЗУРАГ 2.7.2: ТАЙЛАНТ ОНЫ ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ГҮЙЦЭТГЭЛ /ОРХОН, ӨМНӨГОВЬ, ТӨВ, НИЙСЛЭЛЭЭС БУСАД/



ЗУРАГ 2.7.3: ТАЙЛАНТ ОНЫ ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ГҮЙЦЭТГЭЛ /ОРХОН, ӨМНӨГОВЬ, ТӨВ, НИЙСЛЭЛ/



2017 оны газрын төлбөрийн орлогын гүйцэтгэлийг аймаг, нийслэл тус бүрээр авч үзвэл Дундговь аймгаас бусад аймаг, нийслэл нь газрын төлбөрийн орлогын төлөвлөгөөг 100.3-174.3 хувийн гүйцэтгэлтэйгээр давуулан биелүүлсэн байна.

Газрын төлбөрийн орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн аймаг, нийслэлийн Газрын албаны хувьд хууль тогтоомжийн дагуу газрын төлбөрийг газар эзэмшигч, ашиглагч иргэн, аж ахуйн нэгж бүрт ногдуулж, хураан барагдуулах ажлыг батлагдсан журам, зааврын дагуу хэрэгжүүлэн ажиллав. Мөн газрын төлбөрийн өр барагдуулах дараах ажлуудыг зохион байгуулж ажилласан байна. Үүнд:

- Газрын төлбөрийн орлогыг бүрэн төвлөрүүлэх, тасалдаж байгаа орлогын хэмжээг нэмэгдүүлэх, төлбөр барагдуулалтын талаарх мэдээ, газар эзэмших,


ашиглах гэрээг дүгнүүлэх зорилгоор хэвлэл мэдээллийн хэрэгсэл, байгууллагын цахим хуудас зэргээр зар сурталчилгаа явуулах;

- Газрын төлбөр барагдуулах тодорхой хугацааны аян зохион байгуулах;
- Газар эзэмших, ашиглах гэрээний нөхцөл болзлын дагуу гэрээг дүгнэх;
- Тодорхойгүй орлогын талаар арилжааны банкуудтай хамтран ажиллах;
- Газрын төлбөрийн их хэмжээний өртэй аж ахуйн нэгж, байгууллагыг шүүхэд нэхэмжлэх гарган газрын төлбөрийг барагдуулах.

Газрын төлбөрийн орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй Дундговь аймгийн хувьд:


- Эзэмшил газраа 2 жил дараалан хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ашиглаагүй, газрын төлбөрийг цаг хугацаанд нь төлөөгүй зэргээр Газрын тухай хууль болон газар эзэмшүүлэх, ашиглуулах гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй газар эзэмшигч, ашиглагч нарт тухайн шатны Засаг даргын шийдвэрээр газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээг хүчингүй болгон хариуцлага тооцон холбогдох төлбөр тооцоонд хасалт хийгдсэн;
- Уул уурхайн үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж үйл ажиллагаагаа зогсоож төсөв хөрөнгө байхгүй шалтгаанаар газрын төлбөр төлөхгүй байх;
- Мал бүхий иргэд бэлчээрийн газрын төлбөрийг төлдөггүй зэрэг шалтгааны улмаас газрын төлбөрийн орлогын төлөвлөгөөг тасарсан гэж үзэж байна.

ЗУРАГ 2.7.4: ТАЙЛАНТ ОНЫ ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ /ХУВИАР/



2017 онд газрын төлбөрөөс орон нутгийн төсөвт оруулсан орлогыг газрын нэгдмэл сангийн ангиллаар авч үзвэл хамгийн их хувийг хот тосгон, бусад суурины газар болон тусгай хэрэгцээний газар, хамгийн бага хувийг усны сан бүхий газар, зам, шугам сүлжээний газрын төлбөр эзэлж байна. Энэ нь хот суурин газрын эрх зүйн харилцаа үүссэн нэгж талбарын тоо бусад ангиллын эрх зүйн харилцаа үүссэн нэгж талбарын тооноос харьцангуй их байгаатай холбоотой юм /Зураг 2.7.5/.

ЗУРАГ 2.7.5: ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН ОРЛОГО ТӨВЛӨРҮҮЛЭЛТ  
/ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН АНГИЛЛААР, ХУВИАР/



#### ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДАЛ:

Газрын төлбөрийн тухай хуулинд газрын төлбөрийг Газрын албаны мэргэжилтэн, газрын даамал хураан төсөвт төвлөрүүлнэ гэж заасан байдаг. Гэвч дээрх албан хаагчид байцаагчийн эрхгүйгээс шалтгаалан хураах, төвлөрүүлэх эрх зүйн чадамжгүй байдаг.

Аймгийн хэмжээний газрын төлбөрийн орлогыг төвлөрүүлж буй данс /төрийн сангийн данс/ нэг байдагтай холбоотойгоор газар эзэмшигч, ашиглагчийн нэрээр бус төлбөр тушаагч иргэний нэрээр тэмдэглэх, аль сумаас орлого орж байгаа нь тодорхойгүй байх зэргээс шалтгаалан сум тус бүрээр барагдуулалтыг гаргаж төлбөр хянахад хүндрэл гарч байна.

Газрын төлбөрийн ногдуулалт дээр үндэслэлгүйгээр орлогын төлөвлөгөөг Сангийн яамнаас зохиомлоор нэмэх байдал гарч байгаа нь орлого бүрэн төвлөрөхгүй байх шалтгаан болж байна.

Мөн аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, нийслэлийн Газрын алба нь газрын төлбөрийг ногдуулан хурааж улсын төсвийг бүрдүүлэхэд багагүй хувь нэмэр оруулж байгаа хэдий ч Газрын төлбөрийн тухай хуулийн 10.2-д заасан газар зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх зардлын эх үүсвэргүйгээс төрийн өмчийн газрыг хамгаалах, нөхөн сэргээх, түүний төлөв байдал чанарыг тодорхойлж тасралтгүй хянаж байх үйл ажиллагаа алдагдах, газар зохион байгуулалтын төлөвлөгөө хэрэгжихгүй байгаагаас газрын зөрчил маргаан гарах нөхцөл шалтгаан болж байна. Иймд дээрх арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд санхүүгийн эх үүсвэр шаардлагатай байх бөгөөд үүнийг зохих хуулийн хүрээнд газрын төлбөрийн орлогын хэсгээс санхүүжүүлэх нь зүйтэй байна.

#### АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ АРГА ХЭМЖЭЭ

Аймгийн хэмжээнд газрын төлбөрийн орлогыг төвлөрүүлдэг данс нэг байдагтай холбоотойгоор сум тус бүрийн газрын төлбөрийг тодорхой гаргаж, төлбөрийг нэгж

талбар тус бүрээр ногдуулж барагдуулах, хэд хэдэн газартай газар эзэмшигчийн газрын төлбөрийн давхардлыг арилгах, хянах зорилгоор сар бүр газрын төлбөрийн хуулгыг боловсруулж, сумдын даамлуудтай харилцан мэдээлэл солилцож, ажлын уялдааг нэмэгдүүлэн ажиллаж байна.

Мөн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй банкуудад төлбөр төлөгч иргэдийн сумын нэр, регистрийн дугаарыг давхар бичилт хийж өгөх талаар газрын даргын албан тоотыг хүргүүлэн ажиллаж байгаа ба аймгийн Татварын хэлтсийн мэргэжилтнүүдтэй тодорхойгүй орлогын талаар өдөр бүр тогтмол холбогдож, газрын төлбөр барагдуулах тооцоо нийлэх асуудлаар хамтран ажиллаж байна.

Аймгуудын зүгээс урьд оны дутуу төлөлт, газрын төлбөрийг барагдуулах төлбөрийн гүйцэтгэлийг хангахын тулд аймаг, сумын Засаг дарга, Татварын хэлтэстэй хамтран Газрын төлбөр барагдуулах тодорхой хугацааны аян зохион байгуулах, олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдэгдэл, мэдээлэл явуулж ажилласан ба үүрэн телефоны корпорациатай хамтран ажиллаж “Мобайл сурталчилгааны үйлчилгээ”-г нэвтрүүлэх гэрээ байгуулж, газрын төлбөр төлөгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагад текстэн зар хүргүүлэх ажлыг зохион байгуулан ажилласан байна.

Ингэснээр аймгийн хэмжээнд нийтийг хамарсан мессежийг /текстэн зар/ газрын төлбөр төлөгч бүрт шуурхай хүргэж, газар эзэмших гэрээний нөхцөл болзлын дагуу гэрээгээ дүгнүүлэх, урьд онуудад төлж барагдуулаагүй өр авлагыг барагдуулахад томоохон ажлуудын нэг болсон байна.

Мөн газар эзэмшигч, өмчлөгч, ашиглагч нь интернетээр компьютер, гар утас, таблет ашиглан газрын төлбөр, татвараа төлөх боломжийг бүрдүүлэхээр ажиллаж байна.

## 2.8. ГАЗАР ӨМЧЛӨЛИЙН ТАЙЛАН /МАЯГТ ГТ-9/

2017 оны байдлаар Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн дагуу улсын хэмжээнд өссөн дүнгээр нийт 570771 иргэний 57767.26 га газрыг өмчлөх эрхийг баталгаажуулсан байна.

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль анх 2002 оны 6 дугаар сарын 27-ны өдөр батлагдаж, 2003 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн билээ.

Хууль хэрэгжиж эхэлснээс хойшхи хугацаанд Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд 4 удаа нэмэлт өөрчлөлт орсон бөгөөд 2008 оны 5 дугаар сарын 22-ны өдөр Монгол Улсын иргэн бүрт гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газрыг хуульд заасан хэмжээгээр нэг удаа үнэ төлбөргүйгээр өмчлүүлэхээр нэмэлт өөрчлөлт орсон.

2012 оны 5 дугаар сарын 18-ны өдөр “Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль”-ийн 4.1.1-д заасан зориулалтаар Монгол улсын иргэнд газрыг нэг удаа үнэгүй өмчлүүлэх тухай энэхүү хуулийн 19.1.2, 19.1.3, 19.1.4 дэх заалтыг 2018 оны 5 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл дагаж мөрдөхөөр өөрчлөлт орсон.

Тус газраас иргэнд газрыг нэг удаа үнэгүй өмчлүүлэх хуулийн хугацаа дуусч байгаатай холбогдуулан Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг шинэчлэн боловсруулж, батлуулахаар Засгийн газарт саналыг хүргүүлээд байна.


Мөн Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль хэрэгжиж эхэлснээс

хойшхи улсын хүн амын тоог, газар өмчлөгч иргэдийн тоотой харьцуулан үзэхэд 2009 болон 2012 онуудад тодорхой хувиар буурсан үзүүлэлттэй байгаа нь газар өмчлүүлэх хугацаа дуусах үед газар өмчлөл эрчимжиж, сунгасны дараах үед нь буурч байгаа нь харагдаж байна /Хүснэгт 2.8.1, Зураг 2.8.1/.

■ ХҮСНЭГТ 2.8.1: ХУУЛЬ ХЭРЭГЖИЖ ЭХЭЛСНЭЭС ХОЙШХИ ГАЗАР ӨМЧЛӨЛИЙН БАЙДАЛ

№	Он	МУ-ын нийт иргэдийн тоо /он	Газар өмчилсөн нийт иргэдийн тоо /он тус бүрээр	Хувь
1	2003	2495091	21879	0.9
2	2004	2521733	63867	2.5
3	2005	2551081	135077	5.3
4	2006	2583254	152164	5.9
5	2007	2620446	174016	6.6
6	2008	2665955	222094	8.3
7	2009	2716275	203043	7.5
8	2010	2760968	255749	9.3
9	2011	2811666	255747	9.1
10	2012	2867744	330240	11.5
11	2013	2930277	371978	12.7
12	2014	2995949	418671	14.0
13	2015	3057778	446004	14.6
14	2016	3119935	537321	17.2
15	2017	3119935	570771	18.3

■ ЗУРАГ 2.8.1: 2003-2017 ОНУУДЫН ГАЗАР ӨМЧЛӨЛИЙН БАЙДЛЫГ ИРГЭДИЙН ТООТОЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ /ОН ТУС БҮРЭЭР/





Тайлбар: 2017 оны байдлаар Монгол улсын хүн амын тоо аймаг, нийслэлийн хэмжээнд нэгтгэгдэж, албан ёсоор гараагүй тул өмнөх оны /2016/ тоон мэдээг ашигласан болно.

Улсын хэмжээнд газар өмчилж авахаар нийт 604425 хүсэлт ирүүлснээс хуульд нийцүүлэн шинээр 57585.5 га газрыг 569741 иргэнд өмчлүүлснээс, улсын чанартай замын дагуу 445.44 га газрыг 6358 иргэнд өмчлүүлсэн байна.

Гэр бүлийн хэрэгцээнд үнээр нь худалдаж 5.59 га газрыг 654 иргэнд, Аж ахуйн зориулалтаар давуу эрхээр худалдаж 27.43 га газрыг 217 иргэнд, Аж ахуйн зориулалтаар дуудлага худалдаагаар 1.42 га газрыг 31 иргэнд, Газар тариалангийн зориулалтаар дуудлага худалдаагаар 147.36 га газрыг 128 иргэнд худалдаж тус тус өмчлүүлээд байна.

Улсын хэмжээнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар нэг удаа үнэ төлбөргүй газар өмчилсөн иргэдийг аймаг тус бүрээр харьцуулж, хүснэгт 2.8.2-т үзүүлэв.

**ХҮСНЭГТ 2.8.2: ҮНЭГҮЙ ГАЗАР ӨМЧИЛЖ АВСАН ИРГЭДИЙГ ХҮН АМЫН ТООТОЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ**

№	Аймаг	Хүн амын тоо	Өмчилсөн иргэдийн тоо	Хүн амын газар өмчилсөн байдал /хувиар/
1	Архангай	93135	14955	16.1
2	Баян-Өлгий	100172	12125	12.1
3	Баянхонгор	84807	10957	12.9
4	Булган	60603	13957	23.0
5	Говь-Алтай	56587	6376	11.3
6	Говьсүмбэр	16926	8705	51.4
7	Дархан-Уул	101876	13256	13.0
8	Дорноговь	66450	16750	25.2
9	Дорнод	77579	33715	43.5
10	Дундговь	44762	12863	28.7
11	Завхан	70546	8989	12.7
12	Орхон	101789	18740	18.4
13	Өвөрхангай	113157	21424	18.9
14	Өмнөговь	63307	29772	47.0
15	Сүхбаатар	59810	9758	16.3
16	Сэлэнгэ	107513	40465	37.6
17	Төв	91660	51799	56.5
18	Увс	81278	10409	12.8
19	Ховд	84486	12261	14.5
20	Хөвсгөл	129382	12857	9.9
21	Хэнтий	73663	19797	26.9
22	Улаанбаатар	1440447	189811	13.2
Улсын дүн		3119935	569745	18.3

Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар нэг удаа үнэ төлбөргүй газар өмчилсөн иргэдийн тоог аймгийн хүн амын тоотой харьцуулахад хамгийн их хувьтай нь Төв аймаг 56.5, Говьсүмбэр аймаг 51.4, Өмнөговь аймаг 47.0 байгаа бол хамгийн бага хувьтай нь Хөвсгөл аймаг 9.9, Говь-Алтай аймаг 11.3, Баян-Өлгий аймаг 12.1 байна.

Тайлант онд 33450 иргэнд 3416.88 га газрыг өмчлүүлсэн байна. Үүнээс:

- Гэр бүлийн хэрэгцээнд нэг удаа үнэгүйгээр 33355 иргэнд 3403.11 га газрыг,
- Гэр бүлийн хэрэгцээнд үнээр нь худалдаж 79 иргэнд 1.15 га газрыг,
- Аж ахуйн зориулалтаар давуу эрхээр худалдаж 11 иргэнд 0.54 га газрыг,
- Газар тариалангийн зориулалтаар давуу эрхээр худалдаж 5 иргэнд 12.00 га газрыг тус тус өмчлүүлсэн байна.

2017 онд нийт газар өмчилж авсан иргэдийн тоон өсөлтийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээр харьцуулан үзвэл Төв аймаг 8280 иргэн, Өмнөговь аймаг 5128 иргэн, нийслэл 4334 иргэнд газар өмчлүүлсэн бол Баянхонгор аймаг 300 иргэнд, Говь-Алтай аймаг 351 иргэнд, Увс аймаг 370 иргэнд тус тус өмчлүүлсэн дүнтэй байна.

Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд “газар өмчилж авахыг хүссэн Монгол улсын иргэн сайн дурын үндсэн дээр өмчилнө” гэж заасан бөгөөд тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршлыг тогтоохдоо аймаг, нийслэлийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө, Хотын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө зэрэг инженер, нийгмийн дэд бүтцийн иж бүрэн төлөвлөлт, зураг төслийн баримт бичигт нийцүүлэн боловсруулах нь чухал ач холбогдолтой юм.

# 3

## ДҮГНЭЛТ

Газрын нэгдмэл сангийн хувьд 2017 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын газрын нэгдмэл санд хөдөө аж ахуйн газар 114843.6 мянган га буюу 73.4 хувь, хот, тосгон бусад суурины газар 840,1 мянган га буюу 0.5 хувь, зам, шугам сүлжээний газар 471.7 мянган га буюу 0.3 хувь, ойн сан бүхий газар 14341.3 мянган га буюу 9.2 хувь, усны сан бүхий газар 686.1 мянган га буюу 0.4 хувь, улсын тусгай хэрэгцээний газар 25228.9 мянган га буюу 16.1 хувийг тус тус эзэлж байна

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас газрын нэгдмэл сангийн ангиллын мэдээллийг суурин аргаар буюу хиймэл дагуулын зураг, байр зүйн зургийн тодотгол болон бусад шаардлагатай тоон мэдээллийг ашиглан шинэчлэх ажлыг 21 аймаг, нийслэлийн хэмжээнд хийж гүйцэтгээд байна. Тухайн мэдээллийг улсын хэмжээнд нэгтгэн Газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.10-д төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхэд “газрын нэгдмэл сангийн үндсэн ангилалд хамаарах газрыг тогтоох болон нэг ангиллаас нөгөөд шилжүүлэх асуудлыг Засгийн газарт оруулан шийдвэрлүүлэх” асуудлыг хамааруулсны дагуу ажлын үр дүнг Засгийн газарт хуралдаанд танилцуулахаар бэлдэж байна.

Мөн газрын нэгдмэл сангийн мэдээллийг улсын хэмжээнд Газрын кадастрын мэдээллийн сангийн Лэнд менежер програм хангамжид оруулснаар газрын нэгдмэл сангийн тайланг тус програм хангамжаас гаргах нөхцөл бүрдэх юм.

Газрын улсын бүртгэлээр 2017 онд улсын хэмжээнд нийт 1036117 газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч байгаа нь өмнөх оныхоос нийт дүнгээрээ 68547-аар өссөн байна.

2017 онд улсын хэмжээнд өмчлөгчийн тоо 33450-аар, газар эзэмшигчийн тоо 34958-аар, газар ашиглагчийн тоо 88-аар тус тус өссөн бөгөөд 2017 оны өссөн дүнгээр нийт 1061 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага өөрийн эзэмшлийн газрыг бусдад ашиглуулж байна.

Газар өмчлөлийн тайлан, мэдээнээс харахад хууль хэрэгжиж эхэлснээс хойшхи 15 жилийн хугацаанд Монгол улсын нийт хүн амын 18 хувь нь газар өмчлөх эрхээ хэрэгжүүлсэн байгаа нь иргэн бүрт газар өмчлүүлэх ажлын явц хангалтгүй байгааг харуулж байна.

Газрыг нэг удаа үнэгүй өмчлүүлэх хугацаа 2018 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөр дуусаж байгаатай холбогдуулан Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулан батлуулах ажлыг зохион байгуулж байна.

2017 онд улсын хэмжээнд 583 удаа газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдааг зохион байгуулснаас 380 дуудлага худалдаа хүчинтэй болж, 8007.27 га газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлжээ. Энэ нь өмнөх онтой харьцуулбал газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа зохион байгуулсан тоо 13.2 хувиар буурсан бол эзэмшүүлсэн газрын хэмжээ 3884.56 га-гаар нэмэгдсэн байна.

Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолоор “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-д цахим хэлбэрээр дуудлага худалдааг зохион байгуулахаар журамласны дагуу 2016 онд Сэлэнгэ, Ховд, Хэнтий зэрэг 3 аймаг цахим дуудлага худалдаа зохион байгуулсан бол 2017 онд Архангай, Баян-Өлгий, Булган, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Хэнтий, Хөвсгөл зэрэг 12 аймаг дуудлага худалдааг цахим хэлбэрээр зохион байгуулсан байна.

2017 онд газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаагаар улсын хэмжээнд нийт **4 тэрбум 304 сая 696 мянган** төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлснээс Дорноговь аймгаас 27.9 хувь буюу 1 тэрбум 202 сая төгрөг, нийслэлээс 17.8 хувь буюу 765 сая төгрөг, Дорнод аймгаас 12.9 хувь буюу 556 сая төгрөг, Орхон аймгаас 9.8 хувь буюу 420 сая төгрөг, Дархан-Уул аймгаас 9.5 хувь буюу 406 сая төгрөгийг тус тус төвлөрүүлснээр тэргүүлж байна.

Газрын төлбөрийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш газрын төлбөрийн орлогоос орон нутгийн төсөвт өссөн дүнгээр нийт **479 тэрбум 64 сая** төгрөгийг төвлөрүүлээд байна. 2017 онд улсын хэмжээнд газрын төлбөрийн орлогоос нийт **49 тэрбум 361.92 сая** төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, газрын төлбөрийн төлөвлөгөөг **103.5** хувиар биелүүлсэн ба өмнөх оны газрын төлбөрийн орлоготой харьцуулахад 2 тэрбум 421.54 сая төгрөгөөр өссөн дүнтэй байна.

2017 онд улсын хэмжээнд 304 удаа газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулснаас 238 хүчинтэй болж 3473.72 га газрыг эзэмшүүлжээ. Энэ нь өмнөх онтой харьцуулж үзвэл газар эзэмшүүлэх эрхийн төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулсан тоо 22.4 хувиар, эзэмшүүлсэн газрын хэмжээ 3758.18 га-гаар тус тус буурсан байна.

2017 онд 20755 га газар буюу ойролцоогоор нийт газар нутгийн **0.012** хувь нь эдийн засгийн эргэлтэнд орсон байна. Харин газар өмчлөх, эзэмших эрхийн санхүүгийн эргэлтийн хэмжээ 949 тэрбум төгрөг болж, 25 хувиар нэмэгдсэн судалгаа гарсан байна.

Тухайн тайлант онд Үндэсний статистикийн хорооны гаргасан судалгаагаар Монгол улсын ДНБ 27167.0 тэрбум төгрөг ба үүнээс газрын зах зээлийн санхүүгийн эргэлтийн хэмжээ ДНБ-ний **3.4** хувийг эзэлж байна.

Газрын биржийн цахим системд 13210 газрын газар, үл хөдлөх эд хөрөнгийн үнийн мэдээ бүртгэгдсэн бөгөөд цаашид зах зээлийн үнийн мэдээний мэдээллийн санг тогтмол хөтөлж, Газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн бүтэц, багтаамж, оролцогч талууд, нөлөөлөх хүчин зүйлсийг судлах, эдийн засгийн үр, өгөөжийг нэмэгдүүлэх, цаашдын хөгжлийн чиг хандлага, төрөөс баримтлах бодлогыг тодорхойлоход чухал ач холбогдолтой байна.

Улсын хэмжээнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас газартай холбоотой нийт 163226 өргөдөл хүсэлтийг орон нутгийн Засаг даргад гаргаснаас нийт өргөдлийн 57.5 хувийг шинээр газар өмчлөх, эзэмших, ашиглах өргөдөл хүсэлт эзэлж байна.

Үүнээс үзэхэд газартай холбоотой харилцаа улам ихээр өсөн нэмэгдэж, эдийн засгийн хөгжлийг тодорхойлох хүчин зүйлүүдийн нэг болж байна. Иймд тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулахдаа газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон бусад хууль тогтоомж дүрэм, норм нормативтай уялдуулан боловсруулж, тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу газар олголтыг хийж байх шаардлагатай байгаа юм.

Сүүлийн жилүүдэд буюу 2015, 2016, 2017 онуудын байдлаар бүх шатны шүүх байгууллагад хянагдаж байгаа хэргүүдийн 5 хэрэг тутмын 1 нь газартай холбоотой байна. Тухайн маргаануудын хариуцагчаар ихэнх тохиолдолд Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Ашигт малтмалын газар, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нар газрыг давхардуулан олгосон гэсэн үндэслэлээр татагдаж байна. Иймд газар олгогч нар Газрын кадастрын мэдээллийн нэгдсэн системд холбогдсон байх, салбар хоорондын уялдаа холбоог сайжруулах шаардлага гарч байгаа юм.

Улсын хэмжээнд харьяалах нутаг дэвсгэрийн хилийн цэсийн гадна буюу өөр сум, дүүргийн нутаг дэвсгэрт газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгосон нийт 4414 зөрчилтэй нэгж талбар байна.

Энэхүү зөрчлийг арилгахдаа Газрын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх авсан, үүргээ биелүүлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрхийг зөрчил гаргасан аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга өөрөө буюу дээд шатны Засаг дарга хүчингүй болгон, харьяа аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын захирамж, шийдвэрээр шинэчлэн баталгаажуулж, харин газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийг хууль тогтоомжид заасны дагуу аваагүй, мөн холбогдох хууль болон гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй нь тогтоогдсон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийг хүчингүй болгох ажлыг нэн даруй зохион байгуулах шаардлагатай байна.

Жил бүр сүм, дүүргийн Засаг дарга 12-р сарын 15-ны дотор аймаг, нийслэлийн Засаг даргад, аймаг, нийслэлийн Засаг дарга дараа оны 01-р сарын 15-ны дотор Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тус тус гаргана.

Засгийн газрын 2003 оны 204 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН АНГИЛЛЫН 2017 ОНЫ ТАЙЛАН /га-гаар/ Маягт ПТ-1

Д/А	Нийт	Бүл	Бэлчээрийн газар		Үүнээс		Хадлангийн талбай	Тарианлагийн газар			Үүнээс				Атарсан газар	Хөдөө аж ахуйн нийгэмлэг дээр газар				Үүнээс				Хөдөө аж ахуйн нийгэмлэг
			Бүл		Хөдөө аж ахуйн газар	Хөдөө аж ахуйн газар		Төмс, хүнсний ногоо тариансан талбай	Тэжээлийн тариансан талбай	Тариал үржүүл, жинс жижигтэй тариансан талбай	Уришилсан талбай	Өнжөөсөн талбай	Хөдөө аж ахуйн нийгэмлэг дээр газар	Ман аж ахуйн үйлдвэрийн зонилалтай газар		Өвөлжөө, хаажармаа газар	Хөдөө аж ахуйн үйлдвэрийн зонилалтай газар	Хөдөө аж ахуйн үйлдвэрийн зонилалтай газар	Хөдөө аж ахуйн үйлдвэрийн зонилалтай газар					
			Бүл	Нийт																Үүнээс	Хөдөө аж ахуйн газар	Хөдөө аж ахуйн газар	Өвөлжөө, хаажармаа газар	
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21			
1	Архангай	553181.88	3849604.92	3727655.27	2240896.17	1496759.10	53910.00	23566.34	21380.00	1163.14	5.00	98.40	700.00	19.80	33813.70	859.62	665.72	665.72	2.00	191.90	0.00			
2	Баянхонгор	1159779.70	8884481.72	8855287.17	4274768.77	4584518.40	10662.80	2700.75	901.97	1127.58	251.10	6.00	6.00	414.10	9623.00	2017.50	1949.23	1779.39	0.00	68.26	190.50			
3	Баян-Өлгий	4570489.00	3586594.50	3538780.23	1688724.28	1850055.94	12673.92	2609.85	180.00	544.57	497.20	36.90	0.00	1351.88	383.40	32147.10	807.52	807.52	1.40	31838.18	0.00			
4	Булган	4873300.00	2730847.01	2484779.10	1158204.73	1326574.37	11940.10	88827.60	40052.36	467.20	5192.80	917.27	38993.91	3204.06	25427.27	3475.35	3299.13	3248.31	94.25	81.97	16397.60			
5	Говь-Алтай	14144767.01	8621188.38	8609066.03	3471089.73	5137976.30	2627.00	5141.88	152.05	1163.49	475.60	1589.62	340.42	340.42	593.62	3760.55	2699.73	2699.73	1044.70	16.12				
6	Говьсүмбэр	554180.04	485006.49	46987.14	188226.84	281388.30	7810.00	3320.02	177.00	3003.00	140.02				166.51	62.16	62.16			104.35	4092.82			
7	Дархан-Уул	327500.00	22021.84	17693.40	79534.98	97399.42	907.50	34205.46	9607.17	2004.78	799.70	527.65	15791.20	5474.96	103.70	1696.78	669.48	365.72	37.56	989.74	0.00			
8	Дорноговь	10947230.00	958468.71	9157648.10	5480876.31	3676717.9	112.00	546.23	101.20	405.53	6.00	21.00	3.00	9.50	329.30	5500.89	5452.01	4789.50	45.48	3.40	420332.20			
9	Дорнод	12359743.00	9634606.01	8653742.50	4384632.32	4269110.18	839294.08	10168.91	44982.08	435.68	161.00	1395.00	29046.00	25149.15	26655.32	13745.20	13592.11	13592.11	7.00	146.09	0.00			
10	Дундговь	7469032.00	7153119.02	7149136.80	3636247.43	3512889.37	0.00	701.32		190.86	390.50	119.96			3267.90	2368.00	2192.00			899.90	13.00			
11	Завхан	8245566.74	6990208.71	6925699.31	3892151.03	3033548.28	7686.00	6401.32	2326.50	1004.72	786.41	72.29	1829.00	382.40	46158.30	4263.77	4263.77			0.00	0.00			
12	Орхон	84400.00	46271.21	39400.09	1820.04	27580.05	1400.00	5079.62	3282.50	748.93	33.30	34.69	922.20	58.00	253.05	138.45	71.81	71.81	22.91	43.73				
13	Өвөрхангай	6289533.10	574158.34	5690375.19	2845187.59	2845187.59	6586.73	24852.38	9544.36	1072.65	1892.63	2342.74	0.00	0.00	14325.80	5018.24	3240.81	3240.81	46.80	170.63	0.00			
14	Өмнөговь	16538047.00	1795223.31	11541157.2	4775933.7	6662521.95	30.00	749.84	0.00	549.36	182.08	15.40	0.00	3.00	26.81	3305.94	3164.00	3164.00	1.00	140.94	356995.00			
15	Сүхбаатар	8228715.58	7749212.45	767107.12	2947213.42	4723803.70	44488.80	16725.74	0.00	10075.74	6600.00	50.00	0.00	0.00	14433.10	2547.69	2524.10	2524.10	0.67	22.92	0.00			
16	Сэлэнгэ	4115263.00	2059030.02	1613825.63	645984.85	967840.78	123201.50	315270.47	156993.00	4364.61	35910.11	252.64	110018.05	7732.06	2898.10	3826.93	3237.74	2829.93	542.31	46.88	7.40			
17	Төв	7404237.00	5578021.68	5196579.73	2584591.21	2611988.52	63109.45	258245.01	81733.00	7758.70	10908.30	10408.90	69591.10	77845.01	40826.39	4368.39	2359.97	1147.83	751.19	1257.23	14892.70			
18	Увс	6958539.04	4834176.20	4291848.16	1674312.20	2617353.95	22019.37	66598.26	9067.80	399.58	1147.10	1008.21	4845.50	50131.07	2396.86	4626.55	3948.47	3579.87	588.08	90.00	446686.00			
19	Хөвд	7606038.01	5097995.07	5063370.66	3131951.35	1931419.31	17958.25	9044.85	1605.93	3025.11	153.93	518.76	0.00	2381.12	2877.30	4698.40	2750.40	2750.40	30.00	1918.00	7.60			
20	Хөвсгөл	10062818.88	4476090.43	4380185.89	1977564.60	2402621.29	43985.10	33650.08	17813.00	886.12	740.00	228.70	11909.00	2055.26	10685.92	7513.64	7473.36	7473.36	17.70	22.58	89.80			
21	Хэнтий	8032506.00	5488124.67	5068198.90	1896661.25	3171537.66	325997.68	80147.89	19171.00	585.80	8295.40	464.29	23471.00	28160.40	6260.60	7519.60	7098.35	7098.35	87.40	329.00	0.00			
22	Нийслэл	470445.05	236143.99	218069.30	83856.87	134212.43	5587.00	7451.85	0.00	5691.62	326.96	1288.77	0.00	144.50	2939.75	2096.09	1993.86	74.57	12.66	89.57	0.00			
	Нийт дүн	156411575.02	14843547.66	10429332.43	53066019.73	57363240.71	1710152.28	1086785.97	429411.95	43617.16	79994.60	21782.31	307125.96	204853.99	241011.29	116561.07	73696.57	68421.05	3333.10	39531.40	1259704.62			



Д/д	Бүгд	Ангиллын															Усан тээврийн газар, бүгд		
		Зам, шугам сүлжээний газар																	
Үүнээс																			
	Авто замын газар	Улсын чанартай	Орон нутгийн чанартай	Үүнээс			Төмөр замын газар	Үүнээс		Агаарын тээврийн газар	Үүнээс		Шугам сүлжээний газар, бүгд	Үүнээс					Усан тээврийн газар, бүгд
				Улсын чанартай	Аж ахуйн нэгж, байгууллагын дотоодын зориулалттай	Авто тээврийн барилга, байгууламж, зогсоолын талбай		Төмөр замын дагаврын талбай, хамгаалалтын зүвэс газар	Өргөө, зөрлөгийн барилга, байгууламжийн талбай		Агаарын тээврийн газар	Нислэгийн аюулгүй байдлыг хамгаалах бүсийн газар		Барилга байгууламж, төхөөрөмжийн газар	Шугам сүлжээний газар, бүгд	Холбооны шугам, холбооны мэдээлэл үзлэг авах станцын талбай	Эрчим хүчний шугам, станцын эзлэх талбай	Ус, дулаан дамжуулах хөөлөөний эзлэх талбай	
0	41	42	43	44	45	46	47	48	49	50	51	52	53	54	55	56	57	58	59
1	7122.95	3775.55	0.00	3770.55	0.00	5.00	0.00			30.00	29.50	0.50	3317.40	1904.40	1370.00	40.00	3.00	0.00	0.00
2	8067.30	4744.76	1054.98	3643.60	44.20	1.98	0.00			59.10	58.30	0.80	3263.44	1107.54	2072.40	47.00	36.50	0.00	0.00
3	14808.88	13359.90	236.50	13122.29	1.11	0.00	0.00			0.00			1448.98	525.18	923.80	0.00	0.00	0.00	0.00
4	7826.74	2965.12	861.40	2033.10	55.00	15.62	0.00			155.00	143.00	12.00	4706.62	1861.56	2590.31	181.79	28.11	44.85	0.00
5	7622.63	4863.00	434.50	4378.00	48.10	2.40	0.00			188.06	186.80	1.26	2571.57	722.77	1816.80	25.00	2.00	5.00	0.00
6	5256.44	2128.55	747.30	1317.60	63.60	0.05	1358.99	1165.16	193.83	0.00			1768.90	351.76	1399.61	12.97	4.56		0.00
7	6157.45	3407.97	703.38	1121.06	1583.30	0.23	1492.53	1468.34	24.19	0.00			1256.95	39.05	1116.46	12.84	51.46	37.14	0.00
8	57160.19	35420.80	5463.07	28844.43	1021.66	91.64	8125.61	8038.31	87.30	3580.00	3577.00	3.00	10033.79	2269.41	7569.68	188.12	6.50	0.07	0.00
9	50190.04	40201.11	5238.00	34234.51	270.20	458.40	5044.60	4997.30	47.30	289.60	205.80	83.80	4594.73	1439.84	2887.59	28.60	229.10	9.60	0.00
10	31265.74	25731.80	2410.50	20778.00	2538.00	5.30	846.30	465.00	381.30	46.70	45.00	1.70	4640.94	2018.80	2579.84	35.20	4.10	3.00	0.00
11	6583.87	4920.42	193.90	4139.60	586.92	0.00	0.00			91.00	83.00	8.00	1572.45	808.40	762.05	2.00	0.00	0.00	0.00
12	1166.55	257.46	87.70	149.66	20.10		417.32	306.69	110.63	0.00			491.77	55.14	425.58	11.05			0.00
13	24503.86	18118.94	1814.90	16053.69	249.71	0.64	0.00			258.81	257.90	0.91	6126.11	2502.27	3291.72	28.70	17.22	286.20	0.00
14	31251.88	12770.79	1425.90	7847.20	3142.30	355.39	7239.70	6539.70	700.00	878.48	876.03	2.45	10362.91	1242.19	3407.59	5623.60	41.96	47.57	0.00
15	15357.34	7787.35	2.10	7751.90	33.20	0.14	0.00			148.20	148.10	0.10	7421.79	2202.15	5195.12	1.71	22.42	0.39	0.00
16	22075.39	19294.19	2508.10	7682.60	3093.68	9.81	2426.48	2292.54	133.94	78.08	78.08	0.00	6276.64	686.39	5166.93	294.71	77.52	51.10	0.00
17	53454.00	42563.38	17015.20	23152.78	2381.40	14.00	3288.30	3216.30	72.00	1200.00	1200.00	0.00	6402.32	1972.14	4293.99	128.49	2.00	5.70	0.00
18	46135.65	41234.60	10140.00	30575.47	518.30	0.83	0.00			332.10	330.60	1.50	4568.95	1628.05	2911.40	0.00	2.30	27.20	0.00
19	27224.21	24691.15	5919.00	18767.28	2.47	2.40	0.00			355.00	175.40	179.60	278.06	791.40	1233.27	79.16	37.38	36.85	0.00
20	7787.88	3225.02	644.10	2367.52	211.70	1.70	0.00			139.05	137.50	1.55	4422.01	713.17	3699.92	6.62	1.00	1.30	1.80
21	34588.49	29126.34	6816.80	21073.24	1157.30	79.00	213.00	0.00		86.00	68.00	18.00	5163.15	1888.30	3053.35	186.20	15.00	20.30	0.00
22	6142.67	1026.96	555.00	394.92	52.70	24.34	1355.87	1290.27	65.60	895.60	436.00	459.60	2864.24	832.81	1769.98	137.98	60.82	62.65	0.00
	471690.16	335615.16	64272.33	253199.00	17074.95	1068.87	31808.70	29992.61	1816.09	8810.78	8036.01	774.77	95453.73	27562.71	58572.54	9097.15	653.45	675.42	1.80

Маягт ГТ-1-ийн үргэлжлэл 3

д/д	Төрлөөр												Улсын тусгай хэрэгцээний газар
	Ойг сан бүхий газар						Усны сан бүхий газар						
	Бүгд	Үүнээс					Бүгд	Үүнээс					
Ой модоор бүхэлдсэн газар		Ой модыг нь огтолсон газар	Мод үржүүлгийн газар	Ой тэнгэр урхак нөөц газар	Ойг сангийн газар	Гол мөрнийг эзлэх газар		Нүүр, цөөрөм, тойрмын эзлэх газар	Горхи, шандны эзлэх газар	Мөнх цас, голын эзлэх газар	Бүгд		
0	60	61	62	63	64	65	66	67	68	69	70	71	
1	1082621.00	847490.00	2764.00	0.00	0.00	232367.00	25246.00	9337.00	15909.00	0.00	0.00	552058.00	
2	330670.83	298858.50	4220.00	3.33	0.00	27589.00	5118.40	2648.60	48004.00	465.80	534.00	2298818.65	
3	22577.00	22322.00	246.00	9.00	0.00	0.00	46700.00	16240.00	27900.00	2026.00		883766.44	
4	1905003.88	1428665.70	7887.00	47.40	468403.79	313.00	22149.06	12308.06	9111.00	730.00		174353.49	
5	121267.00	1215229.20	5724.80				14254.00	2167.00	12087.00	0.00		4262371.13	
6	0.00						1538.00	64.00	1474.00			55841.96	
7	72041.06	71392.68	415.00	233.38	0.00	0.00	6658.55	6490.00	117.58	50.97		1477.33	
8	158515.10	115464.79	0.00	110.71	0.00	42939.60	27765.50	441.00	25740.57	1583.93		992694.25	
9	174619.40	99319.60	41816.00	1223.30	32260.50	0.00	91135.65	9295.91	81839.74	0.00		2320829.54	
10	68719.63	27124.00	0.00	10255.63	31340.00		7796.00	48.00	7467.50	280.50		189568.03	
11	490582.86	464057.06	5067.00	83.80	270.00	21105.00	80536.00	51045.00	29491.00	0.00		658886.51	
12	15884.40	15576.00		291.40		17.00	221.50	201.50		20.00		142.48	
13	150793.63	129365.87	5968.00	94.47	13244.92	2120.37	8248.59	2921.85	5317.35	9.39		319104.96	
14	753716.94	723668.00	920.00	29128.54	0.40	0.00	15859.50	249.00	14490.00	1120.50		3894105.40	
15	81.75	27.37	42.30	12.08	0.00	0.00	15487.33	275.90	15210.15	1.28		429844.81	
16	1533850.25	1375735.50	21575.50	112.50	27120.00	109306.75	19442.00	18272.00	839.00	331.00		419070.09	
17	573123.23	544913.00	3255.00	7664.23	1193.00	16098.00	14285.00	7485.00	6341.00	459.00		1098627.08	
18	110222.50	72519.90	4512.10	100.00	33090.50		85420.54	29979.10	54714.30	727.14		1865865.96	
19	467888.80	310483.50	395.40	13432.10	95.00	142982.80	43167.00	7503.00	32441.10	2373.90		1934896.05	
20	4005364.96	3383811.12	36455.04	52.50	57070.00	527976.30	86197.00	33298.30	51390.10	1314.10		1468156.03	
21	1130083.21	978194.41	1590.50	20.50	79200.00	71077.80	18776.71	14249.60	3719.43	807.68		1327970.28	
22	74110.29	64653.63	12.00	2097.75	154.71	7192.20	4078.19	3936.10	38.00	104.09		80450.58	
	14341237.72	12188871.84	142865.64	64972.61	743442.82	1210184.82	686080.52	228455.92	443641.82	12405.28		25228899.05	



Маягт ПТ-1-ийн үргэлжлэл 4

Үйлчилгээний нэгж, бүтэц	Үүнээс				Үүнээс				Улсын хилийн зураас газар	Улсын тусгай хамгаалалттай газар, бүтэц	Чөлөөт бүсийн газар	
	Дархан цаазат газар	Байгалийн цогцлолт газар	Байгалийн нөөц газар	Дүрсгалт газар	Урьдчилан хамгаалах болон аюулгүй байдлыг олгосон газар	Гадаад улсын дипломат төлөөллийн болон консулын төлөөллийн газарт олгосон газар	Шинжлэх ухаан технологийн сорилт, туршилт болон бусад төлөв байдлыг нийцүүлж өргөжүүлэх ажиглалтын талбай	Аймаг дундын орчин баар				Улсын тэжээлийн сангийн халдлагын талбай
72	73	74	75	76	77	78	79	80	81	82	83	84
552032.00	0.00	550172.00	0.00	1860.00	0.00	0.00	0.00	26.00	0.00	0.00	0.00	0.00
2172260.00	1361500.00	810760.00	0.00	0.00	74500.00	168.65	0.00	30.00	51860.00	0.00	0.00	0.00
818450.00	27521.00	780591.00	10338.00	0.00	53935.00	2673.04	0.00	0.00	8000.00	0.00	0.00	708.40
52790.00	0.00	0.00	46990.00	58000.00	79164.00	5887.49	0.00	3.00	26989.00	9520.00	0.00	0.00
3938009.30	3222048.00	0.00	592501.30	22460.00	315705.00	406.20	0.00	8250.63	0.00	0.00	0.00	0.00
0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	767.16	0.00	1.00	55073.80	0.00	0.00	0.00
0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	18.23	1.90	1457.20	0.00	0.00	0.00	0.00
656729.00	547249.00	0.00	104650.00	4830.00	299000.00	6372.10	0.00	6293.15	0.00	0.00	23400.00	900.00
1540517.00	869453.00	32840.00	638224.00	0.00	643931.40	4837.12	2.00	6072.02	124400.00	0.00	1070.00	0.00
189465.00	0.00	0.00	189465.00	0.00	0.00	89.03	0.00	14.00	0.00	0.00	0.00	0.00
581369.00	95510.00	485859.00	0.00	0.00	8950.00	195.51	0.00	72.00	68300.00	0.00	0.00	0.00
0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	140.28	1.80	0.40	0.00	0.00	0.00	0.00
267028.00	0.00	246198.00	9330.00	11500.00	0.00	3177.96	0.00	77.00	20282.00	0.00	0.00	0.00
3490894.00	1291927.00	2171737.00	27230.00	0.00	396100.00	7048.70	0.00	62.70	0.00	0.00	0.00	0.00
217014.00	115142.00	0.00	69017.00	32855.00	188000.00	1774.91	0.00	55.90	0.00	23000.00	0.00	0.00
176307.00	95616.00	0.00	80691.00	0.00	173822.00	1814.39	0.00	347.70	0.00	66279.00	0.00	500.00
1031020.00	671636.00	343788.00	15596.00	0.00	0.00	42817.48	0.00	3.60	24786.00	0.00	0.00	0.00
1692770.00	1136846.00	555924.00	0.00	0.00	141294.54	936.42	0.00	24.00	20900.00	9941.00	0.00	0.00
1663969.00	693030.00	884622.00	86317.00	0.00	155000.00	8467.05	0.00	60.00	105200.00	2200.00	0.00	0.00
1026704.00	188634.00	838070.00	0.00	0.00	441000.00	418.23	0.00	33.80	0.00	0.00	0.00	0.00
1000616.00	461727.00	369260.00	169629.00	0.00	141593.00	114.28	0.00	24.00	185623.00	0.00	0.00	0.00
72937.32	40564.00	28000.00	4373.32	0.00	0.00	7433.38	27.98	51.90	0.00	0.00	0.00	0.00
21140880.62	10918403.00	8097821.00	2044351.62	79305.00	3111954.94	124097.61	33.68	22960.00	691413.80	110940.00	24470.00	2108.40

Жил бүр сум, дүүргийн Засаг дарга 12-р сарын 15-ны дотор аймаг, нийслэлийн Засаг даргад, аймаг, нийслэлийн Засаг дарга дараа оны 01-р сарын 15-ны дотор Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тус тус гаргана.

Засгийн газрын 2003 оны 204 дүгээр  
тогтоолын 2 дугаар хавсралт

ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН 2017 ОНЫ ТАЙЛАН /га-гаар/  
Маягт ГТ-2

Д/д	Газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч	Д/д	Нийт	Үүнээс															
				Бүгд	Хөдөлмөрийн газар				Хөдөө аж ахуйн газар				Үүнээс						
					Бүгд	Бэлчээрийн газар	Хөдөлмөрийн талбай	Тариангийн газар, бүгд	Үр тарианы талбай	Төмс, хүнсний ногооны талбай	Тэжээлийн үргэлжлэх талбай	Тариан, жинс, жингэний талбай	Атарцсан газар	Хөдөө аж ахуйн барилга, байгууламжийн дэвсгэр, бүгд	Мал аж ахуйн зориулалттай газар	Өвж, хөвж, хаяржамны дэвсгэр газар	Үүнээс зориулалттай газар	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн газар	
А		Б	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15		
1	Өмчлөгч	а/Эр бүлийн хэрэгцэнд	57591.05	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00		
2		Б/аж ахуйн зориулалтаар	176.21	131.63	0.00	0.00	119.63	4.00	25.17	4.05	86.41	12.00	0.00	0.00	0.00	0.00	0.00		
1		а/мргэн	360062.35	323641.63	4991.62	26369.68	230024.86	17822.65	35970.76	9824.33	6407.12	770.20	61485.28	51471.33	48664.91	301.16	972.78		
2		б/төрийн байгууллага	4080913.46	40042.95	1362.00	4901.54	19985.80	17788.62	1369.53	561.00	266.65	12919.02	874.59	422.00	268.45	40.84	411.76		
3	Эзэмшигч	в/аж ахуйн нэгж	1964990.33	933662.45	14715.32	16888.33	842138.99	761829.16	14405.69	44315.03	21589.11	2987.80	56932.01	2121.50	1007.59	1695.55	5314.96		
4		Дүн	6405966.14	1297347.03	21068.94	48159.55	1092149.65	957440.42	51745.97	54700.37	28262.88	16677.02	119291.87	54014.83	49940.95	2037.54	63239.50		
5		а/мргэн	3953.00	3806.75	1031.00	2360.00	383.70	356.00	27.70	0.00	0.00	0.00	32.05	27.05	27.05	0.00	5.00		
6	Бусдын эзэмшил газрыг	б/төрийн байгууллага	155.16	10.46	0.00	0.00	10.00	0.00	10.00	0.00	0.00	0.00	0.46	0.00	0.00	0.00	0.46		
7	Монгол улсын	в/аж ахуйн нэгж	23751.27	3327.13	10.00	2655.00	652.13	648.83	3.30	0.00	0.00	0.00	10.00	0.00	0.00	0.00	10.00		
8		Дүн	27859.43	7144.34	1041.00	5015.00	1045.83	1004.83	41.00	0.00	0.00	0.00	42.51	27.05	27.05	0.00	15.46		
9		в/газрын иргэн болон харьяалгүй хүн	921.39	3.60	1.80	0.00	1.80	0.00	1.80	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00		
10	Ашиглагч	б/гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын хуулийн этгээд	302244.62	42399.54	1504.80	0.00	9635.03	6164.77	99.51	3100.00	270.75	0.00	31259.71	267.00	200.00	0.00	30992.71		
11		Дүн	303166.01	42403.14	1506.60	0.00	9636.83	6164.77	101.31	3100.00	270.75	0.00	31259.71	267.00	200.00	0.00	30992.71		
		Нийт дүн	6794758.83	1347026.13	23616.54	5374.55	1102951.93	964614.02	51913.45	57804.42	28620.04	16689.02	150594.09	54308.88	50168.00	2037.54	94247.67		

Маягт ГТ-2-ийн үргэлжлэл 1

д/д	Газрын														Үүнээс				
	Хот тосгон, бусад суурины газар																		
	Бүгд	Үүнээс								Үүнээс				Үүнээс					
Барилга, байгуулжигийн дэвсгэр газар, бүгд		Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмчлөн, эзэмшил, ашиглалтад байгаа барилга, байгуулжигийн доорх газар	Амрагт, рашаан сувиллын газар	Нийтийн эдлэрийн газар, бүгд	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил бус амрагт, зураглал, үнэмлэхгүй хэрэглэлийн газар	Гудамж, талбай, замын газар	Цэвэрлэх байгуулжигийн талбай	Оршуулгын газар	Хот хангалтын газар	Эзэмшил, ашиглалтад ортолгүй сул чөлөөтэй газар	Үндэрийн газар	Уурхайн дэвсгэр газар	Ашигт малтмал орборлох байгаа уурхайн талбай	Үндэрийн зориулалттай барилга, байгуулжигийн газар	Сурьшлын бүсийн барилга, байгуулжигийн газар	Газархоолчлын газар, бүгд	Газар, орон сууцны хашааны газар	Газар бүхий хэрэгцээний төмс, хүнсний ногооны талбай	
0	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30	31	32	33	34
1	57591.05	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	57591.05	57586.75	4.30
2	44.58	20.44	20.44	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	24.14	2.99	21.15
3	32971.06	10826.13	8015.71	2810.42	138.48	114.31	454.73	142.83	847.87	753.70	52532.35	882.66	223.53	134.40	73.63	15.50	20900.26	18444.34	2755.92
4	75660.31	17844.50	17014.30	830.20	55966.23	1234.75	454.73	142.83	847.87	753.70	52532.35	1105.98	550.47	316.48	203.36	30.63	193.13	175.64	17.49
5	206210.18	31411.27	19905.05	11506.23	262.29	99.70	1.22	57.35	96.84	7.10	0.08	33040.12	140948.23	130295.62	9060.04	1592.57	548.26	505.51	42.75
6	314841.55	60081.90	44935.06	15146.84	56367.00	1448.76	455.95	200.18	956.71	765.80	52539.60	35028.76	141722.23	130746.50	9337.03	163.870	21641.66	18825.50	2816.16
7	8.42	0.22	0.22	0.00	4.00	0.00	0.00	0.00	4.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	4.20	0.00	4.20
8	12.70	12.70	12.70	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
9	16997.14	9.26	2.76	6.50	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	332.58	16651.80	16586.80	39.00	26.00	3.50	0.00	3.50
10	17018.26	22.18	15.68	6.50	4.00	0.00	0.00	0.00	4.00	0.00	0.00	332.58	16651.80	16586.80	39.00	26.00	7.70	0.00	7.70
11	16.94	1.19	1.19	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	9.22	0.00	0.00	0.00	0.00	6.52	6.52	0.00
12	146745.76	1916.95	1311.91	605.04	7416.10	44.00	0.00	7372.10	0.00	0.00	0.00	2910.97	134495.74	125407.83	6840.38	2247.52	6.00	6.00	0.00
13	146762.69	1918.14	1313.10	605.04	7416.10	44.00	0.00	7372.10	0.00	0.00	0.00	2920.19	134495.74	125407.83	6840.38	2247.52	12.52	12.52	0.00
14	536258.14	62042.66	46284.28	15758.38	63787.10	1492.76	455.95	7572.28	960.71	765.80	52539.60	38281.53	292869.77	272741.13	16216.42	3912.22	79277.07	76427.76	2849.31

Маягт ГТ-2-ийн үргэлжлэл 2

д/д		Ангиллын																									
		Зам, шугам сүлжээний газар																									
		Бүгд	Автомобильн газар, бүгд	Улсын чанартай	Орон нутгийн чанартай	Аж ахуйн нэгж байгууллагын дотоодын зориулалтай	Авто тээврийн барилга, байгууламж, зогсоолын талбай	Төмөр замын далангийн талбай, хамгаалалтын зурвас газар	Үүнээс		Өгрөө, зөрлөгийн барилга, зөрлөгийн талбай	Үүнээс		Агаарын тээврийн газар, бүгд	Үүнээс		Нислэгийн аюулгүй байдлыг хамгаалах бүсийн газар	Үүнээс		Барилга байгууламж, төхөөрөмжийн газар	Шугам сүлжээний газар, бүгд	Үүнээс					Усан тээврийн газар, бүгд
Холбооны шугам, хөдөөтэй чөлөөтэй хэлээл талбай	Эрчим хүчний шугам, станцын эзлэх талбай								Ус, дуулаан дамжуулах хоолойн эзлэх талбай	Ус шахах, өргөх байгууламжийн доторхи газар		Ферээс хамгаалах далан, сувгийн эзлэх талбай	Холбооны шугам, хөдөөтэй чөлөөтэй хэлээл талбай		Эрчим хүчний шугам, станцын эзлэх талбай	Ус, дуулаан дамжуулах хоолойн эзлэх талбай		Ус шахах, өргөх байгууламжийн доторхи газар	Ферээс хамгаалах далан, сувгийн эзлэх талбай								
0	35	36	37	38	39	40	41	42	43	44	45	46	47	48	49	50	51	52	53								
1	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
2	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
3	128.70	66.02	16.64	0.00	20.71	28.66	0.00	0.00	0.00	0.00	36.00	0.00	26.68	0.56	25.97	0.15	0.01	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
4	83446.50	56013.91	10320.27	44949.10	635.25	109.30	1282.14	11211.04	71.10	2481.85	2424.29	57.56	13667.60	1691.16	11528.10	336.39	69.74	42.21	42.21	1.00							
5	64745.38	16786.56	2899.36	9578.78	3511.55	796.87	13405.29	12409.06	996.23	4405.00	4246.90	158.10	30148.52	9949.45	18131.55	1393.51	340.54	333.47	333.47	0.00							
